



# ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК-2020



Улаанбаатар хот  
2021 он

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, Бага тойруу - 44

Засгийн газрын III байр

Утас : 976-51-26-39-66

Цахим хуудас : [www.nso.mn](http://www.nso.mn)

И-мэйл : [international@nso.mn](mailto:international@nso.mn)

## АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	4
Инфографик.....	5
Үндсэн үзүүлэлт.....	6

## БҮЛЭГ 1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ .....8

1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, .....	9
1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн төрлөөр.....	13
1.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн байдлаар.....	66
1.4 Гэмт хэрэг үйлдэгч.....	70
1.5 Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, хуулийн этгээд.....	72
1.6 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт.....	77
1.7 Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүн.....	79

## БҮЛЭГ 2. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ .....81

2.1 Бүх шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг.....	82
2.2 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг.....	83
2.3 Шүүхээр ял шийтгүүлсэн хүн.....	86
2.4 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, хохирогч хүн, хуулийн этгээд.....	89
2.5 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг.....	93
2.6 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн захиргааны хэрэг.....	96
2.7 Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг.....	98
2.8 Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг.....	102
Дүгнэлт.....	104

## ХАВСРАЛТ

Үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт.....	111
Гэмт хэргийн статистикийн мэдээлэл цуглуулалт, тархаалт.....	112
Хуулийн тайлбар.....	113

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:**

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ХАБТХАЖ	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам
ИХШХШ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
МУ	Монгол Улс
ЭХ	Эрүүгийн хууль

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ****Хууль:**

1. Гэр бүлийн тухай хууль, 1999 он
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он
3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, 2015 он
4. Захиргааны ерөнхий хууль, 2015 он
5. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он
6. Иргэний хууль, 2002 он
7. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
8. Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он
9. Эрүүгийн хууль, 2017 он
10. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он

**Мэдээллийн эх үүсвэр:**

1. Цагдаагийн ерөнхий газрын бүртгэгдсэн гэмт хэргийн захиргааны болон албан ёсны статистикийн мэдээлэл
2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхээр шийдвэрлэсэн хэргийн захиргааны болон албан ёсны статистикийн мэдээлэл
3. Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан - [www.1212.mn](http://www.1212.mn) цахим хуудас



**23 064**

Бүртгэгдсэн гэмт хэрэг-Бүгд  
*Recorded crimes-Total*



**13 470**

Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг  
*Resolved criminal case by Court*



Гэмт хэргийн улмаас / *Due to crime*



Хохирсон хүн  
*Victims*

**23 050**



**30 283**



Нас барсан хүн  
*Died persons*

**670**



**619**



Гэмтсэн хүн  
*Injured persons*

**8 175**



**8 676**



Бүртгэгдсэн хэргийн улмаас учирсан хохирол, тэрбум төг

**254.9**

*Damage caused by recorded crime, billion togrogs*



Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирол, тэрбум төг

**228.4**

*Damage caused resolved criminal case by Court, billion togrogs*



Нөхөн төлүүлэлт, тэрбум төг

**82.1**

*Restituted damage, billion togrogs*



Нөхөн төлүүлэлт, тэрбум төг

**29.9**

*Restituted damage, billion togrogs*

Шүүхээр ял шийтгүүлсэн хүн / *Persons convicted by court*



Бүгд / *Total*

**13 391**



Эмэгтэй / *Female*

**1 505**



Өсвөр насны хүн  
*Teenager*

**228**

## 1.1 ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2019-2020 он

Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2019 он	2020 он	Өсөлт, бууралт (%)
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	31 524	23 064	↓26.8
Хүний амьд явах эрхийн эсрэг	тоо	636	382	↓39.9
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	тоо	8 265	7 405	↓10.4
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	тоо	115	189	↑64.3
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	тоо	610	505	↓17.2
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	тоо	3	5	↑66.7
Өмчлөх эрхийн эсрэг	тоо	18 341	12 061	↓34.2
Үндэсний аюулгүй байдлын эсрэг	тоо	29	1	↓96.6
Эдийн засгийн гэмт хэрэг	тоо	247	123	↓50.2
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	тоо	333	291	↓12.6
Хүрээлэн байгаа орчны эсрэг	тоо	489	622	↑27.2
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	тоо	1 276	985	↓22.8
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	тоо	172	80	↓53.5
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	тоо	341	211	↓38.1
Цэргийн албаны эсрэг	тоо	12	6	↓50.0
Эрүүл мэндийн эсрэг	тоо	39	22	↓43.6
Хүүхдийн эсрэг	тоо	31	17	↓45.2
Соёлын өвийн эсрэг	тоо	5	5	
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	тоо	30 782	23 050	↓25.1
Нас барсан хүн	тоо	930	670	↓28.0
Гэмтсэн хүн	тоо	8 727	8 175	↓6.3
Хохирогч байгууллага	тоо	85	66	↓22.4
Учирсан хохирол	тэрбум төг	162.3	254.9	↑57.1
Нөхөн төлүүлэлт	тэрбум төг	43.8	82.1	↑87.4
Гэмт хэрэгт холбогдсон яллагдагч	тоо	17 110	16 667	↓2.6
Бүх шатны шүүхийн эрүүгийн хэрэг	тоо	16 387	16 857	↑2.9
Бүх шатны шүүхийн иргэний хэрэг	тоо	47 873	58 176	↑21.5
Бүх шатны шүүхийн захиргааны хэрэг	тоо	3 771	3 709	↓1.6
Шүүхээр ял шийтгүүлсэн хүн	тоо	13 011	13 391	↑2.9
Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан	тоо	1 302	1 173	↓9.9
Ажлаас буруу шилжүүлсэн	тоо	21	65	↑3.1 дахин
Ажлаас үндэслэлгүй халагдсан	тоо	658	613	↓6.8
Цалин хөлсний маргаан	тоо	496	386	↓22.2
Хүний амьд явах эрхийн эсрэг	тоо	252	285	↑13.1
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	тоо	7 067	6 839	↓3.2
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	тоо	35	52	↑48.6
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	тоо	404	369	↓8.7
Өмчлөх эрхийн эсрэг	тоо	3 702	3 769	↑1.8
Үндэсний аюулгүй байдлын эсрэг	тоо	34	20	↓41.2
Эдийн засгийн гэмт хэрэг	тоо	68	48	↓29.4
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	тоо	213	249	↑16.9
Хүрээлэн байгаа орчны эсрэг	тоо	302	453	↑50.0
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	тоо	1 144	1 033	↓9.7
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	тоо	32	53	↑65.6
Авлигын гэмт хэрэг	тоо	50	118	↑2.4 дахин
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	тоо	95	144	↑51.6
Цэргийн албаны эсрэг	тоо	7	8	↑14.3
Эрүүл мэндийн эсрэг	тоо	4	11	↑2.8 дахин
Хүүхдийн эсрэг	тоо	6	6	
Соёлын өвийн эсрэг	тоо	1	2	↑2.0 дахин




# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

## 1.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 онд 23.1 мянга болж, өмнөх оноос 8460 (26.8%)-аар буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 6280 (34.2%), хулгайлах гэмт хэрэг 3868 (43.1%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 860 (10.4%), мал хулгайлах гэмт хэрэг 768 (42.5%), дээрэмдэх гэмт хэрэг 464 (53.5%), залилах гэмт хэрэг 418 (8.9%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 291 (22.8%), хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 254 (39.9%), хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 217 (57.6%), хөрөнгө завших гэмт хэрэг 203 (33.8%), золгүй явдлаар нас барсан хэрэг 188 (57.5%), нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 130 (38.1%), эдийн засгийн гэмт хэрэг 124 (50.2%), хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 105 (17.2%), гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 96 (46.4%)-гаар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Харин хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 133 (27.2%), цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 89 (2.6 дахин), хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 74 (64.3%)-өөр тус тус өссөн байна (Зураг 1.1.1).

Зураг 1.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, 2000-2020 он



Хүснэгт 1.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, ангиллаар, 2010-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг</b>	<b>19 197</b>	<b>22 089</b>	<b>25 362</b>	<b>27 318</b>	<b>27 757</b>	<b>27 167</b>	<b>32 259</b>	<b>36 220</b>	<b>31 524</b>	<b>23 064</b>
гэмт хэрэг, ангиллаар										
Хөнгөн	7 977	9 637	11 648	13 057	13 487	13 519	20 120	28 095	25 156	19 247
Хүндэвтэр	8 889	10 041	11 514	11 951	12 127	11 767	5 146	-	-	-
Хүнд	1 823	1 914	1 766	1 781	1 628	1 393	6 747	8 125	6 368	3 817
Онц хүнд	508	497	434	529	515	488	246	-	-	-


Тайлбар: Монгол Улсын Эрүүгийн хууль 2017 онд шинэчлэгдэн батлагдснаар, гэмт хэргийн ангилалд өөрчлөлт орсон болно.



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 83.5 хувийг хөнгөн, 16.5 хувийг хүнд хэрэг эзэлж, өмнөх оноос хөнгөн хэрэг 3.7 хувиар нэмэгдэж, хүнд хэрэг 3.7 хувиар буурчээ (Хүснэгт 1.1.1).

Улсын хэмжээгээр 2020 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 12.9 хувь нь Төвийн бүсэд, 11.8 хувь нь Хангайн бүсэд, 5.7 хувь нь Баруун бүсэд, 6.1 хувь нь Зүүн бүсэд, 63.4 хувь нь нийслэлд бүртгэгдсэн нь өмнөх оноос баруун бүс 0.6 хувиар, төвийн бүс 0.6 хувиар өсөж, харин хангайн бүс 0.2 хувиар, зүүн бүс 0.2 хувиар, Улаанбаатар хотод 0.8 хувиар буурсан байна.

Зураг 1.1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүсээр, дүүргээр, хувиар, 2020 он




Бүртгэгдсэн 23.1 мянган гэмт хэргийн 12.1 (52.3%) мянга нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 7.4 (32.1%) мянга нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 985 (4.3%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 505 (2.2%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг байна (Хүснэгт 1.1.2).

## Хүснэгт 1.1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, хэргийн төрлөөр, 2011-2020 он


Гэмт хэргийн төрлөөр	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>19 197</b>	<b>22 089</b>	<b>25 362</b>	<b>27 318</b>	<b>27 757</b>	<b>27 167</b>	<b>32 259</b>	<b>36 220</b>	<b>31 524</b>	<b>23 064</b>
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	624	609	592	565	404	443	721	714	636	382
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5 838	6 546	7 564	8 132	8 064	8 248	8 812	9 134	8 265	7 405
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	26	46	55	49	57	44	71	115	115	189
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	434	405	425	397	383	384	573	621	610	505
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	72	126	124	144	141	116	29	6	3	5
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	7 232	9 023	11 118	12 551	13 445	13 336	18 176	22 468	18 341	12 061
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	96	138	54	45	10	36	34	99	29	1
Эдийн засгийн гэмт хэрэг	115	185	234	426	520	227	287	242	247	123
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2 134	2 044	2 212	2 053	1 971	1 895	1 069	314	333	291
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	270	410	337	287	228	165	330	366	489	622
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1 870	1 999	2 148	2 143	2 010	1 783	1 525	1 231	1 276	985
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	280	332	278	249	269	268	262	237	341	211
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	96	100	104	118	106	91	125	196	172	80
Авлигын гэмт хэрэг	101	110	106	135	128	111	150	362	523	8
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	9	16	10	11	12	10	5	15	12	6
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	1	13	9	10	44	42	57	146
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	31	33	39	22
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	15	21	31	17
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	3	5	5
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	1	-	-

## Зураг 1.1.3 16, түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох гэмт хэрэг, 2020 он



16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 онд улсын дунджаар 108 болж, өмнөх оноос 40 (27.0%)-өөр буурсан байна. 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос буурахад Улаанбаатар хот 58 (28.0%), Хэнтий аймаг 61 (37.6%), Дорноговь аймаг 50 (42.7%), Дархан-Уул аймаг 35 (29.9%), Баянхонгор аймаг 31 (28.5%), Сэлэнгэ аймаг 31 (29.1%)-ээр буурсан нь голлон нөлөөлжээ. Улсын дунджаар 16, түүнээс дээш насны 10 000 хүн тутамд 2020 онд 108 гэмт хэрэг бүртгэгдсэн бол шүүхээр 63 эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн байна. Улаанбаатар хотод 16, түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 149 болж, улсын дундажаас 41 (38.0%)-ээр их байна (Зураг 1.1.3).

Зураг 1.1.4 Бүртгэгдсэн хэрэг, 2019-2020 оны сараар



Бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 оны бүх саруудад өмнөх оны саруудаас буурсан байна. Бүртгэгдсэн хэрэг өмнөх оноос 8460 (26.8%)-аар буурахад, 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 60.1%, 3 дугаар сард 39.6%, 10 дугаар сард 38.5%, 11дүгээр сард 36.1%-иар буурсан нь голлон нөлөөлжээ. Корона вирусны өвчлөл Монгол Улсад бүртгэгдэж, хөл хорио тогтоосон 3, 11, 12 саруудад бүртгэгдсэн хэрэг их буурчээ (Зураг 1.1.4).

Хүснэгт 1.1.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Үйлдэгдсэн хэрэг, гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	31 524	4 877	4 693	4 706	4 594	4 644	4 051	3 959	8 264	8 847	4 634	9 779
2020	23 064	3 470	3 519	3 383	3 291	3 408	2 997	2 996	5 838	6 621	3 410	7 195
дүнд эдлэх хувь												
2019	100.0	15.5	14.9	14.9	14.6	14.7	12.9	12.6	26.2	28.1	14.7	31.0
2020	100.0	15.0	15.3	14.7	14.3	14.8	13.0	13.0	25.3	28.7	14.8	31.2

2020 онд бүртгэгдсэн 23.1 мянган хэргийн 3470 (15.0%) нь даваа гарагт, 3519 (15.3%) нь мягмар гарагт, 3383 (14.7%) нь лхагва гарагт, 3291 (14.3%) нь пүрэв гарагт, 3408 (14.8%) нь баасан гарагт, 2997 (13.0%) нь бямба гарагт, 2996 (13.0%) нь ням гарагт үйлдэгджээ. Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх

оноос 8460-аар буурахад даваа гарагт үйлдэгдсэн гэмт хэрэг 1407 (28.8%)-гоор, лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 1323 (28.1%)-аар, пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 1303 (28.4%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Бүртгэгдсэн 23064 хэргийн 7195 (31.2%) нь 22-06 цагт, 6621 (28.7%) нь 14-19 цагт, 5838 (25.3%) нь 06-14 цагт, 3410 (14.8%) нь 19-22 цагт үйлдэгдсэн байна (Хүснэгт 1.1.3).

Хүснэгт 1.1.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Гэр, орон сууц	Гудамж, талбай	Олон нийтийн газар	Аж ахуйн нэгж, байгууллага	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад газар
2019	31 524	9 926	5 848	3 773	2 789	991	256	7 941
2020	23 064	7 817	4 464	2 145	2 115	289	149	6 085
дүнд эзлэх хувь								
2019	100.0	31.5	18.6	12.0	8.8	3.1	0.8	25.2
2020	100.0	33.9	19.4	9.3	9.2	1.3	0.6	26.4

Бүртгэгдсэн 23064 гэмт хэргийн 7817 (33.9%) нь гэр, орон сууцанд, 4464 (19.4%) нь гудамж, талбайд, 2145 (9.3%) нь олон нийтийн газар, 2115 (9.2%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, 289 (1.3%) нь төрийн байгууллагад, 149 (0.6%) нь төрийн бус байгууллагад, 6085 (26.4%) нь бусад газар үйлдэгдэж, өмнөх оноос 8460-аар буурахад гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 2109 (21.2%)-өөр, олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг 1628 (43.1%)-аар, гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 1384 (23.7%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.1.4).

## 1.2 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, гэмт хэргийн төрлөөр

### 1.2.1 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг

Хүснэгт 1.2.1.1 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг</b>	<b>624</b>	<b>609</b>	<b>592</b>	<b>565</b>	<b>404</b>	<b>443</b>	<b>721</b>	<b>714</b>	<b>636</b>	<b>382</b>
Хүнийг санаатай алах	262	231	204	211	204	174	189	192	197	192
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	21	14	21	27	32	24	45	53	59	59
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	314	324	323	288	144	206	470	459	377	122
Амиа хорлосон	51	46	48	43	24	26	36	45	50	21
Золгүй явдлаар нас барсан	263	278	275	245	120	180	434	414	327	101
Бусад	27	40	44	39	24	39	17	10	3	9

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2020 онд 382 бүртгэгдсэн нь өмнөх оноос 254 (39.9%)-өөр буурчээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг өмнөх оноос буурахад Улаанбаатар хотод өмнөх оноос 170-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг өмнөх оноос буурахад хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг 217 (57.6%)-гоор, хүнийг санаатайгаар алах хэрэг 75 (38.1%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.1.1).

Амиа хорлосон хэрэг 2020 онд 21 болж, өмнөх оноос 29 (58.0%)-өөр, золгүй явдлаар нас барах хэрэг 139 болж, 188 (57.5%)-аар буурсан байна. Золгүй явдлаар нас барах хэрэг 2010-2015 он хүртэл тасралтгүй буураад, 2016-2017 онд өсөөд, 2017 оноос хойш буурсан байна (Зураг 1.2.1.1).

Зураг 1.2.1.1 Амиа хорлосон болон золгүй явдлаар нас барсан хэрэг, 2011-2020 он



Улаанбаатар хотод 2020 онд бүртгэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 208 болж, өмнөх оноос 170 (45.0%)-аар буурахад Баянзүрх дүүрэг 58-аар, Баянгол дүүрэг 30-аар, Сонгинохайрхан дүүрэг 21-ээр, Хан-Уул дүүрэг 20-оор, Чингэлтэй дүүрэг 20-оор буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.1.2).


Хүснэгт 1.2.1.2 Улаанбаатар хотод бүртгэгдсэн Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, дүүргээр, 2019 -2020 он

Үзүүлэлт	Хүний амьд явах эрхийн эсрэг		Хүнийг санаатай алах		Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх		Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	
	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019
<b>Улаанбаатар хот</b>	<b>208</b>	<b>378</b>	<b>95</b>	<b>110</b>	<b>96</b>	<b>241</b>	<b>28</b>	<b>25</b>
Баянзүрх	54	112	27	25	27	80	8	6
Сонгинохайрхан	47	68	27	17	19	45	3	6
Баянгол	30	60	13	15	15	42	2	3
Хан-Уул	30	50	10	17	14	27	8	5
Сүхбаатар	16	34	5	9	5	24	3	1
Чингэлтэй	17	37	7	20	9	16	2	1
Багануур	4	4	2	2	1	-	1	2
Налайх	9	13	4	5	5	7	1	1
Багахангай	1	-	-	-	1	-	-	-

2020 онд бүртгэгдсэн нийт хүнийг санаатай алах гэмт хэргийн 95 (77.9%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 15 (15.6%)-аар буурсан байна. Улаанбаатар хотод бүртгэгдсэн санаатай алах гэмт хэрэг өмнөх оноос 15-аар буурахад Чингэлтэй дүүрэгт 13-аар, Хан-Уул дүүрэгт

7-гоор буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин Сонгино хайрхан дүүрэгт өмнөх оноос 10-аар өссөн байна (Хүснэгт 1.2.1.2).

Зураг 1.2.1.2 Хүнийг санаатай алах гэмт хэрэг, 1995-2020 он



Хүснэгт 1.2.1.3 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Үйлдэгдсэн хэрэг, гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	636	88	103	88	99	91	85	82	226	162	77	171
2020	382	51	53	54	57	66	55	46	108	99	63	112
дүнд эдлэх хувь												
2019	100.0	13.8	16.2	13.8	15.6	14.3	13.4	12.9	35.5	25.5	12.1	26.9
2020	100.0	13.4	13.9	14.1	14.9	17.3	14.4	12.0	28.3	25.9	16.5	29.3

2020 онд бүртгэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг 382 хэргийн 51 (13.4%) нь даваа гарагт, 53 (13.9%) нь мягмар гарагт, 54 (14.1%) нь лхагва гарагт, 57 (14.9%) нь пүрэв гарагт, 66 (17.3%) нь баасан гарагт, 55 (14.4%) нь бямба гарагт, 46 (12.0%) нь ням гарагт үйлдэгджээ.

Хүснэгт 1.2.1.4 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Гэр, орон сууц	Гудамж, талбай	Олон нийтийн газар	Аж ахуйн нэгж, байгууллага	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад газар
2019	636	347	89	17	45	11	9	118
2020	382	190	52	8	20	11	5	96
дүнд эзлэх хувь								
2019	100.0	54.6	14.0	2.7	7.1	1.7	1.4	18.6
2020	100.0	49.7	13.6	2.1	5.2	2.9	1.3	25.1

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 254-өөр буурахад мягмар гарагт үйлдэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 50 (48.5%)-аар, пүрэв гарагт үйлдэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг хэрэг 42 (42.4%)-оор, даваа гарагт үйлдэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг хэрэг 37 (42.0%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ. Бүртгэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг 382 хэргийн

112 (29.3%) нь 22-06 цагт, 108 (28.3%) нь 06-14 цагт, 63 (16.5%) нь 19-22 цагт, 99 (25.9%) нь 14-19 цагт үйлдэгдсэн байна (Хүснэгт 1.2.1.3).


Хүний амьд явах эрхийн эсрэг 382 гэмт хэргийн 190 (49.7%) нь гэр, орон сууцанд, 52 (13.6%) нь гудамж, талбайд, 8 (2.1%) нь олон нийтийн газар, 20 (5.2%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, 11 (2.9%) нь төрийн байгууллагад, 5 (1.3%) нь төрийн бус байгууллагад, 96 (25.1%) нь бусад газар үйлдэгдэж, өмнөх оноос 254-өөр буурахад гэр, орон сууцанд үйлдэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 157 (45.2%)-гоор, гудамж, талбайд үйлдэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 37 (41.6%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.1.4).

### 1.2.2 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, хохирол, нөхөн төлүүлэлт

Хүснэгт 1.2.2.1 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, хүйс, насны бүлгээр, 2019-2020 он

Он	Улсын дүн	дүнд эзлэх хувь							
		Эмэгтэй	7 хүртэлх	8-17	18-29	30-39	40-49	50-59	60, түүнээс дээш насны
2019	646	141	46	15	84	142	179	124	56
2020	400	85	19	19	59	84	107	83	29
2019	100.0	21.8	7.1	2.3	13.0	22.0	27.7	19.2	8.7
2020	100.0	21.3	4.8	4.8	14.8	21.0	26.8	20.8	7.3

Зураг 1.2.2.1 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, боловсролын түвшнээр, 2019-2020 он




Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2020 онд 400 болж өмнөх оноос

246 (38.1%)-гаар буурахад 40-49 насныхан 72 (40.2%)-оор, 30-39 насныхан 58 (40.8%)-аар, 50-59 насныхан 41(33.1%)-ээр буурсан нь голлон нөлөөлжээ. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч 400 хүний 85 (21.3%) нь эмэгтэй хүн, 38 (9.5%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна (Хүснэгт 1.2.2.1).

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч болсон 100 хүн тутмын 10 нь 18 хүртэлх насны хүүхдүүд, 27 нь 40-49 насныхан байна.

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч 400 хүний 177 (44.2%) нь бүрэн дунд боловсролтой, 46 (11.5%) нь дээд боловсролтой, 90 (22.5%) нь суурь боловсролтой, 35 (8.8%) нь бага боловсролтой, 20 (5.0%) нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 32 (8.0%) нь боловсролгүй байна. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 246-гаар буурахад бүрэн дунд боловсролтой хохирогч 140 (44.2%)-өөр, боловсролгүй 34 (51.5%)-өөр, бага боловсролтой 31(25.6%)-ээр буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.2.1).

Зураг 1.2.2.2 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, гэмт хэргийн төрлөөр, хувиар, 2019-2020 он



Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн 400 хохирогчийн 196 (49.0%) нь Хүнийг алах гэмт хэргийн хохирогч, 1 (0.2%) нь санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж, хүнийг алах гэмт хэргийн хохирогч, 131 (32.8%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэргийн хохирогч, 7 (1.8%) нь эх нь нярай хүүхдээ алах хэргийн хохирогч, 65 (16.2%) нь хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэргийн хохирогч байна. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 246-гаар буурахад хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэргийн хохирогч 244 (65.1%)-өөр, хүнийг алах гэмт хэргийн хохирогч 9 (4.4%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.2.2).



Хүснэгт 1.2.2.2 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он


Үзүүлэлтүүд	2019		2020	
	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт
	сая төгрөг			
<b>Улсын дүн</b>	<b>1 614.0</b>	<b>1 010.0</b>	<b>1 364.4</b>	<b>1 086.7</b>
Хүнийг алах	1 028.2	809.6	793.3	687.4
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	57.4	23.5	30.3	28.3
Эх нярай хүүхдээ алах	0.0	0.0	5.0	5.0
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	528.5	177.0	535.8	366.0

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 1.4 тэрбум төгрөг, хохирлын нөхөн төлүүлэлт 1.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 249.6 (15.5%) сая төгрөгөөр буурч, харин нөхөн төлүүлсэн хохирол 76.7 (7.6%) сая төгрөгөөр өссөн байна.

Учирсан хохирол өмнөх оноос буурахад хүнийг алах гэмт хэргийн улмаас учирсан хохирол 234.9 (22.8%) сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. 2020 онд хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 1.1 (79.6%) тэрбум төгрөгийг нөхөн төлүүлжээ (Хүснэгт 1.2.2.2).


### 1.2.3 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч

Зураг 1.2.3.1 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч, насны бүлгээр, 2019-2020 он




Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч 262 болж, өмнөх оноос 4-өөр буурахад 16-29 насныхан буурсан нь голлон нөлөөлжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 3 (1.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 39 (14.9%) нь эмэгтэйчүүд байна. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт холбогдсон нийт 262 яллагдагчийн 3 (1.2%) нь 16-17 насных, 60 (22.9%) нь 18-29 насных, 80 (30.5%) нь 30-39 насных, 71 (27.1%) нь 40-49 насных, 48 (18.3%) нь 50, түүнээс дээш насных байна (Зураг 1.2.3.1).

Зураг 1.2.3.2 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон бүрэн дунд боловсролтой яллагдагч 2020 онд 94 болж, өмнөх оноос 4 (4.1%)-өөр, суурь боловсролтой 58 болж, 11 (15.9%)-ээр, боловсролгүй 17 болж, 4 (19.0%)-өөр буурч, харин бага боловсролтой 35 болж, 9 (34.6%)-өөр, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 16 болж, 3 (23.1%)-аар, дээд боловсролтой 42 болж, 3 (7.7%)-аар өссөн байна. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн тоо өмнөх оноос буурахад суурь боловсролтой гэмт хэрэг үйлдэгч 11-ээр, бага боловсролтой 9-өөр буурсан нь голлон нөлөөлжээ. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн 262 яллагдагчийн 162 (61.8%) нь согтуугаар үйлджээ. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн 262 яллагдагчийн 134 (51.1%) нь эрхэлсэн ажилгүй иргэн байна (Зураг 1.2.3.2).

Зураг 1.2.3.3 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он




Хүний амьд явах эрхийн эсрэг 262 гэмт хэрэг үйлдэгчийн 211 (80.8%) нь хүнийг санаатайгаар алах гэмт хэрэг үйлдэгч, 14 (5.3%) нь санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж, хүнийг алах гэмт хэрэг үйлдэгч, 32 (12.2%) нь эх нь нярай хүүхдээ алах гэмт хэрэг үйлдэгч, 5933 (87.2%) нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах хэрэг үйлдэгч, 32 (12.2%) нь хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг үйлдэгч байна. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч өмнөх оноос 4-өөр буурахад хүнийг санаатайгаар алах гэмт хэрэг 5 (2.3%)-аар, хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг 2 (5.9%)-оор өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.3.3).

### 1.2.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг


Улсын хэмжээнд 2020 онд бүртгэгдсэн 23.1 мянган гэмт хэргийн 7.4 (32.1%) мянга нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг байгаа нь өмнөх оноос 860 (10.4%)-аар буурсан байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос буурахад Улаанбаатар хот 619 (11.9%), Дорноговь 73 (43.2%), Дархан-Уул аймаг 69 (26.0%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.2.1).

Зураг 1.2.2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2011-2020 он



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 7405 гэмт хэргийн 6373 (86.1%) нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг, 523 (7.1%) нь хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг, 301 (4.1%) нь хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг, 111 (1.5%) нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, 40 (0.5%) нь хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах гэмт хэрэг байна (Зураг 1.2.2.2).

Зураг 1.2.2.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 860-аар буурахад хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг 1018 (13.8%)-аар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гэмт хэрэг 96 (46.4%)-гаар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.2.2.).

Хүснэгт 1.2.2.1 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Үйлдэгдсэн хэрэг, гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	8 265	1 174	1 179	1 150	1 163	1 207	1 180	1 212	1 234	1 772	1 749	3 510
2020	7 405	1 034	1 072	996	1 017	1 065	1 086	1 135	1 085	1 736	1 551	3 033
		дүнд эдлэх хувь										
2019	100.0	14.2	14.3	13.9	14.1	14.6	14.3	14.7	14.9	21.4	21.2	42.5
2020	100.0	14.0	14.4	13.5	13.7	14.4	14.7	15.3	14.7	23.4	20.9	41.0

2020 онд бүртгэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 7405 хэргийн 1034 (14.0%) нь даваа гарагт, 1072 (14.4%) нь мягмар гарагт, 996 (13.5%) нь лхагва гарагт, 1017 (13.7%) нь пүрэв гарагт, 1065 (14.4%) нь баасан гарагт, 1086 (14.7%) нь бямба гарагт, 1135 (15.3%) нь ням гарагт үйлдэгджээ. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 860-аар буурахад лхагва гарагт үйлдэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 154 (13.4%)-өөр, пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 146 (12.6%)-гаар, баасан гарагт үйлдэгдсэн хэрэг 142 (11.8%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ. Бүртгэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын

эсрэг 7405 хэргийн 3033 (41.0%) нь 22-06 цагт, 1736 (23.4%) нь 14-19 цагт, 1551 (20.9%) нь 19-22 цагт, 1085 (14.7%) нь 06-14 цагт үйлдэгдсэн байна (Хүснэгт 1.2.2.1).


Хүснэгт 1.2.2.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Гэр, орон сууц	Гудамж, талбай	Олон нийтийн газар	Аж ахуйн нэгж, байгууллага	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад газар
2019	8 265	3 309	2 307	1 323	312	75	41	898
2020	7 405	3 264	2 034	852	266	41	24	924
дүнд эзлэх хувь								
2019	100.0	40.0	27.9	16.0	3.8	0.9	0.5	10.9
2020	100.0	44.1	27.5	11.5	3.6	0.5	0.3	12.5

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 7405 гэмт хэргийн 3264 (44.1%) нь гэр, орон сууцанд, 2034 (27.5%) нь гудамж, талбайд, 852 (11.5%) нь олон нийтийн газар, 266 (3.6%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, 41 (0.6%) нь төрийн байгууллагад, 24 (0.3%) нь төрийн бус байгууллагад, 924 (12.5%) нь бусад газар үйлдэгдэж, өмнөх оноос 860-аар буурахад гудамж, талбайд үйлдэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 273 (11.8%) аар, олон нийтийн газарт үйлдэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 471 (35.6%) ээр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.2.2).

Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 7405 гэмт хэргийн 111 (1.5%) нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг байгаа нь өмнөх оноос 1.0%-иар буурчээ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг өмнөх оноос 96-аар буурахад Улаанбаатар хотод 65-аар, Орхон аймагт 5-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 хэргийн 111 (9.8%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг) ээр зүйлчлэгдсэн байна (Зураг 1.2.2.3).

Зураг 1.2.2.3 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг ба Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэрэг, 2016-2020 он



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 100 хэрэг тутмын 10 хэрэгт эрүүгийн хэрэг (МУ-ын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг) үүсгэсэн байна.


2020 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн 111 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 65 (58.6%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 65 (50.0%-аар буурсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас 2020 онд 21 хүн амь насаа алдаж, МУ-ын ЭХ-ийн 10.1 (Хүнийг алах)-ээр зүйлчлэгдсэн нь өмнөх оноос 9 (75.0%-өөр өссөн байна.

Хүснэгт 1.2.2.3 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	985	134	146	132	147	151	125	150	144	225	253	363
2020	1 138	170	179	146	167	163	127	186	191	283	244	420
дүнд харьцуулсан хувь												
2019	100.0	13.6	14.8	13.4	14.9	15.3	12.7	15.3	14.6	22.8	25.7	36.9
2020	100.0	15.0	15.7	12.8	14.7	14.3	11.2	16.3	16.8	24.9	21.4	36.9

2020 онд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)–ээр зүйлчлэгдсэн 111 хэргийн 17 (15.3%) нь даваа гарагт, 22 (19.8%) нь мягмар гарагт, 9 (8.1%) нь лхагва гарагт, 21 (18.9%) нь пүрэв гарагт, 10 (9.0%) нь баасан гарагт, 12 (10.8%) нь бямба гарагт, 20 (18.0%) нь ням гарагт үйлдэгджээ. Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн 111 хэргийн 43 (38.7%) нь 22-06 цагт, 26 (23.4%) нь 19-22 цагт, 27 (24.3%) нь 14-19 цагт, 15 (13.5%) нь 06-14 цагт үйлдэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 62.1 хувийг 19 цагаас өглөөний 6 цагийн хооронд үйлдэгдсэн байна (Хүснэгт 1.2.2.3).

Зураг 1.2.2.4 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, үйлдэгдсэн цагаар, 2019-2020 он



Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 111 гэмт хэргийн 186 (89.9%) нь гэр, орон сууцанд, 10 (4.8%) нь гудамж, талбайд, 6 (2.9%) нь олон нийтийн газар, 1 (0.5%) нь төрийн байгууллагад, 1 (0.5%) нь төрийн бус байгууллагад, 3 (1.4%) нь бусад газар үйлдэгдсэн өмнөх оноос гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 3.0 хувиар, бусад газарт 1.0 хувиар буурч, харин гудамж, талбайд

үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2.9 хувиар, олон нийтийн газарт 1.0 хувиар өссөн байна. 2020 онд үйлдэгдсэн 111 хэргийн 57 (54.1%) хэргийг согтуугаар үйлджээ (Хүснэгт 1.2.2.4).

Хүснэгт 1.2.2.4 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2019-2020 он


Он	Улсын дүн	Гэр, орон сууц	Гудамж, талбай	Олон нийтийн газар	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад газар
2019	207	186	10	6	1	1	3
2020	111	104	1	-	1	-	5
дүнд эзлэх хувь							
2019	100.0	89.9	4.8	2.9	0.5	0.5	1.4
2020	100.0	93.7	0.9	-	0.9	-	4.5

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэрэг 2020 онд 111 болж, өмнөх оноос 96-аар буурахад Улаанбаатар хотод 65-аар, Хэнтий аймагт 10-аар буурсан нь голлон нөлөөлөв. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 111 хэргийн 65 (58.6%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 111 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэргийн 57 (51.4%) хэргийг согтуугаар, 110 (99.1%) хэргийг санаатайгаар үйлджээ.

### 1.2.3 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт


Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2020 онд 7798 болж, өмнөх оноос 744 (8.7%-өөр буурахад 18-29 насныхан 382 (13.7%-оор, 30-39 насныхан 136 (4.9%-гаар, 40-49 насныхан 166 (10.6%-гаар буурсан нь голлон нөлөөлжээ. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч 7798 хүний 2923 (37.5%) нь эмэгтэй хүн, 430 (5.5%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна (Зураг 1.2.3.1).

Зураг 1.2.3.1 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, насны бүлгээр, 2019-2020 он



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч 7798 хүний 3943 (50.6%) нь бүрэн дунд боловсролтой, 1856 (23.8%) нь дээд боловсролтой, 1046 (13.4%) нь суурь боловсролтой, 469 (6.0%) нь бага боловсролтой, 284 (3.6%) нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 200 (2.6%) нь боловсролгүй байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 744-өөр буурахад бүрэн дунд боловсролтой хохирогч 281 (6.7%)-ээр, суурь боловсролтой 260 (19.9%)-аар, дээд боловсролтой 152 (7.6%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.3.2).


Зураг 1.2.3.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 7798 хохирогчийн 308 (3.9%) нь хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэргийн хохирогч, 39 (0.5%) нь хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах гэмт хэргийн хохирогч, 555 (7.1%) нь хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэргийн хохирогч, 6724 (86.2%) нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах хэргийн хохирогч, 112 (1.4%) нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч, 60 (0.8%) нь бусад хэргийн хохирогч байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 744-өөр буурахад хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэргийн хохирогч 913 (12.0%)-аар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч 98 (46.7%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.3.3).



Зураг 1.2.3.3 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, гэмт хэргийн төрлөөр, хувиар, 2019-2020 он




Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 7.8 тэрбум төгрөг, хохирлын нөхөн төлүүлэлт 6.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 567.4 (7.9%) сая төгрөгөөр, харин нөхөн төлүүлсэн хохирол 615.4 (10.7%) сая төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирол өмнөх оноос 567.4 сая төгрөгөөр өсөхөд хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэргийн улмаас учирсан хохирол 504.8 (2.2 дахин) сая төгрөгөөр, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг 335.2 (54.9%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. 2020 онд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан 7.8 тэр бум төгрөгийн хохирлын 6.3 (81.4%) тэрбум төгрөгийг нөхөн төлүүлжээ (Хүснэгт 1.2.3.1).

Хүснэгт 1.2.3.1 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирол, нөхөн төлүүлэлт, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Үзүүлэлтүүд	2019		2020	
	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт
	сая төгрөг			
<b>Улсын дүн</b>	<b>7 227.9</b>	<b>5 728.7</b>	<b>7 795.3</b>	<b>6 344.1</b>
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	610.2	433.8	945.4	769.3
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	106.6	137.8	69.9	45.8
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	438.8	346.6	943.6	824.7
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	5 743.9	4 567.0	5 609.4	4 564.6
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	59.7	42.2	96.9	86.0
Бусад	268.7	201.3	130.0	53.7

## 1.2.4 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч

Зураг 1.2.4.1 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, гэмт хэргийн төрлөөр, хувиар, 2019-2020 он



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 6806 гэмт хэрэг үйлдэгчийн 259 (3.8%) нь хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг үйлдэгч, 18 (0.3%) нь хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах гэмт хэрэг үйлдэгч, 483 (7.1%) нь хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг үйлдэгч, 5933 (87.2%) нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах хэрэг үйлдэгч, 84 (1.2%) нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэгч, 29 (0.4%) нь бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгч байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч өмнөх оноос 134-өөр өсөхөд хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг 213 (78.9%)-гаар, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг 65 (33.5%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.4.1).

Хүснэгт 1.2.4.1 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, хүйс, насны бүлгээр, 2019-2020 он


Он	Улсын дүн	Эмэгтэй	Дүнд эзлэх хувь						
			14-15	16-17	18-29	30-39	40-49	50-59	60, түүнээс дээш насны
2019	6 672	763	114	133	2 450	2 200	1 190	488	97
2020	6 806	830	102	152	2 381	2 298	1 254	520	99
2019	100.0	11.4	1.7	2.0	36.7	33.0	17.8	7.3	1.5
2020	100.0	12.2	1.5	2.2	35.0	33.8	18.4	7.6	1.5

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч 6806 болж, өмнөх оноос 134 (1.9%)-өөр өсөхөд 30-39 насныхан 98 (4.5%)-аар, 40-49 насныхан 64 (5.4%)-өөр, 50-59 насныхан 32

(6.6%)-өөр өссөн нь голлон нөлөөлжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 254 (3.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 830 (12.2%) нь эмэгтэйчүүд байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдсон нийт 6806 яллагдагчийн 102 (1.5%) нь 14-15 насных, 152 (2.2%) нь 16-17 насных, 2381 (35.0%) нь 18-29 насных, 2298 (33.8%) нь 30-39 насных, 1254 (18.4%) нь 40-49 насных, 619 (9.1%) нь 50, түүнээс дээш насных байна (Хүснэгт 2.2.4.1).

Зураг 1.2.4.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт холбогдсон бүрэн дунд боловсролтой яллагдагч 2020 онд 3465 болж, өмнөх оноос 89 (2.6%)-өөр, дээд боловсролтой 1393 болж, 156 (12.6%)-гаар, боловсролгүй 221 болж, 5 (2.3%)-аар нэмэгдэж, харин бага боловсролтой 420 болж, 56 (11.8%)-гаар, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 244 болж, 11 (4.3%)-ээр, суурь боловсролтой 1063 болж, 49 (4.4%)-өөр буурсан байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн тоо өмнөх оноос өсөхөд бүрэн дунд боловсролтой гэмт хэрэг үйлдэгч 89 (2.6%)-өөр, дээд боловсролтой 156 (12.6%)-гаар өссөн нь голлон нөлөөлжээ. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн 6806 яллагдагчийн 3977 (58.4%) нь согтуугаар үйлджээ. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн 6806 яллагдагчийн 2971 (43.7%) нь эрхэлсэн ажилгүй иргэн байна (Зураг 1.2.4.2).

### 1.2.3 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2020 онд 12061 бүртгэгдэж, өмнөх оноос 6280 (34.2%)-аар буурахад хулгайлах хэрэг 3868 (43.1%)-аар, мал хулгайлах гэмт хэрэг 768 (42.5%)-аар, дээрэмдэх гэмт хэрэг 464 (53.5%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.3.1).

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 23.1 мянган хэргийн 12.1 (52.3%) мянга нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг өмнөх оноос буурахад Улаанбаатар хот 4271 (33.8%), Хэнтий аймаг 303 (53.4%), Хөвсгөл аймаг 164 (42.8%), Дархан-Уул аймаг 159 (35.8%), Орхон аймаг 152 (37.5%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ.

## Хүснэгт 1.2.3.1 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	7 232	9 023	11 118	12 551	13 445	13 336	18 176	22 468	18 341	12 061
Хулгайлах	5 276	6 266	7 884	8 424	9 169	9 065	12 222	13 424	8 968	5 100
Дээрэмдэх	536	552	620	686	537	474	1 233	1 497	868	404
Залилах	688	1 098	1 231	1 843	2 067	2 165	2 996	5 372	4 688	4 270
Хөрөнгө завших	202	269	326	297	333	322	369	562	601	398
Мал хулгайлах	1 169	1 376	1 435	1 434	1 180	805	901	1 096	1 809	1 041

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2020 онд нийт бүртгэгдсэн хэргийн 52.3%-ийг эзэлж, өмнөх оноос 5.9 хувиар буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдхүүнд ордог хулгайлах хэргийн эзлэх хувь 6.6, дээрэмдэх хэргийн эзлэх хувь 1.4-өөр буурсан нь голлон нөлөөлсөн байна (Зураг 1.2.3.1).

## Зураг 1.2.3.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2011-2020 он




Хулгайлах гэмт хэрэг 2020 онд 5100 болж, өмнөх оноос 3868 (43.1%)-аар буурахад Улаанбаатар хот 3056 (46.7%), Өвөрхангай 111 (55.8%), Орхон 99 (43.8%), Хэнтий 97 (52.7%), Хөвсгөл 88 (46.8%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 1.2.3.2 Хулгайлах гэмт хэрэг, 2011-2020 он



Зураг 1.2.3.3 Хулгайлах гэмт хэрэг, 2019-2020 оны сараар




Тухайн сард бүртгэгдсэн хулгайлах гэмт хэргийн тоо 2020 оны 1-3 саруудад буурч, 4 дүгээр сард өсч, харин 5-12 дугаар сард дахин буурсан байна (Зураг 1.2.3.3).

Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт хулгайлах гэмт хэргийн 3481 (68.3%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.


Улаанбаатар хотод бүртгэгдсэн хулгайлах гэмт хэрэг өмнөх оноос 2295 (39.7%)-аар буурахад Баянзүрх дүүрэг 933 (47.9%), Сүхбаатар дүүрэг 536 (53.7%), Сонгинохайрхан 527 (42.0%), Чингэлтэй дүүрэг 462 (52.0%)-оор буурсан нь голлон нөлөөлсөн байна (Зураг 1.2.3.4).

Зураг 1.2.3.4 Хулгайлах гэмт хэрэг, дүүргээр, 2019-2020 он



2020 онд мал хулгайлах 1041 хэрэг бүртгэгдэж, өмнөх оноос 768 (42.5%)-аар буурахад Хэнтий аймаг 163 (56.8%), Төв аймаг 99 (49.7), Дорнод аймаг 69 (51.9%), Булган аймаг 65 (55.6%), Улаанбаатар хот 65 (50.8%), Архангай аймаг 60 (37.0%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 1.2.3.5 Мал хулгайлах гэмт хэрэг, аймаг, нийслэлээр, 2019-2020 он




## Хүснэгт 1.2.3.2 Мал хулгайлах гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Гарагаар							Цагаар			
		Даваа	Мягма	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	1 809	303	269	273	301	235	207	221	264	271	231	1 043
2020	1 041	135	166	159	132	169	128	152	148	173	146	574
дүнд эзлэх хувь												
2019	100.0	16.7	14.9	15.1	16.6	13.0	11.4	12.2	14.6	15.0	12.8	57.7
2020	100.0	13.0	15.9	15.3	12.7	16.2	12.3	14.6	14.2	16.6	14.0	55.1

2020 онд 1041 мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдсэний 135 (13.0%) нь Даваа гарагт, 166 (15.9%) нь Мягмар гарагт, 159 (15.3%) нь Лхагва гарагт, 132 (12.7%) нь Пүрэв гарагт, 169 (16.2%) нь Баасан гарагт, 128 (12.3%) нь Бямба гарагт, 152 (14.6%) нь Ням гарагт үйлдэгджээ. 2020 онд бүртгэгдсэн мал хулгайлах 1041 хэргийн 574 (55.1%) хэргийг 22-06 цагийн хооронд, 148 (14.2%) хэргийг 06-14 цагийн хооронд, 173 (16.6%) хэргийг 14-19 цагийн хооронд, 146 (14.0%) хэргийг 19-22 цагийн хооронд үйлдсэн байна (Хүснэгт 1.2.3.2).

Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 230 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хулгайлах хэргийн 4.5 хувийг эзэлж, өмнөх оноос 37 (13.9%) -гоор буурсан байна (Зураг 1.2.3.6).

## Зураг 1.2.3.6 Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг, 2011-2020 он




## Хүснэгт 1.2.3.3 Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	267	45	45	43	31	40	29	34	50	42	29	146
2020	230	39	31	27	33	35	28	37	35	33	19	143
дүнд эзлэх хувь												
2019	100.0	16.9	16.9	16.1	11.6	15.0	10.9	12.7	18.7	15.7	10.9	54.7
2020	100.0	17.0	13.5	11.7	14.3	15.2	12.2	16.1	15.2	14.3	8.3	62.2


Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг өмнөх оноос 37-гоор буурахад мягмар гарагт 14 (31.1%)-өөр, лхагва гарагт 16 (37.2%) -гаар буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.3.3).

Зураг 1.2.3.7 Залилах болон хөрөнгө завших гэмт хэрэг, 2011-2020 он



Залилах гэмт хэрэг 2020 онд 4270 бүртгэгдэж, өмнөх оноос 418 (8.9%)-аар, хөрөнгө завших хэрэг 398 бүртгэгдсэн нь өмнөх оноос 203 (33.8%)-аар буурчээ (Зураг 2.2.3.8). Залилах хэрэг өмнөх оноос 418-аар буурахад Улаанбаатар хотод 238 (6.2%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Улаанбаатар хотод бүртгэгдсэн залилах гэмт хэрэг өмнөх оноос буурахад Сонгинохайрхан дүүрэгт 153 (32.2%)-аар, Хан-Уул дүүрэгт 143 (29.5%)-аар, Сүхбаатар дүүрэгт 127 (18.8%)-гоор, Чингэлтэй дүүрэгт 123 (22.0%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 1.2.3.8 Дээрэмдэх хэрэг, 1995-2020 он



Дээрэмдэх гэмт хэрэг 2020 онд 404 бүртгэгдэж, өмнөх оноос 464 (53.5%)-өөр буурчээ. Энэ төрлийн гэмт хэрэг өмнөх оноос буурахад Улаанбаатар хотод 379 (52.6%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ. Улаанбаатар хотод дээрэмдэх хэрэг буурахад Баянзүрх дүүрэгт 135 (59.2%), Баянгол дүүрэгт 92 (57.2%)-оор буурсан нь голлон нөлөөлсөн байна.




## 1.2.4 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, хохирол, нөхөн төлүүлэлт

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2020 онд 12112 болж, өмнөх оноос 6277 (34.1%)-гоор буурахад 18-29 насныхан 1629 (36.3%)-өөр, 30-39 насныхан 1795 (31.0%)-аар, 40-49 насныхан 1449 (34.7%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч 12112 хүний 5136 (42.4%) нь эмэгтэй хүн, 198 (1.6%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

Хүснэгт 1.2.4.1 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, хүйсээр, насны бүлгээр, 2019-2020 он

Он	Улсын дүн	дүнд эзлэх хувь							60, түүнээс дээш насны
		Эмэгтэй	18, хүртэлх	18-29	30-39	40-49	50-59		
2019	18 389	8 280	410	4 492	5 798	4 181	2 397	1 111	
2020	12 112	5 136	198	2 863	4 003	2 732	1 573	743	
2019	100.0	45.0	2.2	24.4	31.5	22.7	13.0	6.0	
2020	100.0	42.4	1.6	23.6	33.0	22.6	13.0	6.1	

Зураг 1.2.4.1 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч 12112 хүний 4760 (39.3%) нь бүрэн дунд боловсролтой, 5254 (43.4%) нь дээд боловсролтой, 1203 (9.9%) нь суурь боловсролтой, 350 (2.9%) нь бага боловсролтой, 457 (3.8%) нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 88 (0.7%)

нь боловсролгүй байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 6277-гоор буурахад бүрэн дунд боловсролтой хохирогч 2825 (37.2%)-аар, дээд боловсролтой 2167 (29.2%)-гоор, суурь боловсролтой 701 (36.8%)-ээр буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.4.1).

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 12112 хохирогчийн 5141 (42.4%) нь хулгайлах гэмт хэргийн хохирогч, 407 (3.4%) нь дээрэмдэх гэмт хэргийн хохирогч, 4273 (35.3%) нь залилах гэмт хэргийн хохирогч, 392 (3.2%) нь хөрөнгө завших гэмт хэргийн хохирогч, 502 (4.1%) нь алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэргийн хохирогч, 92 (0.8%) авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах хэргийн хохирогч, 230 (1.9%) нь эд хөрөнгө устгах, гэмтээх хэргийн хохирогч, 10 (0.1%) болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх хэргийн хохирогч, 1054 (8.7%) мал хулгайлах гэмт хэргийн хохирогч байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 6277-гоор буурахад хулгайлах гэмт хэргийн хохирогч 3863 (42.9%)-аар, мал хулгайлах гэмт хэргийн хохирогч 768 (42.2%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.4.2).

Зураг 1.2.4.2 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он



Хүснэгт 1.2.4.2 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирол, нөхөн төлүүлэлт,  
гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Үзүүлэлтүүд	2019		2020	
	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт
	сая төгрөг			
<b>Улсын дүн</b>	<b>134 616.7</b>	<b>25 229.4</b>	<b>125 487.9</b>	<b>63 283.5</b>
Хулгайлах	18 690.7	3 713.6	11 128.8	3 347.0
Дээрэмдэх	893.9	329.6	1 116.1	328.3
Залилах	89 532.2	13 232.6	65 747.4	25 175.0
Хөрөнгө завших	14 764.4	4 402.7	16 453.0	7 531.0
Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших	1 095.4	343.6	1 084.1	246.1
Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах	407.5	223.1	581.8	301.8
Эд хөрөнгө устгах, гэмтээх	1 403.1	244.6	552.9	212.5
Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх	160.5	9.1	24 087.7	24 039.9
Мал хулгайлах	7 543.5	2 726.6	4 390.9	1 996.4
Бусад	125.4	4.0	345.1	105.6

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 125.5 тэрбум төгрөг, хохирлын нөхөн төлүүлэлт 63.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 9.1 (6.8%) тэрбум төгрөгөөр буурч, харин нөхөн төлүүлсэн хохирол 38.1 (2.5 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирол өмнөх оноос 9.1 тэрбум төгрөгөөр буурахад хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирол 7.6 (40.5%) тэрбум төгрөгөөр, залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирол 23.8 (26.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. 2020 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан 125.5 тэрбум төгрөгийн хохирлын 63.3 (50.4%) тэрбум төгрөгийг нөхөн төлүүлжээ (Хүснэгт 1.2.4.2).

### 1.2.5 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч

Хүснэгт 1.2.5.1 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч, хүйс, насны бүлгээр,  
2019-2020 он


Он	Улсын дүн	Эмэгтэй	14-15	16-17	18-29	30-39	40-49	50-59	60, түүнээс дээш насны
2019	7 641	1 139	466	573	3 451	1 996	812	306	37
2020	7 036	1 725	293	359	3 112	2 019	929	267	57
2019	100.0	14.9	6.1	7.5	45.2	26.1	10.6	4.0	0.5
2020	100.0	24.5	4.2	5.1	44.2	28.7	13.2	3.8	0.8

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч 7036 болж, өмнөх оноос 605 (7.9%)-аар буурахад 18-29 насныхан 339 (9.8%)-өөр, 16-17 насныхан 214 (37.3%)-өөр, 14-15 насныхан 173 (37.1%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 652 (9.3%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 1725 (24.5%) нь эмэгтэйчүүд байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон нийт 7036 яллагдагчийн 293 (4.2%) нь 14-15 насных, 359 (5.1%) нь 16-17 насных, 3112 (44.2%) нь 18-29 насных, 2019 (28.7%) нь 30-39 насных, 929 (13.2%) нь 40-49 насных, 324 (4.6%) нь 50, түүнээс дээш насных байна (Хүснэгт 1.2.5.1).

Өмчлөх эрхийн эсрэг 7036 гэмт хэрэг үйлдэгчийн 2821 (40.1%) нь хулгайлах гэмт хэрэг үйлдэгч, 352 (5.0%) нь дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгч, 2269 (32.2%) нь залилах гэмт хэрэг үйлдэгч, 174 (2.5%) нь хөрөнгө завших гэмт хэрэг үйлдэгч, 261 (3.7%) нь алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг үйлдэгч, 68 (1.0%) нь авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч, явах гэмт хэрэг үйлдэгч, 144 (2.0%) нь эд хөрөнгө устгах, гэмтээх гэмт хэрэг үйлдэгч, 9 (0.1%) нь болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх гэмт хэрэг үйлдэгч, 933 (13.3%) мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгч, 5 (0.1%) бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгч байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч өмнөх оноос 605-аар буурахад хулгайлах гэмт хэрэг үйлдэгч 629 (18.2%)-өөр, мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгч 257 (21.6%)-гоор, дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгч 177 (33.5%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.5.1).


Зураг 1.2.5.1 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он



Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон бүрэн дунд боловсролтой яллагдагч 2020 онд 3133 болж, өмнөх оноос 190 (6.5%)-ээр, дээд боловсролтой 1008 болж, 56 (5.9%)-гаар, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 371 болж, 73 (24.5%)-аар нэмэгдэж, харин бага боловсролтой 783 болж, 203 (20.6%)-аар, 244 болж, боловсролгүй 368 болж, 197 (34.9%)-гоор, суурь боловсролтой 1373 болж, 524

(27.6%)-өөр буурсан байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн тоо өмнөх оноос буурахад суурь боловсролтой гэмт хэрэг үйлдэгч 524 (27.6%), бага боловсролтой 203 (20.6%), боловсролгүй 197 (34.9%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн 7036 яллагдагчийн 729 (10.4%) нь согтуугаар үйлджээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн 7036 яллагдагчийн 4367 (62.1%) нь эрхэлсэн ажилгүй иргэн байна (Зураг 1.2.5.2).


Зураг 1.2.5.2 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



#### 1.2.4 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг

Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 2020 онд 291 бүртгэгдэж, өмнөх оноос 42 (12.6 %) -оор буурахад Орхон аймагт 26 (81.3%) -гаар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.4.1).


Зураг 1.2.4.1 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 2011-2020 он



Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд зонхилох байр суурийг эзэлдэг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 2020


онд 202-д хүрч, өмнөх оноос 55 (21.4%)–аар буурахад Улаанбаатар хотод 23 (11.4%)–аар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.4.2).

Зураг 1.2.4.2 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг, 2011-2020 он



2020 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн 202 мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн 178 (88.1 %) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Зураг 1.2.4.3 Улаанбаатар хотод бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг, дүүргээр, 2019-2020 он



Улаанбаатар хотод бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг өмнөх оноос 23 (11.4%)–аар буурахад Чингэлтэй 13 (36.1%), Сүхбаатар 13 (38.2%), Баянгол дүүрэгт 10 (23.3%)–аар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.4.3).

Хүснэгт 1.2.4.1 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Үйлдэгдсэн хэрэг, гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	333	63	51	53	56	52	26	32	77	86	60	110
2020	291	52	51	46	42	51	30	19	46	84	64	97
дүнд эдлэх хувь												
2019	100.0	18.9	15.3	15.9	16.8	15.6	7.8	9.6	23.1	25.8	18.0	33.0
2020	100.0	17.9	17.5	15.8	14.4	17.5	10.3	6.5	15.8	28.9	22.0	33.3

2020 онд бүртгэгдсэн олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 291 хэргийн 52 (17.9%) нь даваа гарагт, 51 (17.5%) нь мягмар гарагт, 46 (15.8%) нь лхагва гарагт, 42 (14.4%) нь пүрэв гарагт, 51 (17.5%) нь баасан гарагт, 30 (10.3%) нь бямба гарагт, 19 (6.5%) нь ням гарагт үйлдэгджээ.

Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 42-оор буурахад пүрэв гарагт үйлдэгдсэн олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 14 (25.0%)-өөр, даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 11 (17.5%)-ээр, ням гарагт үйлдэгдсэн олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг хэрэг 13 (40.6%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ. Бүртгэгдсэн олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 291 хэргийн 46 (15.8%) нь 06-14 цагт, 84 (28.9%) нь 14-19 цагт, 64 (22.0%) нь 19-22 цагт, 97 (33.3%) нь 22-06 цагт үйлдэгдсэн байна (Хүснэгт 1.2.4.1).


Хүснэгт 1.2.4.2 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Гэр, орон сууц	Гудамж, талбай	Олон нийтийн газар	Аж ахуйн нэгж, байгууллага	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад газар
2019	333	81	114	49	9	1	1	78
2020	291	109	85	33	9	3	3	49
дүнд эзлэх хувь								
2019	100.0	24.3	34.2	14.7	2.7	0.3	0.3	23.4
2020	100.0	37.5	29.2	11.3	3.1	1.0	1.0	16.8

Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 291 гэмт хэргийн 109 (37.5%) нь гэр, орон сууцанд, 85 (29.2%) нь гудамж, талбайд, 33 (11.3%) нь олон нийтийн газар, 9 (3.1%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, 3 (1.0%) нь төрийн байгууллагад, 3 (1.0%) нь төрийн бус байгууллагад, 49 (16.8%) нь бусад газар үйлдэгдэж, өмнөх оноос 42-оор буурахад гудамж, талбайд үйлдэгдсэн олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 29 (25.4%)-өөр, бусад газарт үйлдэгдсэн олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 29 (37.2%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.4.2).


### 1.2.5 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт

Зураг 1.2.5.1 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирогч, насны бүлгээр, 2019-2020 он



Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2020 онд 46 болж, өмнөх оноос 26 (36.1%-гаар буурахад 30-39 насныхан 10 (41.7%-аар, 50-59 насныхан 9 (81.8%-өөр, 18 хүртэлх насных 8 (80.0%-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч 44 хүний 15 (34.1%) нь эмэгтэй хүн, 2 (4.35) нь 18 хүртэлх насны хүүхэд байна (Зураг 1.2.5.1).

Зураг 1.2.5.2 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирогч, боловсролын түвшнээр, 2019-2020 он





Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирогч 46 хүний 24 (52.2%) нь бүрэн дунд боловсролтой, 16 (34.8%) нь дээд боловсролтой, 3 (6.5%) нь суурь боловсролтой, 1 (2.2%) нь бага боловсролтой, 1 (2.2%) нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 1 (2.2%) нь боловсролгүй байна. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 26-гаар буурахад дээд боловсролтой хохирогч 14 (46.7%-өөр, суурь боловсролтой 7 (70.0%-гоор буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.5.2).

#### Хүснэгт 1.2.5.1 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирогч, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Үзүүлэлт	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>72</b>	<b>46</b>
Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших	6	1
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	12	2
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших	1	-
Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх	4	3
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	13	10
<b>Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах</b>	<b>33</b>	<b>24</b>

Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 26-гаар буурахад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн хохирогч 10 (83.3%-аар, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэргийн хохирогч 9 (27.3%-) өөр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.5.1).

#### Хүснэгт 1.2.5.2 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирол, нөхөн төлүүлэлт, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Үзүүлэлтүүд	2019		2020	
	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт
	сая төгрөг			
<b>Улсын дүн</b>	<b>139.0</b>	<b>120.5</b>	<b>130.2</b>	<b>45.6</b>
Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших	3.0	-	2.3	1.8
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	33.9	33.8	-	-
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших	0.6	0.6	-	-
Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх	60.9	60.9	-	-
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	12.2	10.9	12.4	12.0
<b>Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах</b>	<b>28.2</b>	<b>14.3</b>	<b>58.8</b>	<b>31.8</b>

Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 130.2 сая төгрөг, хохирлын нөхөн төлүүлэлт 45.6 сая төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 8.7 (6.3%) сая төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 74.9 (62.2%) сая төгрөгөөр буурсан байна.

2020 онд олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан 130.2 сая төгрөгийн хохирлын 45.6 (35.0%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ (Хүснэгт 1.2.5.2).

## 1.2.6 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч


Хүснэгт 1.2.6.1 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, хүйс, насны бүлгээр, 2019-2020 он

Он	Улсын дүн	Эмэгтэй	14-15	16-17	18-29	30-39	40-49	50-59	60, түүнээс дээш насны
2019	366	42	3	26	232	75	16	12	2
2020	352	26	1	14	223	77	25	9	3
2019	100.0	11.5	0.8	7.1	63.4	20.5	4.4	3.3	0.5
2020	100.0	7.4	0.3	4.0	63.4	21.9	7.1	2.6	0.9

Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч 352 болж, өмнөх оноос 14 (3.8%)-өөр буурахад 16-17 насныхан 12 (46.2%)-оор, 18-29 насныхан 9 (3.9%)-өөр, 40-49 насныхан 9 (56.3%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 15 (4.3%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 26 (7.4%) нь эмэгтэйчүүд байна.

Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэгт холбогдсон нийт 352 яллагдагчийн 15 (4.3%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 223 (63.4%) нь 18-29 насных, 77 (21.9%) нь 30-39 насных, 25 (7.1%) нь 40-49 насных, 12 (3.5%) нь 50, түүнээс дээш насных байна (Хүснэгт 1.2.6.1).

Зураг 1.2.6.1 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэгт холбогдсон бүрэн дунд боловсролтой яллагдагч 2020 онд 207 болж, өмнөх оноос 31 (13.0%)-ээр, суурь боловсролтой 29 болж, 6 (17.1%)-гаар, бага боловсролтой 1 болж, 4 (80.0%)-өөр буурч, харин дээд боловсролтой 94 болж, 18 (23.7%)-аар, боловсролгүй 4 болж, 3 (4.0 дахин)-аар, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 17 болж, 6 (54.5%)-гаар өссөн байна.

Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн тоо өмнөх оноос 14-өөр буурахад суурь боловсролтой гэмт хэрэг үйлдэгч 6, бүрэн дунд боловсролтой 31-ээр, буурсан нь голлон нөлөөлжээ. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн 352 яллагдагчийн 235 (66.8%) нь мансуурсан үедээ гэмт хэрэг үйлджээ. Олон нийтийн

аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн 352 яллагдагчийн 223 (63.4%) нь эрхэлсэн ажилгүй иргэн байна (Зураг 1.2.6.1).

#### Хүснэгт 1.2.6.2 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Үзүүлэлт	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>366</b>	<b>352</b>
Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших	15	13
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	316	269
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших	1	-
Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх	9	5
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	5	9
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	20	29
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах	-	2
Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах	-	1
Мөрийтэй тоглоом тоглох	-	24

Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг 352 гэмт хэрэг үйлдэгчийн 2821 (40.1%) нь хулгайлах гэмт хэрэг үйлдэгч, 352 (5.0%) нь дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгч, 269 (76.4%) нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдэгч, 29 (8.2%) нь олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг үйлдэгч, 24 (6.8%) нь мөрийтэй тоглоом тоглох гэмт хэрэг үйлдэгч, 13 (3.7%) нь галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших гэмт хэрэг үйлдэгч, 5 (1.4%) нь хууль бусаар эм био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох худалдах гэмт хэрэг үйлдэгч, 2 (0.6%) мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах гэмт хэрэг үйлдэгч, 1 (0.3%) мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэрэг үйлдэгч байна.


Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг үйлдэгч өмнөх оноос 14-өөр буурахад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдэгч 47 (14.9%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.6.2).

#### 1.2.5 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг


Улсын хэмжээгээр 2020 онд бүртгэгдсэн 23.1 мянган хэргийн 985 (4.3%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2020 онд 985 болж, өмнөх оноос 291 (22.8%)-ээр буурахад Улаанбаатар хот 164 (27.6%), Төв аймаг 43 (36.8%), Өмнө-говь аймаг 22 (35.5%), Дорноговь аймаг 18 (40.9%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин Завхан аймагт өмнөх оноос 16 (3.0 дахин)-аар өсчээ (Зураг 1.2.5.2).

Зураг 1.2.5.1 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 1995-2020 он




Зураг 1.2.5.2 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, аймгаар, 2019-2020 он




2020 онд бүртгэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 985 гэмт хэргийн 981 (99.6%) нь авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг, 4 (0.4%) нь авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах хэрэг байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 291-ээр буурахад авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг өмнөх оноос 282 (22.3%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.5.3).

Зураг 1.2.5.3 Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг, 2011-2020 он




2020 онд 21768 зам тээврийн осол бүртгэгдэж, өмнөх оноос 3534 (14.0%)-өөр буурахад Улаанбаатар хот 3361 (15.4%)-ээр, Ховд аймаг 52 (27.4%)-оор, Архангай аймаг 49 (32.7%)-өөр, Өвөрхангай аймаг 45 (29.4%)-аар, Дархан-Уул аймаг 44 (23.9%)-өөр, Дундговь 44 (37.0%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.5.4).

Зураг 1.2.5.4 Бүртгэгдсэн зам тээврийн осол ба Монгол Улсын Эрүүгийн хуулийн 27 дугаар бүлгээр зүйлчлэгдсэн хэрэг, 2011-2020 он



Бүртгэгдсэн 21.8 мянган зам тээврийн ослын 985 (4.5%) хэрэгт эрүүгийн хэрэг, 19692 (90.5%)-д нь зөрчлийн хэрэг үүсгэж, харин 1091 (5.0%) хэргийг татгалзуулсан байна. Эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэг өмнөх оноос 0.5 хувиар, зөрчлийн хэрэг 4.5 буурч, харин татгалзүүлсэн хэрэг 4.5 хувиар өссөн байна (Зураг 1.2.5.5).

Зураг 1.2.5.5 Зам тээврийн ослын улмаас үүссэн эрүүгийн хэрэг ба зөрчлийн хэрэг, хувиар, 2019-2020 он



Хүснэгт 1.2.5.1 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Үйлдэгдсэн хэрэг, гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	1 276	197	174	193	184	184	197	147	389	340	256	291
2020	985	157	131	139	135	146	150	127	252	293	189	251
дүнд эдлэх хувь												
2019	100.0	15.4	13.6	15.1	14.4	14.4	15.4	11.5	30.5	26.6	20.1	22.8
2020	100.0	15.9	13.3	14.1	13.7	14.8	15.2	12.9	25.6	29.7	19.2	25.5

2020 онд бүртгэгдсэн Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 985 хэргийн 157 (15.9%) нь даваа гарагт, 131 (13.3%) нь мягмар гарагт, 139 (14.1%) нь лхагва гарагт, 135 (13.7%) нь пүрэв гарагт, 146 (14.8%) нь баасан гарагт, 150 (15.2%) нь бямба гарагт, 127 (12.9%) нь ням гарагт үйлдэгджээ. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 291-ээр буурахад лхагва гарагт үйлдэгдсэн гэмт хэрэг 54 (28.0%)-өөр, пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 49 (26.6%)-өөр, бямба гарагт үйлдэгдсэн хэрэг 47 (23.9%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүртгэгдсэн 985 хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 251 (25.5%) нь 22-06 цагт, 293 (29.7%) нь 14-19 цагт, 189 (19.2%) нь 19-22 цагт, 252 (25.6%) нь 06-14 цагт үйлдэгдсэн байна (Хүснэгт 1.2.5.1).


Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 985 хэргийн 979 (99.4%) авто зам дээр үйлдэгджээ (Хүснэгт 1.2.5.2).

Хүснэгт 1.2.5.2 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, хэрэг үйлдэгдсэн замын харьяаллаар, 2019-2020 он

он	Авто зам дээр	Замын харьяаллаар					
		Олон улсын	Улсын	Орон нутгийн зам	Хотын зам	Хувийн зам	Аж ахуйн нэгж, байгууллагын зам
2019	1264	10	38	590	607	3	16
2020	979	11	22	502	433	4	7
		дүнд эзлэх хувь					
2019	100.0	0.8	3.0	46.7	48.0	0.2	1.3
2020	100.0	1.1	2.2	51.3	44.2	0.4	0.7

Авто зам дээр үйлдэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг хэрэг 979 болж, өмнөх оноос 285-аар буурахад орон нутгийн замд үйлдэгдсэн гэмт хэрэг 88 (14.9%)-аар, хотын замд үйлдэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын гэмт хэрэг 174 (28.7%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.5.2).

Зураг 1.2.5.6 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, хэрэг үйлдэгдсэн замын хэсгээр, 2019-2020 он




Авто зам дээр үйлдэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 979 болж, өмнөх оноос 285-аар буурахад явган хүний гарц дээр үйлдэгдсэн гэмт хэрэг 37 (26.6%)-гоор, уулзвар дээр үйлдэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын гэмт хэрэг 25 (19.2%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.5.6).

### 1.2.6 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2020 онд 1081 болж, өмнөх оноос 369 (25.4%)-өөр буурахад 18-29 насныхан 113 (32.7%)-аар, 30-39 насныхан 78 (25.7%)-аар, 40-49 насных 64 (25.6%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт

хэргийн улмаас хохирсон хүн 1081 хүний 437 (40.4%) эмэгтэй хүн, 127 (11.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна (Зураг 1.2.6.1).

Зураг 1.2.6.1 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүн, насны бүлгээр, 2019-2020 он



Хүснэгт 1.2.6.1 Зам тээврийн ослын улмаас нас барсан, гэмтсэн хүн, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	922	901	949	1 078	847	880	1 129	934	930	670
Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн	362	369	423	501	429	399	392	325	319	264
Зам тээврийн ослын улмаас нас барсан хүүхэд	40	41	37	48	54	50	55	45	49	55
Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн	8 100	8 436	9 797	11 281	11 287	11 257	10 513	9 283	8 727	8 175
Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн	1 093	1 077	1 282	1 460	1 382	1 247	1 135	998	1 083	784
Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүүхэд	162	183	197	233	225	224	186	143	149	101

Зам тээврийн ослын улмаас 2020 онд 264 хүн нас барсан нь өмнөх оноос 55 (17.2%)-аар буурахад Төв аймаг 10 (29.4%), Дорноговь 9 (69.2%), Булган 9 (64.3%), Хөвсгөл 7 (41.2%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ. Зам тээврийн ослын улмаас нас барсан 264 хүний 55 (20.8%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 82 (31.1%) нь эмэгтэй хүн байна.

Хүснэгт 1.2.6.2 Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн, хүйс, насны бүлгээр, 2019-2020 он


Он	Улсын дүн	Эмэгтэй	18, хүртэлх	18-29	30-39	40-49	50-59	60, түүнээс дээш насны
2019	319	99	49	61	62	66	63	18
2020	264	82	55	34	41	50	46	38
дүнд эзлэх хувь								
2019	100.0	31.0	15.4	19.1	19.4	20.7	19.7	5.6
2020	100.0	31.1	20.8	12.9	15.5	18.9	17.4	14.4

Зам тээврийн ослын улмаас нас барсан 264 хүний 55 (20.8%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 34 (12.9%) нь 18-29 насных, 41 (15.5%) нь 30-39 насных, 50 (18.9%) нь 40-49 насных, 84 (31.8%) нь 50, түүнээс



дээш насныхан байна. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүүхдийн тоо 55 болж, өмнөх оноос 6 (12.2%)-гаар өсөхөд Дорнод аймаг 4 (2.0 дахин), Сэлэнгэ аймаг 3 (2.5 дахин), Төв аймаг 3 (2.0 дахин)-аар өссөн нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.6.2).

Зураг 1.2.6.2 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын хэргийн улмаас хохирсон хүн, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын гэмт хэргийн хохирогч 1081 хүний 490 (45.3%) нь бүрэн дунд боловсролтой, 177 (16.4%) нь дээд боловсролтой, 176 (16.3%) нь суурь боловсролтой, 76 (7.0%) нь бага боловсролтой, 48 (4.4%) нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 114 (10.6%) нь боловсролгүй байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 369-өөр буурахад дээд боловсролтой хохирогч 75 (29.8%)-аар, бүрэн дунд боловсролтой хохирогч 167 (25.4%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.6.2).

Хүснэгт 1.2.6.3 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүн, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Үзүүлэлт	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>1 450</b>	<b>1 081</b>
Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1 434	1 076
Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах	12	5

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 369-өөр буурахад авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн хохирогч 363 (25.0%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.6.3).


### 1.2.7 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг гэмт үйлдэгч

Хүснэгт 1.2.7.1 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, хүйс, насны бүлгээр, 2019-2020 он

Он	Улсын дүн	Эмэгтэй	14-15	16-17	18-29	30-39	40-49	50-59	60, түүнээс дээш насны	
2019	973	148	1	6	338	314	172	100	42	
2020	854	142	4	5	305	247	180	73	40	
дүнд эзлэх хувь										
2019	100.0	15.2	0.1	0.6	34.7	32.3	17.7	10.3	4.3	
2020	100.0	16.6	0.5	0.6	35.7	28.9	21.1	8.5	4.7	

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдэгч 854 болж, өмнөх оноос 119 (12.2%)-өөр буурахад 30-39 насныхан 67 (21.3%)-гоор, 50-59 насныхан 27 (27.0%)-гоор, 18-29 насныхан 33 (9.8%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 9 (1.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 142 (16.6%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 1.2.7.1 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт холбогдсон бүрэн дунд боловсролтой яллагдагч 2020 онд 407 болж, өмнөх оноос 66 (14.0%)-гаар, суурь боловсролтой 135 болж, 19 (12.3%)-өөр, дээд боловсролтой 187 болж, 17 (8.3%)-гоор, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 52 болж, 16 (23.5%)-гаар, бага боловсролтой 51 болж, 5 (8.9%)-аар буурч, харин боловсролгүй 22 болж, 4 (22.2%)-өөр өссөн байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн тоо өмнөх оноос 119-өөр буурахад бүрэн дунд боловсролтой гэмт хэрэг үйлдэгч 66-

гаар буурсан нь голлон нөлөөлжээ. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдсэн 854 яллагдагчийн 203 (23.8%) нь согтуу үедээ гэмт хэрэг үйлджээ (Зураг 1.2.7.1).

Хүснэгт 1.2.7.2 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он


Үзүүлэлт	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>973</b>	<b>854</b>
<b>Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих</b>	<b>966</b>	<b>850</b>
<b>Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах</b>	<b>3</b>	<b>4</b>

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 854 гэмт хэрэг үйлдэгчийн 850 (99.5%) нь авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг үйлдэгч, 4 (0.5%) нь авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах гэмт хэрэг үйлдэгч байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг үйлдэгч өмнөх оноос 119-өөр буурахад авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг үйлдэгч 116 (12.0%)-гаар буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.7.2).

### 1.2.8 Эдийн засгийн гэмт хэрэг

Зураг 1.2.8.1 Эдийн засгийн гэмт хэрэг, 2011-2020 он



Эдийн засгийн гэмт хэрэг 2020 онд 123 болж, өмнөх оноос 124 (50.2%)-өөр буурахад Улаанбаатар хотод 60 (46.2%), Өмнөговь 23 (79.3%), Дорноговь 21 (60.0%)-ээр буурсан нь голлон нөлөөлжээ. Бүртгэгдсэн эдийн засгийн гэмт хэргийн 70 (56.9%) нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.


Зураг 1.2.8.2 Эдийн засгийн гэмт хэрэг, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он



2020 онд бүртгэгдсэн 123 эдийн засгийн гэмт хэргийн 26 (21.1%) нь татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг, 22 (17.9%) нь улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг, 27 (22.0%) нь мөнгө угаах гэмт хэрэг, 19 (15.4%) нь мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах гэмт хэрэг, 3 (2.4%) нь банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах гэмт хэрэг байна. Улсын хэмжээгээр 2020 онд бүртгэгдсэн эдийн засгийн 123 хэргийн 27 (22.0%) нь мөнгө угаах гэмт хэрэг бөгөөд өмнөх оноос 27 (2.0 дахин)-аар буурсан байна.

Мөнгө угаах гэмт хэрэг өмнөх оноос буурахад Улаанбаатар хот 17-гоор, Төв аймаг 5-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Эдийн засгийн гэмт хэрэг өмнөх оноос 124-өөр буурахад улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг 67 (75.3%)-гоор, мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах гэмт хэрэг 47 (71.2%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.8.2).

Зураг 1.2.8.3 Эдийн засгийн гэмт хэрэг, дүүргээр, 2019-2020 он



Улаанбаатар хотод эдийн засгийн гэмт хэрэг өмнөх оноос 60-аар буурахад Сүхбаатар дүүрэгт 16 (72.7%), Чингэлтэй дүүрэгт 21 (39.5%), Баянгол дүүрэгт 14 (46.7%)-өөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

#### Хүснэгт 1.2.8.1 Эдийн засгийн гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Үйлдэгдсэн хэрэг, гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	247	37	36	41	40	47	18	28	122	83	15	27
2020	123	24	20	22	24	14	11	8	72	42	5	4
дүнд эдлэх хувь												
2019	100.0	15.0	14.6	16.6	16.2	19.0	7.3	11.3	49.4	33.6	6.1	10.9
2020	100.0	19.5	16.3	17.9	19.5	11.4	8.9	6.5	58.5	34.1	4.1	3.3

2020 онд бүртгэгдсэн эдийн засгийн 123 хэргийн 24 (19.5%) нь даваа гарагт, 20 (16.3%) нь мягмар гарагт, 22 (17.9%) нь лхагва гарагт, 24 (19.5%) нь пүрэв гарагт, 14 (11.4%) нь баасан гарагт, 11 (8.9%) нь бямба гарагт, 8 (6.5%) нь ням гарагт үйлдэгджээ. Эдийн засгийн гэмт хэрэг өмнөх оноос 124-өөр буурахад баасан гарагт үйлдэгдсэн гэмт хэрэг 33 (70.2%)-аар, ням гарагт үйлдэгдсэн хэрэг 20 (71.4%)-оор, лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 19 (46.3%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.


Бүртгэгдсэн 123 эдийн засгийн гэмт хэргийн 72 (58.5%) нь 06-14 цагт, 42 (34.1%) нь 14-19 цагт, 5 (4.1%) нь 19-22 цагт, 4 (3.3%) нь 22-06 цагт үйлдэгдсэн байна (Хүснэгт 1.2.8.1).

#### Хүснэгт 1.2.8.2 Эдийн засгийн гэмт хэрэг, үйлдэгдсэн байршлаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Гэр, орон сууц	Гудамж, талбай	Олон нийтийн газар	Аж ахуйн нэгж, байгууллага	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад газар
2019	247	3	10	21	83	2	4	124
2020	123	6	3	3	41	28	6	36
дүнд эзлэх хувь								
2019	100.0	1.2	4.0	8.5	33.6	0.8	1.6	50.2
2020	100.0	4.9	2.4	2.4	33.3	22.8	4.9	29.3

2020 онд бүртгэгдсэн эдийн засгийн гэмт хэргийн 6 (4.9%) нь гэр, орон сууцанд, 3 (2.4%) нь гудамж, талбайд, 3 (2.4%) нь олон нийтийн газар, 41 (33.3%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, 28 (22.8%) нь төрийн байгууллагад, 6 (4.9%) нь төрийн бус байгууллагад, 36 (29.3%) нь бусад газар үйлдэгдэж, өмнөх оноос 124-өөр буурахад аж ахуйн нэгж байгууллагад үйлдэгдсэн эдийн засгийн гэмт хэрэг 42 (50.6%)-оор, бусад газарт үйлдэгдсэн эдийн засгийн гэмт хэрэг 88 (71.0%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.8.2).

Зураг 1.2.8.4 Улаанбаатар хотод бүртгэгдсэн мөнгө угаах гэмт хэрэг, 2019-2020 он



Улаанбаатар хотод бүртгэгдсэн мөнгө угаах гэмт хэрэг өмнөх оноос 17-гоор буурахад Сүхбаатар дүүрэгт 8 (80.0%), Чингэлтэй дүүрэгт 8 (80.0 %) -аар буурсан нь голлон нөлөөлсөн байна (Зураг 1.2.8.4).

Хүснэгт 1.2.8.3 Мөнгө угаах гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Гэр, орон сууц	Гудамж, талбай	Олон нийтийн газар	Аж ахуйн нэгж, байгууллага	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад газар
2019	54	3	3	7	22	4	1	14
2020	27	3	2	1	10	2	2	7
дүнд эзлэх хувь								
2019	100.0	5.6	5.6	13.0	40.7	7.4	1.9	25.9
2020	100.0	11.1	7.4	3.7	37.0	7.4	7.4	25.9

2020 онд бүртгэгдсэн мөнгө угаах гэмт хэргийн 3 (11.1%) нь гэр, орон сууцанд, 2 (7.4%) нь гудамж, талбайд, 1 (3.7%) нь олон нийтийн газар, 10 (37.0%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, 2 (7.4%) нь төрийн байгууллагад, 2 (7.4%) нь төрийн бус байгууллагад, 7 (25.9%) нь бусад газарт үйлдэгдэж, өмнөх оноос 27-гоор буурахад аж ахуйн нэгж байгууллагад үйлдэгдсэн мөнгө угаах гэмт хэрэг 12 (54.5%) -оор, бусад газарт үйлдэгдсэн мөнгө угаах гэмт хэрэг 7 (50.0%) -гоор, 6 (85.7%) -гаар буурсан нь голлон нөлөөлжээ. Аж ахуйн нэгж байгууллага дээр мөнгө угаах гэмт хэрэг хамгийн их бүртгэгддэг байна (Хүснэгт 1.2.8.3).

### 1.2.9 Эдийн засгийн гэмт хэргийн хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт

Эдийн засгийн гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2020 онд 44 болж, өмнөх оноос 63 (58.9%) -аар буурахад 18-29 насныхан 42 (87.5%) -оор, 30-39 насныхан 10 (37.0%) -аар буурсан нь голлон нөлөөлжээ. Эдийн засгийн гэмт хэргийн улмаас 2020 онд 6 төрийн байгууллага хохирсон нь өмнөх оноос 15 (71.4%) -аар буурчээ. Эдийн засгийн гэмт хэргийн улмаас хохирсон хүн 44 хүний 29 (65.9%)

эмэгтэй хүн байна. Харин 18 хүртэлх насны хүүхэд энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохироогүй байна (Хүснэгт 1.2.9.1).

Хүснэгт 1.2.9.1 Эдийн засгийн гэмт хэргийн улмаас хохирсон хүн, хүйсээр, насны бүлгээр, 2019-2020 он

Он	Улсын дүн	Эмэгтэй	7 хүртэлх	8-17	18-29	30-39	40-49	50-59	60, түүнээс дээш насны
2019	107	51	1	1	48	27	17	9	4
2020	44	29	0	0	6	17	14	5	2
дүнд эзлэх хувь									
2019	100.0	47.7	0.9	0.9	44.9	25.2	15.9	8.4	3.7
2020	100.0	65.9	0.0	0.0	13.6	38.6	31.8	11.4	4.5


Эдийн засгийн гэмт хэргийн хохирогч 44 хүний 6 (13.6%) нь 18-29 насных, 17 (38.6%) нь 30-39 насных, 14 (31.8%) нь 40-49 насных, 5 (11.4%) нь 50-59 насных, 2 (4.5%) нь 60 түүнээс дээш насны хүн байна. Эдийн засгийн гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 63-аар буурахад 18-29 насны хохирогч 42 (87.5%)-оор, 30-39 насны хохирогч 10 (37.0%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.9.1).

Эдийн засгийн гэмт хэргийн хохирогч 44 хүний 1 (2.3%) нь бүрэн дунд боловсролтой, 39 (88.6%) нь дээд боловсролтой, 4 (9.1%) нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн байна. Эдийн засгийн гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 63-аар буурахад дээд боловсролтой хохирогч 45-аар, бүрэн дунд боловсролтой хохирогч 15-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.9.1).

Зураг 1.2.9.1 Эдийн засгийн гэмт хэргийн улмаас хохирсон хүн, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Зураг 1.2.9.2 Эдийн засгийн гэмт хэргийн улмаас хохирсон хүн, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он



2020 онд бүртгэгдсэн 123 эдийн засгийн гэмт хэргийн 44 хохирогчийн 11 (25.0%) нь мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах гэмт хэргийн хохирогч, 10 (22.7%) нь мөнгө угаах гэмт хэргийн хохирогч, 4 (9.1%) нь улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн хохирогч, 2 (4.5%) нь татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хохирогч байна.

Хүснэгт 1.2.9.2 Эдийн засгийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Үзүүлэлтүүд	2019		2020	
	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт
	сая төгрөг			
<b>Улсын дүн</b>	<b>5 562.3</b>	<b>3 119.7</b>	<b>102 830.5</b>	<b>2 791.2</b>
Татвар төлөхөөс зайлсхийх	360.9	48.0	1 557.2	957.2
Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	512.3	500.0	200.6	194.2
Мөнгө угаах	2 559.8	2 558.1	99 347.7	5.9
Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах	11.7	10.1	1 624.8	1 600.6
Бусад	2 117.5	3.6	100.2	33.4

Эдийн засгийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 102.8 тэрбум төгрөг, хохирлын нөхөн төлүүлэлт 2.8 сая төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 97.3 (18.5 дахин) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 328.5 (10.5%) сая төгрөгөөр буурсан байна.

2020 онд эдийн засгийн гэмт хэргийн улмаас учирсан 102.8 тэрбум төгрөгийн хохирлын 2.8 (2.7%) тэрбум төгрөгийг нөхөн төлүүлжээ (Хүснэгт 1.2.9.2).



## 1.2.10 Эдийн засгийн гэмт хэрэг үйлдэгч

Хүснэгт 1.2.10.1 Эдийн засгийн гэмт хэрэг үйлдэгч, хүйс, насны бүлгээр, 2019-2020 он


Он	Улсын дүн	Эмэгтэй	Дүнд эзлэх хувь						60, түүнээс дээш насны
			14-15	16-17	18-29	30-39	40-49	50-59	
2019	104	18	0	0	27	37	24	12	4
2020	51	25	1	0	8	19	6	16	1
2019	100.0	17.3	0.0	0.0	26.0	35.6	23.1	11.5	3.8
2020	100.0	49.0	2.0	0.0	15.7	37.3	11.8	31.4	2.0

Эдийн засгийн гэмт хэрэг үйлдэгч 51 болж, өмнөх оноос 53 (51.0%)-аар буурахад 18-29 насныхан 19 (70.4%)-өөр, 30-39 насныхан 18 (48.6%)-аар, 40-49 насныхан 18 (75.0%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 1 (2.0%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 25 (49.0%) нь эмэгтэйчүүд байна.


Эдийн засгийн гэмт хэрэгт холбогдсон бүрэн дунд боловсролтой яллагдагч 2020 онд 19 болж, өмнөх оноос 32 (62.7%)-оор, дээд боловсролтой 19 болж, 11 (36.7%)-ээр, суурь боловсролтой 9 болж, 5 (35.7%)-аар, бага боловсролтой 1 болж, 5 (83.3%)-аар, боловсролгүй 2 болж, 1 (33.3%)-ээр буурсан байна.

Эдийн засгийн гэмт хэрэгт холбогдогчийн тоо өмнөх оноос 53-аар буурахад бүрэн дунд боловсролтой гэмт хэрэг үйлдэгч 32-оор, дээд боловсролтой 11-ээр буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.10.1).

Зураг 1.2.10.1 Эдийн засгийн гэмт хэрэг үйлдэгч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Зураг 1.2.10.2 Эдийн засгийн гэмт хэрэг үйлдэгч, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он



Эдийн засгийн гэмт хэрэг үйлдэгч 51 хүний 19 (37.3%) нь улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг үйлдэгч, 9 (17.6%) нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгч, 8 (15.7%) нь мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах гэмт хэрэг үйлдэгч байна. Эдийн засгийн гэмт хэрэг үйлдэгч өмнөх оноос 53-аар буурахад улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг үйлдэгч 45 (70.3%)-аар, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгч 23 (71.9%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.10.2).

### 1.2.11 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг


Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2020 онд 505 болж, өмнөх оноос 105 (17.2%)-аар буурахад Хөвсгөл аймаг 27 (64.3%)-гоор, Өвөрхангай аймаг 19 (70.4%)-өөр, Дорноговь аймаг 15 (55.6%)-аар, Сэлэнгэ аймаг 14 (43.8%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 1.2.11.1 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг ба, хүчиндэх гэмт хэрэг, 2011-2020 он




Энэ төрлийн хэргийн 79.4 хувийг эзэлж байгаа хүчиндэх хэрэг 2020 онд 401 бүртгэгдэж, өмнөх оноос 80 (16.6%)-аар буурсан байна ( Зураг 1.2.11.1).

Зураг 1.2.11.2 Хүчиндэх гэмт хэрэг, 1995-2020 он



Хүчиндэх гэмт хэрэг өмнөх оноос 80-аар буурахад Хөвсгөл аймагт 16 (55.2%)-гаар, Сэлэнгэ аймагт 11 (45.8%)-ээр, Увс аймагт 7 (36.8%)-гоор, Улаанбаатар хотод 11 (5.1%) -ээр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Бүртгэгдсэн 481 хүчиндэх гэмт хэргийн 203 (42.2%) нь Улаанбаатар хотод бүртгэгджээ (Зураг 1.2.11.2).

Зураг 1.2.11.3 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он



2020 онд бүртгэгдсэн 505 хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 401 (79.4%) нь хүчиндэх гэмт хэрэг, 18 (3.6%) нь улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг байна. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 105-аар буурахад хүчиндэх гэмт хэрэг өмнөх оноос 80 (16.6%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.11.3).

Хүснэгт 1.2.11.1 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн байдлаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Үйлдэгдсэн хэрэг, гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	610	115	80	99	72	95	85	64	139	142	78	251
2020	505	81	90	75	78	65	66	50	112	130	59	204
дүнд эдлэх хувь												
2019	100.0	18.9	13.1	16.2	11.8	15.6	13.9	10.5	22.8	23.3	12.8	41.1
2020	100.0	16.0	17.8	14.9	15.4	12.9	13.1	9.9	22.2	25.7	11.7	40.4

2020 онд бүртгэгдсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 505 хэргийн 81 (16.0%) нь даваа гарагт, 90 (17.8%) нь мягмар гарагт, 75 (14.9%) нь лхагва гарагт, 78 (15.4%) нь пүрэв гарагт, 65 (12.9%) нь баасан гарагт, 66 (13.1%) нь бямба гарагт, 50 (9.9%) нь ням гарагт үйлдэгджээ. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 105-аар буурахад даваа гарагт үйлдэгдсэн гэмт хэрэг 34 (29.6%)-өөр, баасан гарагт үйлдэгдсэн хэрэг 30 (31.6%)-аар, лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 24 (24.2%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүртгэгдсэн 505 хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 112 (22.2%) нь 06-14 цагт, 130 (25.7%) нь 14-19 цагт, 59 (11.7%) нь 19-22 цагт, 204 (40.4%) нь 22-06 цагт үйлдэгдсэн байна (Хүснэгт 1.2.11.1).

2020 онд бүртгэгдсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 505 гэмт хэргийн 334 (66.1%) нь гэр, орон сууцанд, 43 (8.5%) нь гудамж, талбайд, 28 (5.5%) нь олон нийтийн газар, 9 (1.8%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, 3 (0.6%) нь төрийн байгууллагад, 3 (0.6%) нь төрийн бус байгууллагад, 85 (16.8%) нь бусад газарт үйлдэгдэж, өмнөх оноос 105-аар буурахад гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 60 (15.2%)-аар, гудамж, талбайд үйлдэгдсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 22 (33.8%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.2.11.2).

Хүснэгт 1.2.11.2 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн газраар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Гэр, орон сууц	Гудамж, талбай	Олон нийтийн газар	Аж ахуйн нэгж, байгууллага	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад газар
2019	610	394	65	24	8	8	2	109
2020	505	334	43	28	9	3	3	85
дүнд эзлэх хувь								
2019	100.0	64.6	10.7	3.9	1.3	1.3	0.3	17.9
2020	100.0	66.1	8.5	5.5	1.8	0.6	0.6	16.8

1.2.12 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2020 онд 502 болж, өмнөх оноос 122 (19.6%)-оор буурахад 18-29 насныхан 47 (29.9%)-гоор, 30-39 насныхан 30


(51.7%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүн 502 хүний 398 (79.3%) нь эмэгтэй хүн, 333 (66.3%) нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна (Хүснэгт 1.2.12.1).

Хүснэгт 1.2.12.1 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, насны бүлэг, хүйсээр, 2019-2020 он


Он	Улсын дүн	Эмэгтэй	7 хүртэлх	8-17	18-29	30-39	40-49	50-59	60, түүнээс дээш насны
2019	624	608	29	330	157	58	33	10	7
2020	502	398	19	314	110	28	18	9	4
дүнд эзлэх хувь									
2019	100.0	97.4	4.6	52.9	25.2	9.3	5.3	1.6	1.1
2020	100.0	79.3	3.8	62.5	21.9	5.6	3.6	1.8	0.8

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч 502 хүний 104 (20.7%) нь бүрэн дунд боловсролтой, 43 (8.6%) нь дээд боловсролтой, 11 (9.1%) нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 55 (11.0%) нь боловсролгүй, 151 (30.1%) бага боловсролтой, 138 (27.5%) нь суурь боловсролтой хүн байна. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 122-оор буурахад суурь боловсролтой хохирогч 52 -оор, бүрэн дунд боловсролтой хохирогч 54-өөр буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.12.1).

Зураг 1.2.12.1 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Зураг 1.2.12.2 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он



2020 онд бүртгэгдсэн 505 хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 502 хохирогчийн 406 (80.9%) нь хүчиндэх гэмт хэргийн хохирогч, 18 (3.6%) нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн хохирогч байна.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 122-оор буурахад хүчиндэх гэмт хэргийн хохирогч 86 (17.5%)-гаар буурсан нь голлон нөлөөлсөн байна (Зураг 1.2.12.2).

Хүснэгт 1.2.12.2 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Үзүүлэлтүүд	2019		2020	
	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт	Учирсан хохирол	Нөхөн төлүүлэлт
	сая төгрөг			
<b>Улсын дүн</b>	<b>605.5</b>	<b>390.4</b>	<b>683.7</b>	<b>578.6</b>
Хүчиндэх гэмт хэрэг	562.1	369.6	623.6	528.0
Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг	11.0	2.0	9.5	4.3
Бусад	32.4	18.8	50.7	46.4

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 683.7 сая төгрөг, хохирлын нөхөн төлүүлэлт 578.6 сая төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 78.2 (12.9%) сая төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 188.2 (48.2%) сая төгрөгөөр өссөн байна.

2020 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан 683.7 сая төгрөгийн хохирлын 578.6 (84.6%) тэрбум төгрөгийг нөхөн төлүүлжээ (Хүснэгт 1.2.12.2).


1.2.12.3 Хүчиндэх гэмт хэргийн хохирогч, хүйс, насны бүлгээр, 2019-2020 он

Он	Улсын дүн	Эмэгтэй	7 хүртэлх	8-17	18-29	30-39	40-49	50-59	60, түүнээс дээш насны
2019	492	483	29	224	134	57	31	10	7
2020	406	398	15	233	103	26	16	9	4
дүнд эзлэх хувь									
2019	100.0	98.2	5.9	45.5	27.2	11.6	6.3	2.0	1.4
2020	100.0	98.0	3.7	57.4	25.4	6.4	3.9	2.2	1.0

Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2020 онд 406 болж, өмнөх оноос 86 (17.5%)-гаар буурахад 18-29 насныхан 31 (23.1%)-ээр, 30-39 насныхан 31 (54.4%)-ээр буурсан нь голлон нөлөөлжээ. Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хүн 406 хүний 398 (98.0%) нь эмэгтэй хүн, 248 (61.1%) нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна (Хүснэгт 1.2.12.3).

Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон 406 хүний 248 (61.1%) нь 18 хүртэлх насных, 103 (25.4%) нь 18-29 насных, 26 (6.4%) нь 30-39 насных, 16 (3.9%) нь 40-49 насных, 13 (3.2%) нь 50, түүнээс дээш насныхан байна (Хүснэгт 1.2.12.3).

Зураг 1.2.12.3 Хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхэд, насны бүлгээр, 2011-2020 он



2020 онд Монгол Улсын 18 хүртэлх насны 10 000 охидын 4 нь хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон байна. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийн тоо 2020 онд 248 болж, өмнөх оноос 5-аар буурахад 7 хүртэлх насны хохирогчийн тоо 14 (48.3%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.


### 1.2.13 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч 366 болж, өмнөх оноос 22 (5.7%)-оор буурахад 18-29 насныхан 25 (12.4%)-аар, 30-39 насныхан 13 (13.5%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 26 (7.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 6 (1.6%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 1.2.13.1 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, хүйс, насны бүлгээр, 2019-2020 он

Он	Улсын дүн	Эмэгтэй	Хүйс							60, түүнээс дээш насны
			14-15	16-17	18-29	30-39	40-49	50-59		
2019	388	4	9	12	202	96	51	11	7	
2020	366	6	13	13	177	83	50	22	8	
дүнд эзлэх хувь										
2019	100.0	1.0	2.3	3.1	52.1	24.7	13.1	2.8	1.8	
2020	100.0	1.6	3.6	3.6	48.4	22.7	13.7	6.0	2.2	

Зураг 1.2.13.1 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, боловсролын түвшнээр, 2019-2020 он




Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эсрэг гэмт хэрэгт холбогдсон бүрэн дунд боловсролтой яллагдагч 2020 онд 132 болж, өмнөх оноос 10 (7.0%)-аар, суурь боловсролтой 74 болж, 27 (26.7%)-гоор, боловсролгүй 35 болж, 6 (14.6%)-гаар, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 19 болж, 5 (20.8%)-аар буурч, харин дээд боловсролтой 46 болж, 18 (64.3%)-аар, бага боловсролтой 60 болж, 8 (15.4%)-аар өссөн байна.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн тоо өмнөх оноос 22-оор буурахад бүрэн дунд боловсролтой гэмт хэрэг үйлдэгч 10-аар, суурь боловсролтой гэмт хэрэг үйлдэгч 27-гоор буурсан нь голлон нөлөөлжээ. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн 366 яллагдагчийн 140 (38.3%) нь согтуу үедээ гэмт хэрэг үйлджээ (Зураг 1.2.13.1).



Зураг 1.2.13.2 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он



Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч 366 хүний 294 (80.3%) нь хүчиндэх гэмт хэрэг үйлдэгч, 14 (3.8%) нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгч байна.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч өмнөх оноос 22-оор буурахад хүчиндэх гэмт хэрэг үйлдэгч 20 (6.4%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.2.13.2).


### 1.3 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн байдлаар

Хүснэгт 1.3.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн байдлаар, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Согтуугаар үйлдсэн	4 312	5 063	6 406	6 686	5 907	5 520	4 012	3 289	4 371	4 855
Галт зэвсгээр үйлдсэн	39	41	42	39	38	33	44	39	36	40
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	420	534	418	1 076	1 356	1 449	1 286	1 069	985	1 138
Бүлэглэн гүйцэтгэсэн	2 066	2 427	2 447	2 683	2 274	1 635	1 829	1 714	1 805	1 482
Мансуурсан үедээ үйлдсэн	4	22	15	37	45	65	92	176	247	184
Зохион байгуулалттай бүлгээр	40	108	73	52	47	23	15	85	56	15

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2020 онд 4855 болж, өмнөх оноос 484 (11.1%)-өөр, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 1138 болж, 153 (15.5%)-аар, галт зэвсгээр үйлдсэн хэрэг 40 болж, 4 (11.1%)-өөр нэмэгдэж, харин бүлэглэн үйлдсэн хэрэг 1482 болж, 323 (17.9%)-аар, зохион байгуулалттай бүлгээр үйлдсэн хэрэг 41 (73.2%)-ээр, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 184 болж, 63 (25.5%)-аар буурсан байна (Хүснэгт 1.3.1).

Зураг 1.3.1 Согтуугаар үйлдсэн хэрэг, 2011-2020 он



2020 онд бүртгэгдсэн 23.1 мянган хэргийн 4.9 (21.1%) мянгыг согтуугаар үйлдэж, өмнөх оноос 484-өөр өсөхөд Улаанбаатар хот 530-аар, Төв аймаг 136-гаар өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 1.3.1).

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2020 онд 1138 болж, өмнөх оноос 153-аар өсөхөд Улаанбаатар хот 90, Хөвсгөл 33, Баянхонгор 27, Төв 22, Ховд 17, Сүхбаатар аймгуудад 16-гаар өссөн нь голлон нөлөөлөв.

Хүснэгт 1.3.1 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг, гэмт хэргийн төрлөөр, 2016-2020 он


Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>1 449</b>	<b>1 286</b>	<b>1 070</b>	<b>985</b>	<b>1 138</b>
Хүний амьд явах эрхийн эсрэг	17	13	12	13	22
Хүнийг алах	16	12	7	12	21
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	1	-	5	-	-
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1 356	1 089	998	913	1 043
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	-	198	210	207	111
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	33	166	47	54	61
Хүчиндэх	26	56	38	50	53
Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	-	-	2	-	1
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	-	-	5	2	2
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	1	-
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	-	7	2	4
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	38	4	-	-	-
Өмчлөх эрхийн гэмт хэрэг	4	10	-	-	-
Бусад	1	4	1	-	6

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн 1138 хэргийн 584 (51.3%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэрэг Баянзүрх (212), Сонгинохайрхан (116), Баянгол (72), Чингэлтэй (68) дүүргүүдэд хамгийн их бүртгэгджээ.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 хэргийн 1043 (91.6%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 61 (5.4%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 22 (1.9%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг байна (Хүснэгт 1.3.1).

Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2020 онд 811 болж, өмнөх оноос 257 (24.1%)-гоор буурахад Улаанбаатар хот 91 (14.0%)-ээр, Ховд аймаг 31 (60.8%)-ээр, Сэлэнгэ аймаг 28 (75.7%)-аар, Орхон 21 (56.8%)-ээр буурсан нь голлон нөлөөлсөн байна (Зураг 1.3.2).

Зураг 1.3.2 Хүүхэд оролцсон гэмт хэрэг, 1999-2020 он




Зураг 1.3.3 Мансуурсан үедээ үйлдсэн хэрэг, дүүргээр, 2017-2020 он



Мансуурсан үедээ үйлдэгдсэн хэрэг улсын хэмжээгээр 2020 онд 184 болж, өмнөх оноос 63 (25.5%)-аар буурахад Улаанбаатар хот 36 (17.7%)-гаар, Орхон аймаг 20 (87.0%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ. Мансуурсан үедээ үйлдэгдсэн 184 хэргийн 167 (90.8%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна (Зураг 1.3.3).


2020 онд улсын хэмжээгээр эмэгтэй хүн оролцсон хэрэг 3352 болж, өмнөх оноос 235 (7.5%)-аар өсөхөд Улаанбаатар хотод 498 (24.2%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Эмэгтэйчүүд оролцсон 3352 хэргийн 2557 (76.3%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна (Зураг 1.3.4).

Зураг 1.3.4 Эмэгтэйчүүд оролцсон хэрэг, дүүргээр, 2017-2020 он



2020 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн 23064 хэргийн 1482 (6.4%) нь бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг байна. Бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг өмнөх оноос 323 (17.9%)-аар буурахад Улаанбаатар хот 118 (14.8%)-аар, Хэнтий аймаг 40 (46.0%)-өөр, Сэлэнгэ 33 (36.7%)-аар, Орхон 29 (46.8%)-өөр, Дорноговь аймаг 28 (51.9%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Бүлэглэн гүйцэтгэсэн 1482 гэмт хэргийн 680 (45.9%) Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна (Зураг 1.3.5).

Зураг 1.3.5 Бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг, 2011-2020 он



## 1.4 ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧ


Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдын тоо 2020 онд 16.7 мянгад хүрч, өмнөх оноос 443 (2.6%)-аар буурахад Хэнтий аймаг 174 (28.0%)-өөр, Дархан-Уул аймаг 146 (23.7%)-гаар, Сэлэнгэ 132 (23.7%)-оор, Дорноговь 125 (32.8%)-аар, Орхон 90 (17.6%)-ээр өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 1.4.1).

Зураг 1.4.1 Яллагдагч ба Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, 2011-2020 он



2020 онд гэмт хэрэгт холбогдон, яллагдагчаар татагдсан 16.7 мянган хүний 2907 (17.4%) нь эмэгтэйчүүд, 990 (5.9%) нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдын 2092 (12.6%) нь өмнө нь ял шийтгэгдсэн хүн байна.

Зураг 1.4.2 Гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, насны бүлгээр, 2019-2020 он




Гэмт хэрэгт 2020 онд холбогдсон нийт 16667 яллагдагчийн 415 (2.5%) нь 14-15 насных, 575 (3.4%) нь 16-17 насных, 6506 (39.0%) нь 18-29 насных, 5133 (30.8%) нь 30-39 насных, 2767 (16.6%) нь 40-49 насных, 1271 (7.6%) нь 50, түүнээс дээш насныхан байна (Зураг 1.4.2).

## Хүснэгт 1.4.1 Гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, гэмт хэргийн төрлөөр, 2011-2020 он

Гэмт хэргийн төрлөөр	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>17 982</b>	<b>19 734</b>	<b>22 286</b>	<b>23 737</b>	<b>24 857</b>	<b>23 805</b>	<b>18 131</b>	<b>16 389</b>	<b>17 110</b>	<b>16 667</b>
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	360	335	343	327	316	296	270	266	266	262
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5 970	6 671	7 724	8 365	8 468	8 503	7 267	6 936	6 672	6 806
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	23	37	52	57	58	45	30	34	35	53
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	484	451	471	417	446	426	496	392	388	366
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	67	111	120	141	159	127	30	-	-	-
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	6 115	6 977	8 207	9 233	10 326	9 915	6 926	6 885	7 641	7 036
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	98	147	35	11	1	2	17	66	-	14
Эдийн засгийн гэмт хэрэг	129	185	188	182	186	144	102	58	104	51
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2 243	2 049	2 298	2 146	2 219	1 997	1 106	329	366	352
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	340	418	422	396	304	210	293	307	359	588
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1 738	1 887	2 015	2 048	1 956	1 728	1 273	903	973	854
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	248	284	264	254	278	280	215	119	226	150
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	93	104	95	106	99	90	63	54	27	35
Авлигын гэмт хэрэг	67	62	42	40	29	19	17	2	8	1
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	7	16	10	12	10	13	5	12	13	8
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	2	2	10	14	7	12	73
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	4	10	1	10
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	3	8	14	7
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	1	-	-
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	5	1

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын Яллагдагчийн мэдээлэл

## Зураг 1.4.3 Гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Гэмт хэрэг үйлдэгч 16667 хүний 6806 (40.8%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, 7036 (42.2%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч, 854 (5.1%) нь

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдэгч, 588 (3.5%) нь хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг үйлдэгч байна.


Гэмт хэрэг үйлдэгч өмнөх оноос 443 (2.6%)-аар буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч 605 (7.9%)-гаар, Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдэгч 119 (12.2%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.4.1).

Гэмт хэрэгт холбогдсон бүрэн дунд боловсролтой яллагдагч 2020 онд 7824 болж, өмнөх оноос 255 (3.4%)-аар, дээд боловсролтой 2981 болж, 189 (6.8%)-өөр, техникийн болон тусгай мэргэжлийн боловсролтой 758 болж, 66 (9.5%)-гаар өсөж, харин суурь боловсролтой 2947 болж, 553 (15.8%)-аар, бага боловсролтой 1445 болж, 225 (13.5%)-аар, боловсролгүй 712 болж, 175 (19.7%)-аар буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогчийн тоо өмнөх оноос 443-аар буурахад суурь боловсролтой гэмт хэрэг үйлдэгч 553-аар, бага боловсролтой 225-аар, боловсролгүй 175-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.4.3).

### 1.5 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдэлээс баттай хамгаалагдсан байх явдал юм. Нэг ч хүн хохирохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн улс орны туршлага хаана ч байхгүй бөгөөд байх ч боломжгүй. Гэхдээ л иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг тасралтгүй үр ашигтай явуулах, нэгэнт хохирсон тохиолдолд түүний хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн тогтолцоо, үйл ажиллагааны зохистой нөхцөлийг цогцоор нь бүрдүүлэх явдал аль ч улс орны хувьд нэн чухал байдаг.

Зураг 1.5.1 Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, 2011-2020 он



Гэмт хэргийн улмаас 2020 онд 23.1 мянган хүн, 66 хуулийн этгээд хохирч, өмнөх оноос хохирсон хүний тоо 7732-оор, хохирсон хуулийн этгээдийн тоо 19-өөр буурчээ. Хохирсон хүний тоо өмнөх оноос 7732 (25.1%)-оор буурахад Улаанбаатар хот 5172 (26.3%)-оор, Хэнтий аймаг 296 (36.0%)-гаар,

Дархан-Уул аймаг 283 (33.9%)-аар, Сэлэнгэ аймаг 208 (27.9%)-аар, Өвөрхангай аймаг 207 (33.5%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.5.1).

Гэмт хэргийн улмаас хохирсон 23.1 мянган хүний 1181 (5.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 9.4 (40.9%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 1.5.1 Хохирсон хүн, гэмт хэргийн төрлөөр, 2011-2020 он

Гэмт хэргийн төрлөөр	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>18 592</b>	<b>21 294</b>	<b>25 015</b>	<b>27 475</b>	<b>27 948</b>	<b>27 689</b>	<b>37 173</b>	<b>33 566</b>	<b>30 782</b>	<b>23 050</b>
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	589	560	557	546	402	462	769	647	646	400
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5 911	6 607	7 728	8 405	8 423	8 664	8 980	9 148	8 542	7 798
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	23	36	52	62	63	48	56	85	101	161
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	413	383	408	385	369	377	564	579	624	502
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	70	116	126	147	137	120	34	6	2	4
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	7 070	8 838	11 012	12 625	13 509	13 507	23 352	20 859	18 389	12 112
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	4	1	8	-	2	1	1	-	-
Эдийн засгийн гэмт хэрэг	31	67	95	220	217	143	105	118	107	44
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2 138	1 969	2 200	2 044	1 993	1 877	984	93	72	46
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	159	284	262	256	237	161	243	305	414	507
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1 950	2 122	2 293	2 439	2 232	1 995	1 728	1 375	1 450	1 081
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	163	234	203	219	248	234	205	173	230	181
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	57	52	59	81	76	70	77	82	75	49
Авлигын гэмт хэрэг	12	8	10	19	27	12	15	8	14	11
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	5	14	9	8	7	9	13	13	8	5
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	11	8	8	11	24	40	113
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	19	28	37	17
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	17	18	29	17
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	3	2	2
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	1	-	-

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын Хохирогч хүн, хуулийн этгээдийн мэдээ


2020 онд гэмт хэргийн улмаас хохирсон хүний 12112 (52.5%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 7798 (33.8%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 1081 (4.7%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч байна. Хохирсон хүн өмнөх оноос 7732-оор буурахад Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч 6277 (34.1%), Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч 744 (8.7%), Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч 369 (25.4%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.5.1).

Гэмт хэргийн улмаас хохирсон 23050 хүний 155 (0.7%) нь 7 хүртэлх насных, 1026 (4.5%) нь 8-17 насных, 5934 (25.7%) нь 18-29 насных, 7344 (31.9%) нь 30-39 насных, 4724 (20.5%) нь 40-49 насных, 3867 (16.8%) нь 50, түүнээс дээш насныхан байна. Хохирсон хүн өмнөх оноос 7732-оор буурахад 18-29 насныхан 2180 (26.9%), 30-39 насныхан 2111 (22.3%), 40-49 насныхан 1742 (26.9%), 50 түүнээс дээш насныхан 1282 (24.9%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.5.2).



2020 онд гэмт хэргийн улмаас хохирсон нийт хүний 7039 (30.5%) ажилгүй хүн байгаа нь өмнөх оноос 1883-аар буурчээ.

Зураг 1.5.2 Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, насны бүлгээр, хувиар, 2019-2020 он




Хүснэгт 1.5.2 Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд, гэмт хэргийн төрлөөр, 2011-2020 он

Гэмт хэргийн төрлөөр	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>1 178</b>	<b>1 270</b>	<b>1 426</b>	<b>1 576</b>	<b>1 477</b>	<b>1 340</b>	<b>1 758</b>	<b>1 688</b>	<b>1 598</b>	<b>1 181</b>
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	42	36	42	50	46	52	79	47	61	38
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	333	355	356	403	373	323	430	445	505	430
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	2	6	2	5	3	4	11	12	5
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	202	196	202	182	189	194	262	312	359	333
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	5	11	5	4	3	6	3	-	-	-
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	210	269	373	471	414	345	647	660	410	198
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эдийн засгийн гэмт хэрэг	-	-	7	2	1	-	-	1	2	-
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	175	156	187	163	163	145	85	5	10	2
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	-	-	1	-	-	2	2	1	-	-
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	208	244	246	297	282	268	244	192	206	155
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	-	-	1	-	-	1	-	1	1	-
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2	-	-	2	1	1	1	-	-	1
Авлигын гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	1	-	-	-	-	-	-	-	-
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	1	4	6	3
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	9	26	16
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-

Сүүлийн 11 жилийн байдлаар жилд дунджаар 1414 хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсон байна. Хохирсон 1181 хүүхдийн 38 (3.2%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 333


(28.2%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 198 (16.8%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 430 (36.4%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 155 (13.1%) нь ХАБТХАЖ-ын эсрэг гэмт хэргийн хохирогч байна.

Зураг 1.5.3 Гэмт хэргийн хохирогч, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Гэмт хэргийн хохирогч 23050 хүний 9639 (41.8%) нь бүрэн дунд боловсролтой, 8256 (35.8%) нь дээд боловсролтой, 868 (3.8%) нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 509 (2.2%) нь боловсролгүй, 1093 (4.7%) бага боловсролтой, 2685 (11.6%) нь суурь боловсролтой хүн байна. Гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 7732-оор буурахад бүрэн дунд боловсролтой хохирогч 3489-өөр, дээд боловсролтой хохирогч 2364-өөр, суурь боловсролтой хохирогч 1095 -аар буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 1.5.3).

Зураг 1.5.4 Гэмт хэргийн улмаас хохирсон хуулийн этгээд, 2011-2020 он



2020 онд хохирсон 66 хуулийн этгээдийн 47 (71.2%) нь төрийн, 1 (1.5%) нь төрийн бус, 18 (27.3%) нь хувийн байгууллага байгаа бөгөөд өмнөх оноос төрийн байгууллага 6.4 хувиар, төрийн бус байгууллага 3.2 хувиар буурч, харин хувийн байгууллага 9.6 хувиар өссөн байна (Зураг 1.5.4).

Хүснэгт 1.5.3 Хохирсон хуулийн этгээд, гэмт хэргийн төрлөөр, өмчийн хэлбэрээр,  
2019-2020 он

Гэмт хэргийн төрлөөр	2019				2020			
	Бүгд	Төрийн	Төрийн бус	Хувийн	Бүгд	Төрийн	Төрийн бус	Хувийн
<b>Улсын дүн</b>	<b>85</b>	<b>65</b>	<b>5</b>	<b>15</b>	<b>66</b>	<b>47</b>	<b>1</b>	<b>18</b>
<b>Өмчлөх эрхийн эсрэг</b>	<b>40</b>	<b>22</b>	<b>4</b>	<b>14</b>	<b>26</b>	<b>11</b>	<b>1</b>	<b>14</b>
Хулгайлах гэмт хэрэг	15	6	2	7	8	4	1	3
Залилах гэмт хэрэг	8	6	1	1	4	2	-	2
Эд хөрөнгө устгах, гэмтээх	2	-	-	2	-	-	-	-
Хөрөнгө завших	15	10	1	4	10	3	-	7
Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл	-	-	-	-	1	-	-	1
эд хөрөнгө, алдуул мал завших	-	-	-	-	-	-	-	-
Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх	-	-	-	-	2	2	-	-
Мал хулгайлах	-	-	-	-	1	-	-	1
<b>Эдийн засгийн гэмт хэрэг</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>-</b>	<b>-</b>
Татвар төлөхөөс зайлхийх	1	1	-	-	-	-	-	-
Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	17	17	-	-	5	5	-	-
Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл, хуурамчаар бэлтгэх, ашиглах	1	1	-	-	-	-	-	-
<b>Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших	-	-	-	-	-	-	-	-
Хууль бусаар эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх	3	3	-	-	-	-	-	-
<b>Авлигын гэмт хэрэг</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	1	1	-	-	-	-	-	-
<b>Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>10</b>	<b>9</b>	<b>-</b>	<b>1</b>
Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах	3	3	-	-	9	8	-	1
Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт хулгайлах, устгах, гэмтээх	-	-	-	-	1	1	-	-
<b>Хүрээлэн байгаа орчны эсрэг</b>	<b>13</b>	<b>13</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>18</b>	<b>18</b>	<b>-</b>	<b>-</b>
Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	1	1	-	-	2	2	-	-
Хууль бусаар ан агнах	7	7	-	-	7	7	-	-
Хууль бусаар мод бэлтгэх	-	-	-	-	4	4	-	-
Ой хээрийн түймэр тавих	1	1	-	-	-	-	-	-
Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх	1	1	-	-	4	4	-	-
<b>Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Цахим мэдээлэл хууль бусаар халдах	1	-	1	-	-	-	-	-
<b>Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Тушаал биелүүлэхгүй байх	1	-	-	1	-	-	-	-
<b>Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>
<b>Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>1</b>

2020 онд гэмт хэргийн улмаас хохирсон 66 хуулийн этгээдийн 26 (39.4%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн, 6 (9.1%) нь Эдийн засгийн гэмт хэргийн, 10 (15.2%) нь Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн, 18 (27.3%) нь Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн, 2 (3.0%) нь

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийн, 1 (1.5%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн, 3 (4.5%) нь Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн хохирогч байна (Хүснэгт 1.5.3).

## 1.6 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 254.9 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 82.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 92.6 (57.1%) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 38.3 (87.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирол өмнөх оноос 92.6 тэрбум төгрөгөөр өсөхөд Улаанбаатар хотод гэмт хэргийн улмаас учирсан хохирол 100.5 тэрбум төгрөгөөр, Өмнөговь аймагт 897.3 тэрбум төгрөгөөр, Завхан аймагт 536.9 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Харин нөхөн төлүүлсэн хохирол өмнөх оноос 38.3 тэрбум төгрөгөөр өсөхөд Улаанбаатар хотод 43.4 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна (Зураг 1.6.1).

Зураг 1.6.1 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, тэрбум төгрөг, 2011-2020 он



2020 онд гэмт хэргийн улмаас учирсан 254.9 тэрбум төгрөгийн хохирлын 125.5 (49.2%) тэрбум төгрөг нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн, 7.8 (3.1%) тэрбум төгрөг нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн, 5.0 (2.0%) тэрбум төгрөг нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн, 102.8 (40.3%) тэрбум төгрөг нь Эдийн засгийн гэмт хэргийн хохирол байна. Учирсан хохирол өмнөх оноос 92.6 тэрбум төгрөгөөр өсөхөд Эдийн засгийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол 97.3 тэрбум төгрөгөөр, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирол 3.8 тэр бум төгрөгөөр, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн хохирол 1.9 тэрбум төгрөгөөр, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1.8 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.6.1).

## Хүснэгт 1.6.1 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Гэмт хэргийн төрлөөр	Учирсан хохирол сая төг	
	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>162 346.6</b>	<b>254 937.3</b>
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	1 614.0	1 364.4
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7 227.9	7 795.3
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	605.5	683.7
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	168.7	636.9
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	5.0	1.0
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	36.4	22.4
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	3.0	10.5
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	134 616.7	125 487.9
Эдийн засгийн гэмт хэрэг	5 562.3	102 830.5
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	139.0	130.2
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	976.1	2 884.0
Авлигын гэмт хэрэг	166.7	58.5
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2 807.8	984.0
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	2 576.1	3 109.3
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	27.5	10.0
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	73.1	3 891.2
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	5 679.5	5 023.5
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	61.4	14.0

## Хүснэгт 1.6.2 Нөхөн төлүүлсэн хохирол, гэмт хэргийн төрлөөр, 2019 -2020 он

Гэмт хэргийн төрлөөр	Нөхөн төлүүлэлт сая төг	
	2019	2020
Улсын дүн	43 759.6	82 079.4
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	1 010.0	1 086.7
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5 728.7	6 344.1
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	390.4	578.6
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	119.2	149.4
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	3.3	15.4
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	25 229.4	63 283.5
Эдийн засгийн гэмт хэрэг	3 119.7	2 791.2
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	120.5	45.6
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	138.2	1 719.8
Авлигын гэмт хэрэг	5.0	34.8
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1 499.4	275.1
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	2 027.8	1 805.2
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	27.5	-
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	41.2	39.7
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	4 219.3	3 896.2
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	80.0	14.0

2020 онд нөхөн төлүүлсэн нийт 82.1 тэрбум төгрөгийн хохирлын 63.3 (77.1%) тэрбум төгрөг нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн, 6.3 (7.7%) тэрбум төгрөг нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн, 3.9 (4.7%) тэрбум төгрөг нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн, 2.8 (3.4%) тэрбум төгрөг нь Эдийн засгийн гэмт хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт байна. Нөхөн төлүүлэлт өмнөх оноос 38.3 тэрбум төгрөгөөр өсөхөд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт 38.1 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.6.2).

### 1.7 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ГЭМТСЭН, НАС БАРСАН ХҮН

Хүснэгт 1.7.1 Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн, нас барсан хүн, хүйсээр, насны бүлгээр, 2019-2020 он

Үзүүлэлт	Хохирсон нийт хүн		Гэмтсэн хүн		Нас барсан хүн	
	2019 он	2020 он	2019 он	2020 он	2019 он	2020 он
7 хүртэлх	208	155	87	65	74	63
8-17	1 390	1 026	537	451	37	36
18-29	8 114	5 934	2 716	2 480	140	90
30-39	9 455	7 344	2 726	2 635	187	131
40-49	6 466	4 724	1 575	1 443	243	153
50-59	3 604	2 707	781	815	178	126
60-69	1 182	931	214	235	54	46
70, ба түүнээс дээш	363	229	91	51	17	25
<b>Улсын дүн</b>	<b>30 782</b>	<b>23 050</b>	<b>8 727</b>	<b>8 175</b>	<b>930</b>	<b>670</b>
Эмэгтэй	13 205	9 421	3 394	3 127	244	170

Гэмт хэргийн улмаас 2020 онд 23050 хүн хохирсны 670 (2.9%) нь нас барж, 8175 (35.5%) нь гэмтсэн байна. Хохирсон хүн өмнөх оноос 7732 (25.1%)-оор, нас барсан хүн 260 (28.0%)-аар, гэмтсэн хүн 552 (6.3%)-оор тус тус буурчээ.

Нас барсан хүн өмнөх оноос 260-аар буурахад Улаанбаатар хотод гэмт хэргийн улмаас нас барсан хүн 153 (35.0%)-аар, Төв аймагт нас барсан хүн 31 (43.1%)-ээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо өмнөх оноос 552-оор буурахад Улаанбаатар хотод гэмт хэргээс гэмтсэн хүний тоо 278 (5.5%)-аар, Дорноговь аймагт 90 (40.5%)-ээр, Дархан-Уул аймагт 80 (26.8%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Гэмт хэргийн улмаас 2020 онд нас барсан 670 хүний 63 (9.4%) нь 7 хүртэлх насных, 36 (5.4%) нь 8-17 насных, 90 (13.4%) 18-29 насных, 131 (19.6%) нь 30-39 насных, 153 (22.8%) нь 40-49 насных, 126 (18.8%) нь 50-59 насных, 71 (10.6%) нь 60, ба түүнээс дээш насныхан байна.

Гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо өмнөх оноос буурахад 40-49 насныхан 90-ээр, 18-29 насныхан 50-аар, 30-39 насныхан 56-гаар, 50-59 насныхан 52-оор буурсан нь голлон нөлөөлжээ.

Нас барсан нийт хүний 170 (25.4%) нь эмэгтэйчүүд, 99 (14.8%) 18 хүртэлх насны хүүхдүүд байна. 2020 онд гэмт хэргийн улмаас 99 хүүхэд нас барж, өмнөх оноос 12 (10.8%) –оор, 516 хүүхэд гэмтэж, өмнөх оноос 108 (17.3%)-аар буурсан байна (Хүснэгт 1.7.1).

Гэмт хэргийн улмаас гэмтсэн 8175 хүний 65 (0.8%) нь 7 хүртэлх насных, 451 (5.5%) нь 8-17 насных, 2480 (30.3%) 18-29 насных, 2635 (32.2%) нь 30-39 насных, 1443 (17.7%) нь 40-49 насных, 815 (10.0%) нь 50-59 насных, 286 (3.5%) нь 60, ба түүнээс дээш насныхан байна. Гэмт хэргийн улмаас гэмтсэн


хүний тоо өмнөх оноос 552-оор буурахад 18-29 насных 236-гаар, 40-49 насных 132-оор буурсан нь голлон нөлөөлжээ. Гэмт хэргийн улмаас гэмтсэн 8175 хүний 3127 (38.3%) нь эмэгтэйчүүд, 516 (6.3%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна (Хүснэгт 1.7.1).

Гэмт хэргийн улмаас 2020 онд 670 хүн нас барсны 371 (55.4%) нь хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас, 264 (39.4%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ. Сүүлийн 11 жилд жил тутам дундажаар 950 орчим хүн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан байна (Хүснэгт 1.7.2).

Хүснэгт 1.7.2 Гэмт хэргийн улмаас нас барсан хүн, гэмт хэргийн төрлөөр, 2011-2020 он

Гэмт хэргийн төрлөөр	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>922</b>	<b>901</b>	<b>949</b>	<b>1 078</b>	<b>847</b>	<b>880</b>	<b>1 129</b>	<b>934</b>	<b>930</b>	<b>670</b>
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	497	456	444	493	350	421	685	558	576	371
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	10	16	17	13	11	7	22	38	13	19
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	2	4	-	4	7	3	2	3	1
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	15	33	36	32	33	28	7	-	-	-
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	5	6	8	8	3	-	-	-	-	-
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эдийн засгийн гэмт хэрэг	-	-	-	2	-	1	-	-	-	-
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	29	18	14	22	14	12	3	-	-	1
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	-	1	2	2	-	4	-	-	1	-
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	363	369	424	503	429	399	392	325	319	264
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	1	1	-	3	1
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	-	-	-	1	-	-	-	-	-
Авлигын гэмт хэрэг	-	-	-	2	1	-	2	-	-	-
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	-	-	1	1	-	-	11	-	-
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	4	-	10	10
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	10	-	4	3
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	1	-

Зураг 1.7.1 Гэмтсэн хүн, гэмтлийн зэргээр, хувиар, 2019-2020 он



2020 онд гэмт хэргийн улмаас гэмтсэн 8175 хүний 80.0 % нь хөнгөн, 13.5 % нь хүндэвтэр, 6.5 % нь хүнд гэмтэл авсан бөгөөд хөнгөн хэлбэрийн гэмтэл өмнөх оноос 0.6 хувиар, хүндэвтэр хэлбэрийн гэмтэл 0.1 хувиар буурч, харин хүнд хэлбэрийн гэмтэл 0.7 хувиар өссөн байна (Зураг 1.7.1).

### Хүснэгт 1.7.3 Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн, гэмт хэргийн төрлөөр, 2011-2020 он

Гэмт хэргийн төрлөөр	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>8 100</b>	<b>8 436</b>	<b>9 797</b>	<b>11 281</b>	<b>11 287</b>	<b>11 257</b>	<b>10 513</b>	<b>9 283</b>	<b>8 727</b>	<b>8 175</b>
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	18	30	32	30	29	16	37	34	23	29
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4 850	5 341	6 256	7 531	7 683	7 931	8 024	7 957	7 416	7 202
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	150	121	112	122	105	98	192	97	92	55
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1	-	-	2	2	1	2	3	2
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	46	58	81	103	103	87	21	-	-	-
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	265	258	276	295	240	253	230	94	36	25
Үндэсний аюулгүй байдалын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эдийн засгийн гэмт хэрэг	2	-	-	-	-	1	-	-	-	-
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1 611	1 479	1 685	1 649	1 656	1 551	801	44	27	22
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	-	1	2	6	-	1	2	-	-	-
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1 094	1 078	1 282	1 460	1 382	1 247	1 135	998	1 072	784
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	55	57	64	71	75	56	55	41	41	44
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4	5	1	8	8	6	6		1	4
Авлигын гэмт хэрэг	-	-	-	-	1	1	-	-	-	-
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	4	7	6	6	3	7	9	4	2	2
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	10	11	5
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	2	3	1

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын Хохирогч хүн, хуулийн этгээдийн мэдээлэл

2020 онд гэмт хэргийн улмаас гэмтсэн 8175 хүний 7202 (88.1%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас, 784 (9.6%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн байна (Хүснэгт 1.7.3).

2020 онд гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо өмнөх оноос 552-оор буурахад хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн 214 (2.9%)-өөр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн 288 (26.9%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 1.7.3).





# ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ

## 2.1 БҮХ ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд заасанчлан **Шүүх** гэдэг нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэрийг төрийн нэрийн өмнөөс гаргадаг **шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг** ойлгоно.

**“Дагнасан шүүх”** гэж Эрүү, Иргэн, Захиргааны хэргийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулагдсан шүүхийг ойлгоно. Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.

Бүх шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2020 онд 16.9 мянга болж, өмнөх оноос 470 (2.9%)-аар, иргэний хэрэг 58.2 мянга болж, 10.3 (21.5%) мянгаар өсөж, харин захиргааны хэрэг 3.8 мянга болж, 62 (1.6%)-оор буурсан байна. Бүх шатны шүүхийн эрүүгийн хэрэг өмнөх оноос 470-аар өсөхөд Төв аймаг 94 (23.9%), Баянхонгор аймаг 88 (28.2%), Улаанбаатар хот 79 (1.1%)-өөр өссөн нь голлон нөлөөлжээ. Бүх шатны шүүхийн иргэний хэрэг өмнөх оноос 10.3 мянгаар өсөхөд Улаанбаатар хотод 3368 (13.8%), Хөвсгөл аймаг 958 (73.6%), Баян-Өлгий аймаг 508 (63.5%), Говь-Алтай аймаг 458 (2.0 дахин) өссөн нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 2.1.1).


## Хүснэгт 2.1.1 Бүх шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Анхан шатны шүүх</b>										
Эрүүгийн хэрэг	5 877	6 161	6 169	6 375	6 756	5 762	8 839	12 551	13 427	13 470
Иргэний хэрэг	30 368	27 792	35 314	33 996	40 674	46 173	45 233	48 155	43 397	53 678
Захиргааны хэрэг	891	961	1 097	1 187	1 439	1 780	1 908	1 638	1 747	1 524
<b>Давж заалдах шатны шүүх</b>										
Эрүүгийн хэрэг	2 032	2 168	1 960	2 161	1 971	1 822	1 971	2 166	2 286	2 702
Иргэний хэрэг	1 803	1 634	1 806	1 947	2 519	3 108	3 721	3 562	3 144	3 394
Захиргааны хэрэг	362	517	598	883	1 049	1 460	1 668	1 340	1 416	1 476
<b>Хяналтын шатны шүүх</b>										
Эрүүгийн хэрэг	807	859	685	629	512	448	432	570	674	685
Иргэний хэрэг	1 089	778	983	1 017	1 376	1 655	1 829	2 074	1 332	1 104
Захиргааны хэрэг	382	220	268	381	421	548	716	655	608	709
<b>Улсын дүн</b>										
Эрүүгийн хэрэг	8 716	9 188	8 814	9 165	9 239	8 032	11 242	15 287	16 387	16 857
Иргэний хэрэг	33 260	30 204	38 103	36 960	44 569	50 936	50 783	53 791	47 873	58 176
Захиргааны хэрэг	1 635	1 698	1 963	2 451	2 909	3 788	4 292	3 633	3 771	3 709

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл

16, түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2020 онд улсын дунджаар 63 болж, өмнөх оны түвшинд байна. 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг Говьсүмбэр (86), Төв (78), Дорнод (73) аймгууд болон Улаанбаатар хотод (76) улсын дундажаас өндөр байна (Зураг 2.1.1).

Зураг 2.1.1 16, түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, аймаг, нийслэлээр, 2020 он




## 2.2 АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ

Анхан шатны шүүхээр 2020 онд 13.5 мянган эрүүгийн хэрэг, 53.7 мянган иргэний хэрэг, 1.5 мянган захиргааны хэрэг, 20.9 мянган зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэж, хариуцлага ногдуулсан бөгөөд эрүүгийн хэрэг өмнөх оноос 43 (0.3%), иргэний хэрэг 10.3 (23.7%) мянгаар, зөрчил 3.3 (18.5%) мянгаар өсөж, харин захиргааны хэрэг 223 (12.8%)-аар буурсан байна (Хүснэгт 2.2.1).

Хүснэгт 2.2.1 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Эрүүгийн хэрэг	5 877	6 161	6 169	6 375	6 756	5 762	8 839	12 551	13 427	13 470
Иргэний хэрэг	30 368	27 792	35 314	33 996	40 674	46 173	45 233	48 155	43 397	53 678
Захиргааны хэрэг	891	961	1 097	1 187	1 439	1 780	1 908	1 638	1 747	1 524

Зураг 2.2.1 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, бүсээр, 2019-2020 он



Улсын хэмжээгээр 2020 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн нийт 13470 гэмт хэргийн 2085 (15.5%) нь Төвийн бүсэд, 2006 (14.9 %) нь Хангайн бүсэд, 1022 (5.7%) нь Баруун бүсэд, 908 (6.1%) нь Зүүн бүсэд, 7449 (55.3%) нь нийслэлийнх байна. Анхан шатны шүүхийн эрүүгийн гэмт хэрэг өмнөх оноос 43-аар өсөхөд Хангайн бүсэд 107 (5.6%)-гоор, Улаанбаатар хотод 86 (1.2%)-гаар өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 2.2.1).

#### Хүснэгт 2.2.2 Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг, хэргийн хөдөлгөөнөөр, 2011-2020 он

Үзүүлэлт		2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Тайлант хугацааны үлдэгдэл	хэрэг	409	457	498	580	505	488	492	702	799	882
	хүн	710	732	800	1 077	864	831	837	1 077	1 124	1 292
Шинээр хүлээн авсан	хэрэг	6 367	6 608	6 750	7 023	7 493	6 537	9 920	13 505	14 417	14 694
	хүн	9 807	9 940	10 101	10 353	10 739	9 289	13 242	16 657	17 577	18 474
Шийдвэрлэвэл зохих хэрэг	хэрэг	6 776	7 065	7 248	7 603	7 998	7 025	10 412	14 207	15 216	15 576
	хүн	10 517	10 672	10 901	11 430	11 603	10 120	14 079	17 734	18 701	19 766
Прокурорт буцаасан	хэрэг	448	472	505	712	736	730	774	686	696	660
	хүн	825	851	1 014	1 430	1 326	1 368	1 305	1 188	1 208	1 211
Харьяаллын дагуу шилжүүлсэн	хэрэг	13	12	12	23	23	22	47	133	130	161
	хүн	23	20	27	41	45	42	149	310	252	371
Түдгэлзүүлсэн	хэрэг	-	-	-	-	-	-	11	35	76	150
	хүн	-	-	-	-	-	-	13	53	105	218
Хянан шийдвэрлэсэн	хэрэг	5 877	6 161	6 169	6 375	6 756	5 762	8 839	12 551	13 427	13 470
	хүн	8 967	9 065	8 923	9 146	9 417	7 835	11 478	15 093	15 921	16 227
Тайлант хугацааны үлдэгдэл	хэрэг	438	420	562	493	483	511	741	802	887	1 135
	хүн	702	736	937	813	815	875	1 147	1 143	1 320	1 739

Анхан шатны шүүх 2020 онд 19766 хүнд холбогдох, 15576 эрүүгийн хэрэг хүлээн авсны 16227 хүнд холбогдох 13470 (86.5%) хэргийг хянан шийдвэрлэж, 1211 хүнд холбогдох, 660 хэргийг прокурорт буцааж, 218 хүнд холбогдох 150 хэргийг түдгэлзүүлж, 371 хүнд холбогдох, 161 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 62 хүнд холбогдох 129 хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

2020 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 7449 (55.3%) нь Улаанбаатар хотынх байгаа нь өмнөх оноос 0.5 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 2.2.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, 2011-2020 он

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	19 197	22 089	25 362	27 318	27 757	27 167	32 259	36 220	31 524	23 064
Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг	тоо	5 877	6 161	6 169	6 375	6 756	5 762	8 839	12 551	13 427	13 470
	хувь	30.6	27.9	24.3	23.3	24.3	21.2	27.4	34.7	42.6	58.4

Улсын хэмжээгээр 2020 онд 23.1 мянган хэрэг бүртгэгдсэний 13.5 (58.4%) мянган хэрэгт МУ-ын Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, заалтын дагуу шүүхээс гэм буруутайг нь тогтоож ял шийтгэл оногдуулсан байна (Хүснэгт 2.2.3).

Анхан шатны шүүхээр 2020 онд шийдвэрлэсэн 13.5 мянган эрүүгийн хэргийн 6.8 (50.8%) мянга нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3.8 (28.0%) мянга нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 1.0 (7.7%) мянга нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн

ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байна. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 43-аар өсөхөд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 151 (50.0%), залилах гэмт хэрэг 106 (17.4%)-гаар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 228 (3.2%)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 111 (9.7%)-ээр, хулгайлах гэмт хэрэг 71 (4.2%)-ээр тус тус буурсан байна (Хүснэгт 2.2.4).

Хүснэгт 2.2.4 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, гэмт хэргийн төрлөөр, 2018-2020 он

Гэмт хэргийн төрлөөр	2018	2019	2020
<b>Шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг - Бүгд</b>	<b>12 551</b>	<b>13 427</b>	<b>13 470</b>
<b>Гэмт хэргийн төрлөөр</b>			
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	227	252	285
Хүнийг санаатай алах гэмт хэрэг	166	187	210
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг	53	58	61
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг	-	2	4
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	6 948	7 067	6 839
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	16	35	52
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	324	404	369
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	2	-
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	8	4	11
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	9	6	6
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	3 229	3 702	3 769
Хулгайлах	1 644	1 685	1 614
Дээрэмдэх	306	316	269
Залилах	465	608	714
Хөрөнгө завших	168	210	252
Мал хулгайлах	234	362	389
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	53	34	20
Эдийн засгийн гэмт хэрэг	70	68	48
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	189	213	249
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	260	302	453
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	1	2
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1 032	1 144	1 033
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	94	95	144
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	44	32	53
Авлигын гэмт хэрэг	34	50	118
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	10	7	8
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3	9	11

Хүснэгт 2.2.5 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар, 2019-2020 он

Он	Хянан шийдвэрлэсэн			Хялбаршуулсан журмаар			Ердийн журмаар			Эмнэлгийн чанартай албадлага	
	Хэрэг	Хүн	Хуулийн этгээд	Хэрэг	Хүн	Хуулийн этгээд	Хэрэг	Хүн	Хуулийн этгээд	Хэрэг	Хүн
2019	13 427	15 921	5	4 663	4 993	-	8 736	10 900	5	28	28
2020	13 470	16 227	7	4 390	4 820	2	9 061	11 334	4	19	20

Шүүхээр 2020 онд шийдвэрлэсэн 13.5 мянган эрүүгийн хэргийн 4.8 мянган хүнд холбогдох 4.4 (32.6%) мянган хэргийг хялбаршуулсан журмаар, 11.3 мянган хүнд холбогдох 9.1 (67.3%) мянган хэргийг ердийн журмаар, 20 хүнд холбогдох 19 (0.1%) хэрэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан байна (Хүснэгт 2.2.5).


### 2.3 ШҮҮХЭЭР ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ХҮН

Хүснэгт 2.3.1 Анхан шатны шүүхээр ял шийтгүүлсэн хүн, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Ял шийтгүүлсэн хүн	8 210	8 324	8 065	8 178	7 696	6 566	9 019	12 088	13 011	13 391
Урьд нь ял шийтгүүлсэн	1 460	1 544	1 698	1 919	1 900	1 773	1 977	2 542	2 990	3 577
Гэмт хэрэг давтан үйлдсэн	471	539	504	455	600	451	282	311	76	203
Бүлэглэн үйлдсэн	1 465	1 498	1 414	1 604	1 616	1 382	1 497	893	865	808
Согтуугаар үйлдсэн	1 704	1 717	1 710	1 582	1 700	1 729	2 250	2 928	2 592	3 123


Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 2020 онд 13391 болж, өмнөх оноос 380 (2.9%)-аар өсөхөд Улаанбаатар хот 352 (4.7%), Баянхонгор аймаг 101 (34.4%), Төв аймаг 98 (26.9%), Баян-Өлгий аймаг 54 (28.1%)-өөр өссөн нь голлон нөлөөлжээ. Ял шийтгүүлэгчдийн 1505 (11.2%) нь эмэгтэйчүүд, 228 (1.7%) нь өсвөр насны хүүхэд байна. Ял шийтгүүлэгчдийн 3577 (26.7%) нь урьд нь ял шийтгүүлж байсан, 203 (1.5%) нь давтан хэрэг үйлдсэн, 808 (6.0%) нь бүлэглэн үйлдсэн, 3123 (23.3%) нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна (Хүснэгт 2.3.1).

Зураг 2.3.1 Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, 2000-2020 он




2020 онд шүүхээр ял шийтгүүлсэн 13391 хүний 228 (1.7%)-ыг 14-17 насныхан эзэлж, өмнөх оноос 1.1 хувиар, 5034 (37.6%)-ийг 18-29 насныхан эзэлж, 4.2 хувиар, 2895 (21.6%)-ыг 30-34 насныхан эзэлж, 1.3 хувиар тус тус буурч, харин 35-аас дээш насныхан 5234 (39.1%)-ийг эзэлж, 6.6 хувиар өссөн байна. Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо өмнөх оноос 380-аар өсөхөд 35 ба түүнээс дээш насныхан 1009 (23.9%)-өөр өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 2.3.2).

Зураг 2.3.2 Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, насны бүлгээр, 2019-2020 он



2020 онд шүүхээр ял шийтгүүлсэн 13.4 мянган хүний 5.7 (42.4%) мянга нь бүрэн дунд боловсролтой, 2.3 (17.2 %) мянга нь суурь боловсролтой, 2.8 (21.1%) мянга нь дээд боловсролтой, 1.1 (8.2%) мянга нь бага боловсролтой, 777 (5.8%) нь боловсролгүй хүн байна. Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо өмнөх оноос 380-аар өсөхөд дээд боловсролтой 516-гаар, бүрэн дунд боловсролтой 221-ээр өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 2.3.3).

Зураг 2.3.3 Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Хүснэгт 2.3.2 Анхан шатны шүүхээр ял шийтгүүлсэн хүн, гэмт хэргийн төрлөөр,  
2018-2020 он

үзүүлэлт	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>12 088</b>	<b>13 011</b>	<b>13 391</b>
<b>Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг</b>	<b>192</b>	<b>210</b>	<b>236</b>
Хүнийг алах	170	190	209
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	-	2	2
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	17	17	21
<b>Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг</b>	<b>7 340</b>	<b>7 367</b>	<b>7 275</b>
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	371	331	375
<b>Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг</b>	<b>308</b>	<b>351</b>	<b>336</b>
Хүчиндэх	291	313	295
Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	16	33	32
<b>Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг</b>	<b>17</b>	<b>39</b>	<b>71</b>
Хүн худалдаалах	5	7	19
Хүн хулгайлах	2	2	7
<b>Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>
<b>Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>15</b>
<b>Хүүхдийн эсрэг гэмт хэрэг</b>	<b>2</b>	<b>7</b>	<b>9</b>
Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах	-	0	4
Хүүхэдтэй хэрцгий харьцах	2	1	1
Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах	-	4	3
Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх	-	0	0
Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх	-	1	0
<b>Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг</b>	<b>3 039</b>	<b>3 653</b>	<b>3 877</b>
Хулгайлах	1 542	1 691	1 637
Дээрэмдэх	360	393	303
Залилах	394	522	719
Хөрөнгө завших	106	139	188
Мал хулгайлах	193	354	470
<b>Эдийн засгийн гэмт хэрэг</b>	<b>75</b>	<b>89</b>	<b>80</b>
Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	71	73	38
Мөнгө угаах	3	7	28
<b>Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг</b>	<b>52</b>	<b>30</b>	<b>21</b>
<b>Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг</b>	<b>158</b>	<b>192</b>	<b>277</b>
Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших	2	5	10
Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	104	154	211
<b>Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг</b>	<b>50</b>	<b>47</b>	<b>60</b>
<b>Авлигын гэмт хэрэг</b>	<b>30</b>	<b>90</b>	<b>207</b>
Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	6	19	81
Хажууль өгөх	11	35	68
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	-	0	1
<b>Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг</b>	<b>79</b>	<b>62</b>	<b>115</b>
<b>Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг</b>	<b>189</b>	<b>210</b>	<b>271</b>
Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	32	29	53
Хууль бусаар ан агнах	18	15	38
<b>Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>2</b>
<b>Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>10</b>
<b>Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг</b>	<b>548</b>	<b>654</b>	<b>528</b>
Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	541	650	526
<b>Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>



Анхан шатны шүүхээр 2020 онд шийдвэрлэсэн 13.5 мянган эрүүгийн хэрэгт холбогдсон 13.4 мянган яллагдагчийн 7275 (54.8%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн яллагдагч, 3877 (29.0%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн яллагдагч, 528 (3.9%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн яллагдагч, 236 (1.8%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн яллагдагч, 336 (2.5%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн яллагдагч байна.

Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо өмнөх оноос 380-аар өсөхөд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн яллагдагч 224 (6.1%-өөр, Авлигын гэмт хэргийн яллагдагч 117 (30.0%)-гоор өссөн нь голлон нөлөөлжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн яллагдагч өмнөх оноос 224-өөр өсөхөд залилах гэмт хэргийн яллагдагч 197 (37.7%)-гоор, мал хулгайлах гэмт хэргийн яллагдагч 116 (32.8%)-гаар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин авлигын гэмт хэргийн яллагдагч өмнөх оноос 117-гоор өсөхөд эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн яллагдагч 62 (4.3 дахин)-оор, хахууль өгөх гэмт хэргийн яллагдагч 33 (94.3%)-аар өссөн голлон нөлөөлсөн байна (Хүснэгт 2.3.2).

2020 онд ял шийтгүүлсэн 13.4 мянган хүний 3657 хүнд хорих ял оногдуулсны 3522 (96.3%) нь хорих ялыг биечлэн эдэлж, 2333 нь хорих ялыг тэнсэж, 7646 нь торгох ял оногдуулж, 9.1 тэрбум төгрөгийн торгууль ноогдуулжээ. Хорих ял шийтгүүлсэн хүний тоо өмнөх оноос 157-гоор өсөхөд Улаанбаатар хотын хорих ял шийтгүүлсэн хүн 97 (4.8%)-гоор, Баянхонгор аймгийнх 52 (59.8%)-оор, Өвөрхангай аймгийнх 33 (52.4%)-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна (Хүснэгт 2.3.3).

#### Хүснэгт 2.3.3 Шүүхээс оногдуулсан ял, ялын төрлөөр, 2019-2020 он

Он	Нийт ял шийтгүүлсэн хүн	Торгох ял шийтгүүлсэн хүн	Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн хүн	Хорих ял шийтгүүлсэн хүн	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүн	Эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүн	Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх	Өршөөл үзүүлсэн
2019	13 011	7 532	1 965	3 522	124	28	2 187	8
2020	13 391	7 646	2 066	3 679	124	19	2 333	-

## 2.4 УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ, ХОХИРСОН ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД

#### Хүснэгт 2.4.1 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, тэрбум төгрөгөөр, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
	тэрбум.төг									
Учирсан хохирол	13.9	22.0	96.0	78.2	59.8	15.2	84.8	40.2	46.1	228.4
Нөхөн төлүүлэлт	1.7	2.1	90.8	1.5	1.3	1.1	2.9	22.3	32.0	29.9


Анхан шатны шүүхээр 2020 онд 13470 эрүүгийн хэрэгт холбогдох 228.4 тэрбум төгрөгийн хохирол учирч, 29.9 (13.1%) тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 228.4 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 29.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 182.3 (5.0 дахин) тэрбум төгрөгөөр өсөж, харин нөхөн төлүүлэлт 2.1 (6.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирол өмнөх оноос 182.3 тэрбум төгрөгөөр өсөхөд Улаанбаатар хотод 166.1 тэрбум төгрөгөөр, Дорноговь аймагт 10.3 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. 2020 онд учирсан нийт хохирлын 80.5

(35.2%) тэрбум төгрөг нь хувь хүнд, 147.8 (64.8%) тэрбум төгрөгийн хохирол нь хуулийн этгээдэд учирсан хохирол байна.


Анхан шатны шүүхээр 2020 онд шийдвэрлэгдсэн 13470 эрүүгийн гэмт хэргийн улмаас 30.3 мянган хүн хохирч өмнөх оноос 13763 (83.3%)-аар, 137 хуулийн этгээд хохирч, 38 (38.4%)-аар тус тус өсжээ. Хохирсон хүн өмнөх оноос 13763-аар өсөхөд Улаанбаатар хотын хохирсон хүн 13285 (2.4 дахин) өссөн нь голлон нөлөөлжээ. Нийт хохирсон хүний 7028 (23.2%) нь эмэгтэйчүүд, 757 (2.5%) нь 18, хүртэлх насны хүүхдүүд байна.

Зураг 2.4.1 Эрүүгийн гэмт хэргийн хохирогч хүн, насны бүлгээр, 2019-2020 он



Эрүүгийн гэмт хэргийн 30.3 мянган хохирогчийн 757 (2.5%) нь 0-17 насных, 2237 (7.4%) нь 18-24 насных, 3196 (10.6%) нь 25-29 насных, 3502 (11.6%) нь 30-34 насных, 3653 (12.1%) нь 35-39 насных, 3518 (11.6%) нь 40-44 насных, 3815 (12.6%) нь 45-49 насных, 2850 (9.4%) нь 50-54 насных, 6168 (20.4%) нь 55-59 насных, 587 (1.9%) нь 60, түүнээс дээш насныхан байна. Хохирогч өмнөх оноос 13763-аар өсөхөд 55-59 насныхан 5718 (13.7 дахин), 45-49 насныхан 2429 (2.8 дахин), 50-54 насныхан 1938 (3.1 дахин) өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 2.4.1). Нийт хохирсон хүний 22.8 (75.4%) мянга нь Улаанбаатар хотынх байна.

Зураг 2.4.2 Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, боловсролын түвшнээр, 2019-2020 он



Гэмт хэргийн хохирогч 30283 хүний 14460 (47.7%) нь бүрэн дунд боловсролтой, 9533 (31.5%) нь дээд боловсролтой, 1236 (4.1%) нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 786 (2.6%) нь боловсролгүй, 1383 (4.6%) бага боловсролтой, 2885 (9.5%) нь суурь боловсролтой хүн байна. Гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 13763-аар өсөхөд бүрэн дунд боловсролтой хохирогч 8175-аар, дээд боловсролтой хохирогч 4776-гаар өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 2.4.2).

#### Хүснэгт 2.4.2 Хохирсон хүн, гэмт хэргийн төрлөөр, 2018-2020 он

Үзүүлэлт	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>14 053</b>	<b>16 520</b>	<b>30 283</b>
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	217	267	278
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7 157	7 340	7 510
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	255	368	377
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	16	50	82
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	-	1	-
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	3	5	10
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	4	6	7
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	4 820	6 676	20 328
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4	9	-
Эдийн засгийн гэмт хэрэг	23	6	17
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	63	38	26
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	96	77	53
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын	1 292	1 568	1 425
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	77	63	105
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	11	7	8
Авлигын гэмт хэрэг	4	23	47
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	5	2	6
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	-	1
<u>Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг</u>	<u>6</u>	<u>14</u>	<u>3</u>

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөлийн анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн хохирогчийн тайлан

2020 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 30.3 мянган хохирогчийн 7510 (24.8%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 20328 (67.1%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 1425 (4.7%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч, 377 (1.2%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 278 (0.9%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч байна.

Хохирсон хүний тоо өмнөх оноос 13763-аар өсөхөд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч 13652 (3.0 дахин)-оор өссөн нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 2.4.2).

Эрүүгийн гэмт хэргийн улмаас 2020 онд хохирсон 30.3 мянган хүний 8676 (28.7%) нь гэмтэж, 619 (2.0%) нь нас барсан нь өмнөх оноос гэмтсэн хүн 79-өөр, нас барсан хүн 74-өөр тус тус өссөн байна. Гэмт хэргийн улмаас гэмтсэн 8676 хүний 280 (3.2%) нь өсвөр насны хүн, 2117 (24.4%) мянга нь эмэгтэйчүүд байна. Нас барсан 619 хүний 58 (9.4%) нь өсвөр насны хүн, 154 (24.9%) мянга нь эмэгтэйчүүд байна (Хүснэгт 2.4.3). Гэмт хэргийн улмаас хохирсон 30.3 мянган хүний 6693 (22.1%) нь ажилгүй хүн байна.

## Хүснэгт 2.4.3 Эрүүгийн гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүн, 2019-2020 он

Үзүүлэлт	Хохирсон нийт хүн		Гэмтсэн хүн		Нас барсан хүн	
	2019	2020	2019	2020	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>16 520</b>	<b>30 283</b>	<b>8 597</b>	<b>8 676</b>	<b>545</b>	<b>619</b>
Өсвөр насны хүн	965	757	387	280	58	58
Эмэгтэйчүүд	6 448	7 028	2 944	2 117	198	154

## Хүснэгт 2.4.4 Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүн, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Үзүүлэлт	2019		2020	
	Гэмтсэн хүн	Нас барсан хүн	Гэмтсэн хүн	Нас барсан хүн
<b>Улсын дүн</b>	<b>8 597</b>	<b>545</b>	<b>8 676</b>	<b>619</b>
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	45	246	17	266
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7 237	33	7 400	48
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	31	14	68	3
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	-	6	-
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	2	3	3	8
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1	-	1	-
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	18	-	6	-
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
Эдийн засгийн гэмт хэрэг	-	-	-	-
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	17	-	9	-
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1 221	248	1 140	289
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	21	1	22	5
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	-	1	-
Авлигын гэмт хэрэг	-	-	-	-
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	-	3	-
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-

2020 онд гэмт хэргийн улмаас гэмтсэн 8676 хүний 7400 (85.3%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас, 1140 (13.1%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн байна. 2020 онд эрүүгийн гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо өмнөх оноос 79-өөр өсөхөд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн 163 (2.3%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 2.4.4).


2020 онд гэмт хэргийн улмаас нас барсан 619 хүний 266 (43.0%) нь хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас, 289 (46.7%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн байна. 2020 онд эрүүгийн гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо өмнөх оноос 74-өөр өсөхөд хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан хүн 20-оор, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн 15-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн

ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан хүн 41-ээр өссөн нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 2.4.4).

## 2.5 АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ИРГЭНИЙ ХЭРЭГ

Иргэний хэргийн анхан шатны шүүх 2020 онд 74.7 мянган нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 11.3 мянган (15.1%) нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч, 53.7 (71.9 %) мянган иргэний хэргийг хянан шийдвэрлэжээ. Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг 53.7 мянга болж өмнөх оноос 10.3 (23.7%) мянгаар өсөхөд Улаанбаатар хотын иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг 3368 (13.8%)-аар, Хөвсгөл аймгийнх 958 (73.6%)-аар, Баян-Өлгий аймгийнх 508 (63.5%)-аар, Говь-Алтай аймгийнх 458 (2.0 дахин)-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 2.5.1 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг, 2011-2020 он



Хүснэгт 2.5.1 Анхан шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг, хуулиар, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>30 368</b>	<b>27 792</b>	<b>35 314</b>	<b>33 996</b>	<b>40 674</b>	<b>46 173</b>	<b>45 233</b>	<b>48 155</b>	<b>43 397</b>	<b>53 678</b>
Иргэний хуулиар	11 568	11 796	12 738	14 708	20 805	24 826	22 783	21 616	20 624	25 365
Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	11 152	9 262	15 571	12 421	11 532	11 942	13 600	18 318	14 654	19 237
Гэр бүлийн тухай хуулиар	4 449	3 878	4 276	4 207	4 539	4 674	4 566	4 763	4 449	4 732
Хөдөлмөрийн тухай хуулиар	897	742	1 080	1 377	1 487	2 220	2 214	1 785	1 302	1 173
Газрын тухай хуулиар	101	142	93	132	198	148	119	169	146	113
Дампуурлын тухай хуулиар	7	37	11	13	16	10	28	15	25	15
Компаны тухай хуулиар	24	16	18	8	18	32	21	35	24	22
Нийгмийн даатгалын багц хуулиар	128	97	148	326	436	476	403	332	334	315
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар	210	147	162	118	204	381	384	323	346	489
Татварын ерөнхий хуулиар	283	251	412	305	621	574	274	215	202	79
Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	5	2	6	4	0	1	1	1	3	6
Төрийн албаны тухай хуулиар	6	4	2	3	7	4	4	15	2	4
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд	70	73	52	55	44	45	17	32	627	919
Бусад хуулиар	1 468	1 345	678	319	767	840	819	536	659	1 209


Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг өмнөх оноос 10.3 (23.7%) мянгаар өсөхөд

Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэрэг 4583 (31.3%), Иргэний хуулиар шийдвэрлэсэн иргэний хэрэг 4741 (23.0%) -ээр өссөн нь голлон нөлөөлжээ.

Иргэний хэргийн анхан шатны шүүхээс энэ онд шийдвэрлэсэн 53.7 мянган хэргийн 27.8 (51.8%) мянган хэргийг Улаанбаатар хотын анхан шатны шүүх шийдвэрлэсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 4.4 хувиар буурсан байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхээр 2020 онд шийдвэрлэсэн 53.7 мянган иргэний хэргийн 30.7 (57.1%) мянган хэргийг ердийн журмаар, 15.7 (29.3%) мянган хэргийг хялбаршуулсан журмаар, 7.3 (13.6%) мянган хэргийг хэрэгсэхгүй болгосон бөгөөд ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 0.7 хувиар, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг 2.3 хувиар өсөж, харин хэрэгсэхгүй болгосон хэрэг 0.2 хувиар буурчээ (Зураг 2.5.2).

Зураг 2.5.2 Иргэний хэрэг, маргааныг шийдвэрлэсэн журмаар, 2019-2020 он



Хүснэгт 2.5.2 “Гэр бүлийн тухай” хуулиар шийдвэрлэсэн хэрэг, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>4 449</b>	<b>3 878</b>	<b>4 276</b>	<b>4 207</b>	<b>4 539</b>	<b>4 674</b>	<b>4 566</b>	<b>4 763</b>	<b>4 449</b>	<b>4 732</b>
Гэрлэлт цуцалсан	3 642	3 100	3 382	3 182	2 978	2 980	2 791	2 945	2 736	2 726
Эцэг тогтоосон	325	278	313	430	531	450	467	392	465	402
Эцэг, эх байх эрхээ хасуулсан	7	4	6	21	37	17	24	11	26	20
Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	364	370	454	478	825	1 006	1 056	1 146	1 047	1 333
Тэтгэлэг тогтоолгосон хүүхэд	1 932	786	998	1 843	1 932	1 060	877	985	2 167	703
Гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох	9	11	11	32	59	47	50	64	27	25
Бусад	102	115	110	64	109	174	178	205	148	226

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар 2020 онд 4732 хэрэг шийдвэрлэсний 2726 (57.6%) нь гэрлэлт цуцалсан, 402 (8.5%) нь эцэг тогтоосон, 1333 (28.2%) нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 20 (0.4%) нь эцэг, эх байх эрх хассан, 25 (0.5%) нь гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, 226 (4.8%) нь бусад хэрэг байна.

“Гэр бүлийн тухай” хуулийн дагуу анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 283 (6.4%)-аар өсөхөд хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан 286 (27.3%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан 286 (27.3%)-аар өссөн хэдий ч тэтгэлэг тогтоосон хүүхдийн тоо 1464-өөр буурсан байна (Хүснэгт 2.5.2).

Зураг 2.5.3 “Гэр бүлийн тухай” хуулиар шийдвэрлэсэн зарим хэрэг, 2011-2020 он



2020 онд хүүхдийн тэтгэлэг гаргуулах 1333 маргаан шийдвэрлэж, 703 хүүхэд тэтгэлэг тогтоолгосон нь өмнөх оноос хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргааны тоо 286 (27.3%)-гаар өсч, харин тэтгэлэг тогтоолгосон хүүхдийн тоо 1464 (67.6%)-өөр буурсан байна.

Хүснэгт 2.5.3 Шүүхээр шийдвэрлэсэн хөдөлмөрийн маргаан, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>897</b>	<b>742</b>	<b>1 080</b>	<b>1 377</b>	<b>1 487</b>	<b>2 220</b>	<b>2 214</b>	<b>1 785</b>	<b>1302</b>	<b>1 173</b>
Ажлаас буруу шилжүүлсэн	18	18	36	28	18	59	53	31	21	65
Ажлаас үндэслэлгүй халагдсан	534	459	725	742	910	1 213	1 432	943	658	613
Цалин хөлсний маргаан	247	196	206	475	415	653	565	637	496	386

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулиар 2020 онд 1173 хөдөлмөрийн маргаан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 129 (9.9%)-өөр буурсан байна. Хөдөлмөрийн маргаан өмнөх оноос 129-өөр буурахад цалин хөлсний маргаан 110 (22.2%)-аар, ажлаас үндэслэлгүй халагдсан 45 (6.8%) -аар буурсан нь голлон нөлөөлжээ. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулиар 2020 онд 1173 хөдөлмөрийн маргаан шийдвэрлэгдсэний 613 (52.3%) нь ажлаас үндэслэлгүй халагдсан, 386 (32.9%) нь цалин хөлсний маргаан, 65 (5.5%) нь ажлаас буруу шилжүүлсэн маргаан байна (Хүснэгт 3.5.3). Ажлаас буруу шилжүүлсэн маргаан өмнөх оноос 44 (3.1 дахин)-өөр өсөхөд Улаанбаатар хотод шийдвэрлэсэн ажлаас буруу шилжүүлсэн маргаан 44 (4.1 дахин) өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 2.5.4 Шүүхээр шийдвэрлэсэн хөдөлмөрийн маргаан, 2011-2020 он



2020 онд иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн 1173 хөдөлмөрийн маргааны 753 (64.2%) нь Улаанбаатар хотод шийдвэрлэсэн хөдөлмөрийн маргаан байна. Улаанбаатар хотод шийдвэрлэсэн хөдөлмөрийн маргаан 31 (4.0%)-ээр буурчээ.

## 2.6 АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

Хүснэгт 2.6.1 Анхан шатны шүүхийн захиргааны хэргийн хариуцагч, хэлбэрээр, 2017-2020 он

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>2 049</b>	<b>1 903</b>	<b>1 955</b>	<b>1 699</b>
Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага, албан тушаалтан	1 790	1 728	1 809	1 502
Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах бусад байгууллага	47	42	39	69
Захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд	7	6	4	8
Төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, эрчим хүч гэх зэрэг байгууллагын захиргаа	13	5	14	16
Нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь гомдол гаргахаар хуульд заасан байгууллага	170	119	87	99
Нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтан	22	3	2	5

2020 онд захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн 1524 хэргийн 1699 хариуцагч байгаа бөгөөд өмнөх оноос хариуцагчийн тоо 256 (13.1%) –гаар буурахад захиргааны хэргийг хариуцагч төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага, албан тушаалтны тоо 307 (17.0%)-гоор буурсан нь голлон нөлөөлсөн байна (Хүснэгт 2.6.1).



Хүснэгт 2.6.2 Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг ба нэхэмжлэл, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>891</b>	<b>961</b>	<b>1 097</b>	<b>1 187</b>	<b>1 439</b>	<b>1 780</b>	<b>1 908</b>	<b>1 638</b>	<b>1 747</b>	<b>1 524</b>
Ашигт малтмалтай холбоотой маргаан	86	119	72	43	96	142	172	154	128	109
Байгал орчныг хамгаалахтай холбоотой маргаан	1	4	3	2	2	3	-	3	17	2
Боловсролтой холбоотой маргаан	2	2	3	4	4	1	2	4	5	3
Газрын маргаан	228	210	280	386	338	419	372	416	329	347
Иргэний бүртгэлтэй холбоотой маргаан	27	18	13	28	16	30	29	22	35	26
Нийгмийн даатгалтай холбоотой маргаан	24	11	16	23	37	40	35	43	33	40
Оюуны өмчийн маргаан	6	1	3	4	6	2	3	-	-	-
Сонгуулийн маргаан	10	120	103	14	6	184	42	18	10	48
Татварын маргаан	76	73	65	81	128	127	77	59	90	53
Төрийн албаны маргаан	139	133	203	297	400	417	660	335	272	199
Төрийн болон орон нутгийн өмчийн маргаан	11	18	16	9	11	6	54	61	74	108
Төрийн хяналт, шалгалттай холбоотой бусад маргаан	54	42	46	81	83	75	52	62	142	121
Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад маргаан	19	7	2	15	15	10	18	34	15	31
Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой бусад маргаан	12	5	6	12	14	24	33	25	31	14
Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан	83	80	88	59	104	83	112	65	49	31
Бусад	113	118	178	129	179	217	247	337	517	392
<b>Нэхэмжлэгч-бүгд</b>	<b>1 045</b>	<b>1 001</b>	<b>1 150</b>	<b>1 398</b>	<b>1 651</b>	<b>2 041</b>	<b>2 340</b>	<b>2 085</b>	<b>1 919</b>	<b>1 617</b>
Иргэд	685	590	689	955	1 089	1 293	1 660	1 228	922	743
Хуулийн этгээд	360	411	461	443	562	748	604	648	744	712

Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2020 онд нийт 2299 нэхэмжлэл хүлээн авснаас 1524 (66.3%) хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 5.3 хувиар буурсан байна. Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2020 онд 1617 нэхэмжлэгчид холбогдох 1524 маргааныг шийдвэрлэсэн нь өмнөх оноос нэхэмжлэгчдийн тоо 302 (15.7%)-оор, хянан шийдвэрлэсэн маргааны тоо 223 (12.8%)-аар буурчээ. Анхан шатны шүүхийн захиргааны маргаан өмнөх 223-аар буурахад нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэсэн маргаан 179 (16.7%)-өөр буурсан нөлөөлжээ. Нийт 1617 нэхэмжлэлийн 743 (46.0%) нь иргэний нэхэмжлэл, 712 (44.0%) нь хуулийн этгээдийн нэхэмжлэл байна. Анхан шатны шүүхийн захиргааны маргаан өмнөх оноос 223-аар буурахад төрийн албаны маргаан 73 (26.8%), бусад маргаан 125 (24.2%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

## Хүснэгт 2.6.2 Анхан шатны шүүхийн захиргааны хэрэг, 2019-2020 он

Он	Шийдвэрлэ- вэл зохих хэрэг	Шийдвэр- лэсэн хэрэг	Хялбар- шуулсан журмаар	Ердийн журмаар	Хэрэгсэхгүй болгосон	Нэхэмж- лэгч	Хариу- цагч	Хохирол.сая төгрөг	
								Нэхэмжил- сэн	Шийдвэр- лэсэн
2019	2 464	1 747	448	1 124	175	1 919	1 966	5 563.2	3 276.9
2020	2 299	1 524	407	996	121	1 617	1 699	200 523.1	16 289.5

Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2020 онд 1917 нэхэмжлэгчээс 200.5 тэрбум төгрөгийн хохирлыг нэхэмжилж, харин шүүхээс 16.3 (8.1%) тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр 2020 онд шийдвэрлэсэн 1524 хэргийн 404 (26.7%) хэргийг хялбаршуулсан журмаар, 996 (65.4%) хэргийг ердийн журмаар шийдвэрлэж, харин 121 (7.9%) хэргийг хэрэгсэхгүй болгосон байна (Хүснэгт 2.6.2).

## 2.7 ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ


Давж заалдах шатны шүүхээр 2020 онд шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2702 болж, өмнөх оноос 416 (18.2%)-аар, иргэний хэрэг 3394 болж, 250 (8.0%)-аар, захиргааны хэрэг 1476 болж, 60 (4.2%)-аар өссөн байна (Хүснэгт 2.7.1).

## Хүснэгт 2.7.1 Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Эрүүгийн хэрэг	2 032	2 168	1 960	2 161	1 971	1 822	1 971	2 166	2 286	2 702
Иргэний хэрэг	1 803	1 634	1 806	1 947	2 519	3 108	3 721	3 562	3 144	3 394
Захиргааны хэрэг	362	517	598	883	1 049	1 460	1 668	1 340	1 416	1 476

Давж заалдах шатны эрүүгийн хэргийн шүүх 2020 онд 2702 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 416 (18.2%)-гаар өсөхөд дээрэмдэх хэрэг 62 (36.0%), бусад хэрэг 94 (37.0%), хүнийг алах 49 (39.5%), хөрөнгө завших 41 (2.5 дахин), мал хулгайлах 46 (64.8%)-гаар өссөн нь нөлөөлжээ (Хүснэгт 2.7.2).

## Зураг 2.7.1 Давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэрэг, шийдвэрлэлтээр, 2013-2020 он




Давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр тогтоолыг хэвээр үлдээсэн хэрэг өмнөх оноос 0.4 хувиар, тогтоолд өөрчлөлт оруулсан нь 0.6 хувиар буурч, харин тогтоолыг хүчингүй болгосон нь 1.0 хувиар өссөн байна (Зураг 2.7.1).

Хүснэгт 2.7.2 Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, гэмт хэргийн төрлөөр, 2019-2020 он

Үзүүлэлт	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>2 286</b>	<b>2 702</b>
Хүнийг алах	124	173
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	135	129
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	18	38
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	77	89
үний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	9	5
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	379	386
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	28	24
Хүчиндэх	197	235
Хүн худалдаалах	1	3
Хулгайлах	353	359
Дээрэмдэх	86	96
Залилах	172	234
Хөрөнгө завших	27	68
Мал хулгайлах	71	117
Татвар төлөхөөс зайлсхийх	0	2
Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	9	15
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	73	106
Хахууль авах	17	22
Хахууль өгөх	9	13
Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	247	240
Бусад	254	348

Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 386 (14.2%) нь хүний эрүүл мэндэнд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах гэмт хэрэг, 359 (13.3%) нь хулгайлах гэмт хэрэг, 240 (8.9%) нь авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг, 235 (8.7%) нь хүчиндэх гэмт хэрэг, 234 (8.7%) нь залилах гэмт хэрэг байна (Хүснэгт 2.7.2).

Зураг 2.7.2 Давж заалдах шатны шүүхээр тогтоолыг хүчингүй болгосон хэрэг, 2019-2020 он



2020 онд давж заалдах шатны шүүхээс шүүгчийн тогтоолыг хүчингүй болгосон 833 эрүүгийн хэргийн 811 (97.4%) хэргийн шүүгчийн тогтоолыг хүчингүй болгож, шүүхээр хэлэлцүүлэхээр буцааж, 22 (2.6%) хэргийн шүүгчийн тогтоолыг хүчингүй болгож, хэрэгсэхгүй болгосон бөгөөд шүүхээр хэлэлцүүлэхээр буцаасан хэрэг өмнөх оноос 0.6%-иар өсөж, харин хэрэгсэхгүй болгосон хэрэг 0.6%-иар буурсан байна (Зураг 2.7.2).

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2020 онд 3839 хэрэг хүлээн авч, 3394 (88.4%) хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 1.5 хувиар буурчээ (Хүснэгт 2.7.3).

Хүснэгт 2.7.3 Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг, 2013-2020 он

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Шийдвэрлэвэл зохих хэрэг	2 011	2 116	2 800	3 475	4 167	3 807	3 427	3 839
Шийдвэрлэсэн хэрэг	1 806	1 962	2 540	3 143	3 776	3 562	3 144	3 436
Хянан шийдвэрлэсэн хэрэг	1 837	1 947	2 519	3 108	3 721	3 527	3 082	3 394
Арбитрийн шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг хянан шийдвэрлэсэн	15	5	7	13	38	23	12	32
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	16	10	14	22	17	12	15	10
Давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзсан	36	46	69	54	70	72	106	76
Давж заалдах гомдлоосоо татгалзсан	36	13	40	44	39	38	29	33
Үлдэгдэл хэрэг	103	95	151	234	282	135	148	294

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөлийн Давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн мэдээ

Зураг 2.7.3 Давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн шийдвэрлэлт, 2013-2020 он



2020 онд иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн 3394 хэргийн 1529 (45.1%) хэргийн тогтоолыг хэвээр үлдээж, 1167 (34.4%) хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, 698 (20.6%) хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгожээ (Зураг 2.7.3).

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2020 онд 1488 хэрэг хүлээн авч, 1416 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 34 (2.5%)-өөр өссөн байна.

Хүснэгт 2.7.3 Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн захиргааны хэрэг, 2013-2020 он

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Шийдвэрлэвэл зохих хэрэг	660	933	1 126	1 555	1 750	1 458	1 488	1 567
Хянан шийдвэрлэсэн хэрэг	598	883	1 049	1 460	1 668	1 382	1 416	1 476
Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан	384	512	606	823	923	687	718	662
Анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан	185	343	416	573	649	594	591	686
Бусад	26	25	25	60	90	94	106	125
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	3	3	2	4	6	7	1	3
Үлдэгдэл хэрэг	62	50	77	95	82	76	72	91

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг 2020 онд 1476 болж, өмнөх оноос 60 (4.2%)-аар өсөхөд анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан хэрэг 95 (16.1%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Шийдвэрлэвэл зохих 1567 хэргийн 1476 (94.2%) хэргийг хянан шийдвэрлэжээ (Хүснэгт 2.7.3).


## 2.8 ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ

Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2020 онд 685 болж, өмнөх оноос 11 (1.6%)-ээр, захиргааны хэрэг 709 болж, 101 (16.6%)-ээр өсөж, харин иргэний хэрэг 1104 болж, 228 (17.1%)-аар буурсан байна. Хяналтын шатны шүүхийн эрүүгийн хэрэг 11-ээр өсөхөд Улаанбаатар хотод 23 (6.2%)-аар, Орхон аймагт 8 (53.3%)-аар, Булган аймагт 8 (88.9%)-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Хяналтын шатны шүүхийн захиргааны хэрэг 101-ээр өсөхөд Улаанбаатар хотод 117 (28.1%)-гоор өссөн нь голлон нөлөөлжээ. Хяналтын шатны шүүхийн иргэний хэрэг 228-аар буурахад Улаанбаатар хотод 135 (14.0%)-аар, Дархан-Уул аймагт 30 (46.2%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 2.8.1 Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, 2011-2020 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Эрүүгийн хэрэг	807	859	685	629	512	448	432	570	674	685
Иргэний хэрэг	1 089	778	983	1 017	1 376	1 655	1 829	2 074	1 332	1 104
Захиргааны хэрэг	382	220	268	381	421	548	716	655	608	709

Зураг 2.8.1 Хяналтын шатны шүүхийн эрүүгийн хэрэг, шийдвэрлэлтээр, 2019-2020 он



Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн 685 хэргийн 332 (48.5%) хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж, 152 (22.2%) хэргийн тогтоолд өөрчлөлт оруулж, 201 (29.3%) хэргийн тогтоолыг хүчингүй болгожээ (Зураг 2.8.1).

Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 11-ээр өсөхөд бусад хэрэг 30 (40.0%), залилах хэрэг 8 (12.9%), мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 8 (38.1%)-аар өссөн нь нөлөөлжээ (Хүснэгт 2.8.2).

Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 95 (13.9%) нь хүний эрүүл мэндэнд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах гэмт хэрэг, 105 (15.3%) нь бусад гэмт хэрэг, 70

(10.2%) нь залилах гэмт хэрэг, 65 (9.5%) нь хүчиндэх гэмт хэрэг, 63 (9.2%) нь хүнийг алах гэмт хэрэг, 57 (8.3%) нь хулгайлах гэмт хэрэг, 55 (8.0%) нь авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байна (Хүснэгт 2.8.2).

Хүснэгт 2.8.2 Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн гэмт хэрэг, 2019-2020 он

Үзүүлэлт	2019	2020
<b>Улсын дүн</b>	<b>674</b>	<b>685</b>
Хүнийг алах	70	63
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	44	38
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	4	2
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	16	20
үний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	3	1
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	100	95
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	6
Хүчиндэх	73	65
Хүн худалдаалах	1	4
Хулгайлах	90	57
Дээрэмдэх	18	19
Залилах	62	70
Хөрөнгө завших	13	16
Мал хулгайлах	11	17
Татвар төлөхөөс зайлсхийх	-	-
Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	4	7
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	21	29
Хахууль авах	6	9
Хахууль өгөх	3	7
Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	58	55
Бусад	75	105

## ДУГНЭЛТ

- Бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 онд 23.1 мянга болж, өмнөх оноос 8460 (26.8%)-аар буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 6280 (34.2%), хулгайлах гэмт хэрэг 3868 (43.1%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 860 (10.4%), мал хулгайлах гэмт хэрэг 768 (42.5%), дээрэмдэх гэмт хэрэг 464 (53.5%), залилах гэмт хэрэг 418 (8.9%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 291 (22.8%), хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 254 (39.9%), хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 217 (57.6%), хөрөнгө завших гэмт хэрэг 203 (33.8%), золгүй явдлаар нас барсан хэрэг 188 (57.5%), нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 130 (38.1%), эдийн засгийн гэмт хэрэг 124 (50.2%), хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 105 (17.2%), гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 96 (46.4%)-гаар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Харин хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 133 (27.2%), цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 89 (2.6 дахин), хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 74 (64.3%)-өөр тус тус өссөн байна.
- 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 онд улсын дунджаар 108 болж, өмнөх оноос 40 (27.0%)-аар буурахад Улаанбаатар хот 58 (28.0%), Хэнтий аймаг 61 (37.6%), Дорноговь аймаг 50 (42.7%), Дархан-Уул аймаг 35 (29.9%), Баянхонгор аймаг 31 (28.5%), Сэлэнгэ аймаг 31 (29.1%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Улсын дунджаар 16, түүнээс дээш насны 10 000 хүн тутамд 2020 онд 108 гэмт хэрэг бүртгэгдсэн бол шүүхээр 63 эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн байна. Улаанбаатар хотод 16, түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 149 болж, улсын дунжаас 41 (38.0%)-ээр их байна.
- Улсын хэмжээнд бүртгэгдсэн 23.1 мянган хэргийн 12.1 (52.3%) мянга нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг өмнөх оноос буурахад Улаанбаатар хот 4271 (33.8%), Хэнтий аймаг 303 (53.4%), Хөвсгөл аймаг 164 (42.8%), Дархан-Уул аймаг 159 (35.8%), Орхон аймаг 152 (37.5%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2020 онд 12061 бүртгэгдэж, өмнөх оноос 6280 (34.2%)-аар буурахад хулгайлах хэрэг 3868 (43.1%)-аар, мал хулгайлах гэмт хэрэг 768 (12.7%)-аар, дээрэмдэх гэмт хэрэг 464 (53.5%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.
- 2020 онд мал хулгайлах 1041 хэрэг бүртгэгдэж, өмнөх оноос 768 (42.5%)-аар буурахад Хэнтий аймаг 163 (56.8%), Төв аймаг 99 (49.8%), Дорнод аймаг 69 (51.9%), Булган аймаг 65 (55.6%), Улаанбаатар хот 65 (50.8%), Архангай аймаг 60 (37.0%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ.
- Залилах гэмт хэрэг 2020 онд 4270 бүртгэгдэж, өмнөх оноос 418 (8.9%)-аар, хөрөнгө завших хэрэг 398 бүртгэгдсэн нь өмнөх оноос 203 (33.8%)-аар буурахад Улаанбаатар хотод 238 (6.2%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Улаанбаатар хотод бүртгэгдсэн залилах гэмт хэрэг өмнөх оноос буурахад Сонгинохайрхан дүүрэгт 153 (32.2%)-аар, Хан-Уул дүүрэгт 143 (29.5%)-аар, Сүхбаатар дүүрэгт 127 (18.8%)-гоор, Чингэлтэй дүүрэгт 123 (22.0%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна.
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 12112 хохирогчийн 5141 (42.4%) нь хулгайлах гэмт хэргийн хохирогч, 407 (3.4%) нь дээрэмдэх гэмт хэргийн хохирогч, 4273 (35.3%) нь залилах гэмт хэргийн хохирогч, 392 (3.2%) нь хөрөнгө завших гэмт хэргийн хохирогч, 502 (4.1%) нь алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэргийн хохирогч, 92 (0.8%) авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах хэргийн хохирогч, 230 (1.9%) нь эд хөрөнгө устгах, гэмтээх хэргийн хохирогч, 10 (0.1%) болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах,



гэмтээх, үрэгдүүлэх хэргийн хохирогч, 1054 (8.7%) мал хулгайлах гэмт хэргийн хохирогч байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 6277-гоор буурахад хулгайлах гэмт хэргийн хохирогч 3863 (42.9%)-аар, мал хулгайлах гэмт хэргийн хохирогч 768 (42.2%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ.

- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 125.5 тэрбум төгрөг, хохирлын нөхөн төлүүлэлт 63.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 9.1 (6.8%) тэрбум төгрөгөөр буурч, харин нөхөн төлүүлсэн хохирол 38.1 (2.5 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирол өмнөх оноос 9.1 тэрбум төгрөгөөр буурахад хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирол 7.6 (40.5%) тэрбум төгрөгөөр, залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирол 23.8 (26.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.
- Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд зонхилох байр суурийг эзэлдэг мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 2020 онд 202-д хүрч, өмнөх оноос 55 (21.4%)–аар буурахад Улаанбаатар хотод 23 (11.4%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Улаанбаатар хотод бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг өмнөх оноос 23 (11.4%)-аар буурахад Чингэлтэй 13 (36.1%), Сүхбаатар 13 (38.2%), Баянгол дүүрэгт 10 (23.3%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ.
- Улсын хэмжээгээр 2020 онд бүртгэгдсэн 23.1 мянган хэргийн 985 (4.3%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2020 онд 985 болж, өмнөх оноос 291 (22.8%)-ээр буурахад Улаанбаатар хот 164 (27.6%), Төв аймаг 43 (36.8%), Өмнө-говь аймаг 22 (35.5%), Дорноговь аймаг 18 (40.9%)-аар буурсан голлон нөлөөлсөн байна. Харин Завхан аймагт өмнөх оноос 16 (3.0 дахин)-аар өсчээ.
- 2020 онд 21768 зам тээврийн осол бүртгэгдэж, өмнөх оноос 3534 (14.0%)-өөр буурахад Улаанбаатар хот 3361 (15.4%)-ээр, Ховд аймаг 52 (27.4%)-оор, Архангай аймаг 49 (32.7%)-өөр, Өвөрхангай аймаг 45 (29.4%)-аар, Дархан-Уул аймаг 44 (23.9%)-өөр, Дундговь 44 (37.0%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.
- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон 1081 хүний 437 (40.4%) эмэгтэй хүн, 127 (11.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна. Зам тээврийн ослын улмаас нас барсан 264 хүний 55 (20.8%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 82 (31.1%) нь эмэгтэй хүн байна. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүүхдийн тоо 55 болж, өмнөх оноос 6 (12.2%)-гаар өсөхөд Дорнод аймаг 4 (2.0 дахин), Сэлэнгэ аймаг 3 (2.5 дахин), Төв аймаг 3 (2.0 дахин)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон 406 хүний 398 (98.0%) нь эмэгтэй хүн, 248 (61.1%) нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хүн өмнөх оноос 86 (17.5%)-гаар буурахад 18-29 насныхан 31 (23.1%)-ээр, 30-39 насныхан 31 (54.4%)-ээр буурсан нь голлон нөлөөлжээ.
- Гэмт хэргийн улмаас 2020 онд 23.1 мянган хүн, 66 хуулийн этгээд хохирч, өмнөх оноос хохирсон хүний тоо 7732-оор, хохирсон хуулийн этгээдийн тоо 19-өөр буурчээ. Хохирсон хүний тоо өмнөх оноос 7732 (25.1%)-оор буурахад Улаанбаатар хот 5172 (26.3%)-оор, Хэнтий аймаг 296 (36.0%)-гаар, Дархан-Уул аймаг 283 (33.9%)-аар, Сэлэнгэ аймаг 208 (27.9%)-аар, Өвөрхангай аймаг 207 (33.5%)-гоор буурсан нь голлон нөлөөлжээ. Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 23.1 мянган хүний 1181 (5.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 9.4 (40.9%) мянга нь эмэгтэйчүүд байна.

- 2020 онд гэмт хэргийн улмаас хохирсон хүний 12112 (52.5%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 7798 (33.8%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 1081 (4.7%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч байна. Хохирсон хүн өмнөх оноос 7732-оор буурахад Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч 6277 (34.1%), Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч 744 (8.7%), Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч 369 (25.4%)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.
- Гэмт хэргийн улмаас хохирсон 23050 хүний 155 (0.7%) нь 7 хүртэлх насных, 1026 (4.5%) нь 8-17 насных, 5934 (25.7%) нь 18-29 насных, 7344 (31.9%) нь 30-39 насных, 4724 (20.5%) нь 40-49 насных, 3867 (16.8%) нь 50, түүнээс дээш насныхан байна. Хохирсон хүн өмнөх оноос 7732-оор буурахад 18-29 насныхан 2180 (26.9%), 30-39 насныхан 2111 (22.3%), 40-49 насныхан 1742 (26.9%), 50 түүнээс дээш насныхан 1282 (24.9%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ. 2020 онд гэмт хэргийн улмаас хохирсон нийт хүний 7039 (30.5%) ажилгүй хүн байгаа нь өмнөх оноос 1883-аар буурчээ.
- Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдын тоо 2020 онд 16.7 мянгад хүрч, өмнөх оноос 443 (2.6%)-аар буурахад Хэнтий аймаг 174 (28.0%)-өөр, Дархан-Уул аймаг 146 (23.7%)-гаар, Сэлэнгэ 132 (23.7%)-оор, Дорноговь 125 (32.8%)-аар, Орхон 90 (17.6%)-ээр өссөн нь голлон нөлөөлжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 990 (5.9%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 2907 (17.4%) нь эмэгтэйчүүд байна.
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 254.9 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 82.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 92.6 (57.1%) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 38.3 (87.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирол өмнөх оноос 92.6 тэрбум төгрөгөөр өсөхөд Улаанбаатар хотод гэмт хэргийн улмаас учирсан хохирол 100.5 тэрбум төгрөгөөр, Өмнөговь аймагт 897.3 тэрбум төгрөгөөр, Завхан аймагт 536.9 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Харин нөхөн төлүүлсэн хохирол өмнөх оноос 38.3 тэрбум төгрөгөөр өсөхөд Улаанбаатар хотод 43.4 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.
- 2020 онд гэмт хэргийн улмаас учирсан 254.9 тэрбум төгрөгийн хохирлын 125.5 (49.2%) тэрбум төгрөг нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн, 7.8 (3.1%) тэрбум төгрөг нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн, 5.0 (2.0%) тэрбум төгрөг нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн, 102.8 (40.3%) тэрбум төгрөг нь Эдийн засгийн гэмт хэргийн хохирол байна. Учирсан хохирол өмнөх оноос 92.6 тэрбум төгрөгөөр өсөхөд Эдийн засгийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол 97.3 тэрбум төгрөгөөр, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирол 3.8 тэр бум төгрөгөөр, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн хохирол 1.9 тэрбум төгрөгөөр, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1.8 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.
- Гэмт хэргийн улмаас 2020 онд 23050 хүн хохирсны 670 (2.9%) нь нас барж, 8175 (35.5%) нь гэмтсэн байна. Хохирсон хүн өмнөх оноос 7732 (25.1%)-оор, нас барсан хүн 260 (28.0%)-аар, гэмтсэн хүн 552 (6.3%)-оор тус тус буурчээ.

- Нас барсан хүн өмнөх оноос 260-аар буурахад Улаанбаатар хотод гэмт хэргийн улмаас нас барсан хүн 153 (35.0%)-аар, Төв аймагт нас барсан хүн 31 (43.1%)-ээр буурсан нь голлон нөлөөлжээ.
- Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо өмнөх оноос 552-оор буурахад Улаанбаатар хотод гэмт хэргээс гэмтсэн хүний тоо 278 (5.5%)-аар, Дорноговь аймагт 90 (40.5%)-ээр, Дархан-Уул аймагт 80 (26.8%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Гэмт хэргийн улмаас 2020 онд нас барсан 670 хүний 63 (9.4%) нь 7 хүртэлх насных, 36 (5.4%) нь 8-17 насных, 90 (13.4%) 18-29 насных, 131 (19.6%) нь 30-39 насных, 153 (22.8%) нь 40-49 насных, 126 (18.8%) нь 50-59 насных, 71 (10.6%) нь 60, ба түүнээс дээш насныхан байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэрэг 2020 онд 1138 болж, өмнөх оноос 153-аар өсөхөд Улаанбаатар хот (90), Хөвсгөл (33), Баянхонгор (27), Төв (22), Ховд (17), Сүхбаатар аймгуудад (16)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэргийн хохирогч 2020 онд 1082 болж, өмнөх оноос 188 (21.0%)-аар өсөхөд Улаанбаатар хотод өмнөх оноос 130 (29.7%)-аар, Ховд аймагт 3.7 дахин, Баянхонгорт 3.1 дахин, Хөвсгөлд 2.9 дахин, Сүхбаатарт 2.4 дахин, Өмнөговьд 90.9%, Төв аймагт 80.8%-аар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.
- Бүх шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2020 онд 16.9 мянга болж, өмнөх оноос 470 (2.9%)-аар, иргэний хэрэг 58.2 мянга болж, 10.3 (21.5%) мянгаар өсөж, харин захиргааны хэрэг 3.8 мянга болж, 62 (1.6%)-оор буурсан байна. Бүх шатны шүүхийн эрүүгийн хэрэг өмнөх оноос 470-аар өсөхөд Төв аймаг 94 (23.9%), Баянхонгор аймаг 88 (28.2%), Улаанбаатар хот 79 (1.1%)-өөр өссөн нь голлон нөлөөлжээ. Бүх шатны шүүхийн иргэний хэрэг өмнөх оноос 10.3 мянгаар өсөхөд Улаанбаатар хотод 3368 (13.8%), Хөвсгөл аймаг 958 (73.6%), Баян-Өлгий аймаг 508 (63.5%), Говь-Алтай аймаг 458 (2.0 дахин) өссөн нь голлон нөлөөлжээ.
- 16, түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2020 онд улсын дунджаар 63 болж, өмнөх оны түвшинд байна. 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг Говьсүмбэр (86), Төв (78), Дорнод (73) аймгууд болон Улаанбаатар хотод (76) улсын дундажаас өндөр байна.
- Улсын хэмжээгээр 2020 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн нийт 13470 гэмт хэргийн 2085 (15.5%) нь Төвийн бүсэд, 2006 (14.9 %) нь Хангайн бүсэд, 1022 (5.7%) нь Баруун бүсэд, 908 (6.1%) нь Зүүн бүсэд, 7449 (55.3%) нь нийслэлийнх байна. Анхан шатны шүүхийн эрүүгийн гэмт хэрэг өмнөх оноос 43-аар өсөхөд Хангайн бүсэд 107 (5.6%)-гоор, Улаанбаатар хотод 86 (1.2%)-гаар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Анхан шатны шүүхээр 2020 онд шийдвэрлэсэн 13.5 мянган эрүүгийн хэргийн 6.8 (50.8%) мянга нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3.8 (28.0%) мянга нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 1.0 (7.7%) мянга нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байна. Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 43-аар өсөхөд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 151 (50.0%), залилах гэмт хэрэг 106 (17.4%)-гаар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.
- Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 2020 онд 13391 болж, өмнөх оноос 380 (2.9%)-аар өсөхөд Улаанбаатар хот 352 (4.7%), Баянхонгор аймаг 101 (34.4%), Төв аймаг 98 (26.9%), Баян-Өлгий аймаг 54 (28.1%)-өөр өссөн нь голлон нөлөөлжээ. Ял шийтгүүлэгчдийн 1505 (11.2%) нь эмэгтэйчүүд, 228 (1.7%) нь өсвөр насны хүүхэд байна.

- Анхан шатны шүүхээр 2020 онд шийдвэрлэсэн 13.5 мянган эрүүгийн хэрэгт холбогдсон 13.4 мянган яллагдагчийн 7275 (54.8%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн яллагдагч, 3877 (29.0%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн яллагдагч, 528 (3.9%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн яллагдагч, 236 (1.8%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн яллагдагч, 336 (2.5%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн яллагдагч байна.
- Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо өмнөх оноос 380-аар өсөхөд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн яллагдагч 224 (6.1%-өөр, Авлигын гэмт хэргийн яллагдагч 117 (30.0%)-гоор өссөн нь голлон нөлөөлжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн яллагдагч өмнөх оноос 224-өөр өсөхөд залилах гэмт хэргийн яллагдагч 197 (37.7%)-гоор, мал хулгайлах гэмт хэргийн яллагдагч 116 (32.8%)-гаар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин авлигын гэмт хэргийн яллагдагч өмнөх оноос 117-гоор өсөхөд эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн яллагдагч 62 (4.3 дахин)-оор, хахууль өгөх гэмт хэргийн яллагдагч 33 (94.3%)-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна.
- 2020 онд ял шийтгүүлсэн 13.4 мянган хүний 3657 хүнд хорих ял оногдуулсны 3522 (96.3%) нь хорих ялыг биечлэн эдэлж, 2333 нь хорих ялыг тэнсэж, 7646 нь торгох ял оногдуулж, 9.1 тэрбум төгрөгийн торгууль ноогдуулжээ. Хорих ял шийтгүүлсэн хүний тоо өмнөх оноос 157-гоор өсөхөд Улаанбаатар хотын хорих ял шийтгүүлсэн хүн 97 (4.8%)-гоор, Баянхонгор аймгийнх 52 (59.8%)-оор, Өвөрхангай аймгийнх 33 (52.4%)-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна.
- Анхан шатны шүүхээр 2020 онд 13470 эрүүгийн хэрэгт холбогдох 228.4 тэрбум төгрөгийн хохирол учирч, 29.9 (13.1%) тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2020 онд 228.4 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 29.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 182.3 (5.0 дахин) тэрбум төгрөгөөр өсөж, харин нөхөн төлүүлэлт 2.1 (6.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирол өмнөх оноос 182.3 тэрбум төгрөгөөр өсөхөд Улаанбаатар хотод 166.1 тэрбум төгрөгөөр, Дорноговь аймагт 10.3 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. 2020 онд учирсан нийт хохирлын 80.5 (35.2%) тэрбум төгрөг нь хувь хүнд, 147.8 (64.8%) тэрбум төгрөгийн хохирол нь хуулийн этгээдэд учирсан хохирол байна.
- Анхан шатны шүүхээр 2020 онд шийдвэрлэгдсэн 13470 эрүүгийн гэмт хэргийн улмаас 30.3 мянган хүн хохирч өмнөх оноос 13763 (83.3%)-аар, 137 хуулийн этгээд хохирч, 38 (38.4%)-аар тус тус өсжээ. Хохирсон хүн өмнөх оноос 13763-аар өсөхөд Улаанбаатар хотын хохирсон хүн 13285 (2.4 дахин) өссөн нь голлон нөлөөлжээ. Нийт хохирсон хүний 7028 (23.2%) нь эмэгтэйчүүд, 757 (2.5%) нь 18, хүртэлх насны хүүхдүүд байна.
- Эрүүгийн гэмт хэргийн 30.3 мянган хохирогчийн 757 (2.5%) нь 0-17 насных, 2237 (7.4%) нь 18-24 насных, 3196 (10.6%) нь 25-29 насных, 3502 (11.6%) нь 30-34 насных, 3653 (12.1%) нь 35-39 насных, 3518 (11.6%) нь 40-44 насных, 3815 (12.6%) нь 45-49 насных, 2850 (9.4%) нь 50-54 насных, 6168 (20.4%) нь 55-59 насных, 587 (1.9%) нь 60, түүнээс дээш насныхан байна. Хохирогч өмнөх оноос 13763-аар өсөхөд 55-59 насныхан 5718 (13.7 дахин), 45-49 насныхан 2429 (2.8 дахин), 50-54 насныхан 1938 (3.1 дахин) өссөн нь голлон нөлөөлжээ. Нийт хохирсон хүний 22.8 (75.4%) мянга нь Улаанбаатар хотынх байна.
- 2020 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 30.3 мянган хохирогчийн 7510 (24.8%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч,

20328 (67.1%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 1425 (4.7%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч, 377 (1.2%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 278 (0.9%) нь Хүний амьд явэх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч байна. Хохирсон хүний тоо өмнөх оноос 13763-аар өсөхөд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч 13652 (3.0 дахин)-оор өссөн голлон нөлөөлжээ.

- Эрүүгийн гэмт хэргийн улмаас 2020 онд хохирсон 30.3 мянган хүний 8676 (28.7%) нь гэмтэж, 619 (2.0%) нь нас барсан нь өмнөх оноос гэмтсэн хүн 79-өөр, нас барсан хүн 74-өөр тус тус өссөн байна. Гэмт хэргийн улмаас гэмтсэн 8676 хүний 280 (3.2%) нь өсвөр насны хүн, 2117 (24.4%) мянга нь эмэгтэйчүүд байна. Нас барсан 619 хүний 58 (9.4%) нь өсвөр насны хүн, 154 (24.9%) мянга нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэргийн улмаас хохирсон 30.3 мянган хүний 6693 (22.1%) нь ажилгүй хүн байна.
- Иргэний хэргийн анхан шатны шүүх 2020 онд 74.7 мянган нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 11.3 мянган (15.1%) нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч, 53.7 (71.9 %) мянган иргэний хэргийг хянан шийдвэрлэжээ. Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг 53.7 мянга болж өмнөх оноос 10.3 (23.7%) мянгаар өсөхөд Улаанбаатар хотын иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг 3368 (13.8%)-аар, Хөвсгөл аймгийнх 958 (73.6%)-аар, Баян-Өлгий аймгийнх 508 (63.5%)-аар, Говь-Алтай аймгийнх 458 (2.0 дахин)-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна.
- Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг өмнөх оноос 10.3 (23.7%) мянгаар өсөхөд Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэрэг 4583 (31.3%), Иргэний хуулиар шийдвэрлэсэн иргэний хэрэг 4741 (23.0%)-ээр өссөн нь голлон нөлөөлжээ.
- Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар 2020 онд 4732 хэрэг шийдвэрлэсний 2726 (57.6%) нь гэрлэлт цуцалсан, 402 (8.5%) нь эцэг тогтоосон, 1333 (28.2%) нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 20 (0.4%) нь эцэг, эх байх эрх хассан, 25 (0.5%) нь гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, 226 (4.8%) нь бусад хэрэг байна. “Гэр бүлийн тухай” хуулийн дагуу анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 283 (6.4%)-аар өсөхөд хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан 286 (27.3%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан 286 (27.3%)-аар өссөн хэдий ч тэтгэлэг тогтоосон хүүхдийн тоо 1464 (67.6%)-өөр буурсан байна.
- Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулиар 2020 онд 1173 хөдөлмөрийн маргаан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 129 (9.9%)-өөр буурсан байна. Хөдөлмөрийн маргаан өмнөх оноос 129-өөр буурахад цалин хөлсний маргаан 110 (22.2%)-аар, ажлаас үндэслэлгүй халагдсан 45 (6.8%) -аар буурсан нь голлон нөлөөлжээ. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулиар 2020 онд 1173 хөдөлмөрийн маргаан шийдвэрлэгдсэний 613 (52.3%) нь ажлаас үндэслэлгүй халагдсан, 386 (32.9%) нь цалин хөлсний маргаан, 65 (5.5%) нь ажлаас буруу шилжүүлсэн маргаан байна. Ажлаас буруу шилжүүлсэн маргаан өмнөх оноос 44 (3.1 дахин)-өөр өсөхөд Улаанбаатар хотод шийдвэрлэсэн ажлаас буруу шилжүүлсэн маргаан 44 (4.1 дахин) өссөн нь голлон нөлөөлжээ.
- Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2020 онд нийт 2299 нэхэмжлэл хүлээн авснаас 1524 (66.3%) хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 5.3 хувиар буурсан байна. Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2020 онд 1617 нэхэмжлэгчид холбогдох 1524 маргааныг

шийдвэрлэсэн нь өмнөх оноос нэхэмжлэгчдийн тоо 302 (15.7%)-оор, хянан шийдвэрлэсэн маргааны тоо 223 (12.8%)-аар буурчээ. Анхан шатны шүүхийн захиргааны маргаан өмнөх 223-аар буурахад нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэсэн маргаан 179 (16.7%)-өөр буурсан нь нөлөөлжээ. Нийт 1617 нэхэмжлэлийн 743 (46.0%) нь иргэний нэхэмжлэл, 712 (44.0%) нь хуулийн этгээдийн нэхэмжлэл байна. Анхан шатны шүүхийн захиргааны маргаан өмнөх оноос 223-аар буурахад төрийн албаны маргаан 73 (26.8%), бусад маргаан 125 (24.2%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

- Давж заалдах шатны шүүхээр 2020 онд шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2702 болж, өмнөх оноос 416 (18.2%)-аар, иргэний хэрэг 3394 болж, 250 (8.0%)-аар, захиргааны хэрэг 1476 болж, 60 (4.2%)-аар өссөн байна. Давж заалдах шатны эрүүгийн хэргийн шүүх 2020 онд 2702 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 416 (18.2%)-гаар өсөхөд дээрэмдэх хэрэг 62 (36.0%), бусад хэрэг 94 (37.0%), хүнийг алах 49 (39.5%), хөрөнгө завших 41 (2.5 дахин), мал хулгайлах 46 (64.8%)-гаар өссөн нь нөлөөлжээ.
- Давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг 2020 онд 1476 болж, өмнөх оноос 60 (4.2%)-аар өсөхөд анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан хэрэг 95 (16.1%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2020 онд 3839 хэрэг хүлээн авч, 3394 (88.4%) хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 1.5 хувиар буурчээ.
- Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2020 онд 685 болж, өмнөх оноос 11 (1.6%)-ээр, захиргааны хэрэг 709 болж, захиргааны хэрэг 101 (16.6%)-ээр өсөж, харин иргэний хэрэг 1104 болж, 228 (17.1%)-аар буурсан байна. Хяналтын шатны шүүхийн эрүүгийн хэрэг 11-ээр өсөхөд Улаанбаатар хотод 23 (6.2%)-аар, Орхон аймагт 8 (53.3%)-аар, Булган аймагт 8 (88.9%)-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 11-ээр өсөхөд бусад хэрэг 30 (40.0%), залилах хэрэг 8 (12.9%), мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 8 (38.1%)-аар өссөн нь нөлөөлжээ.
- Хяналтын шатны шүүхийн захиргааны хэрэг өмнөх оноос 101-ээр өсөхөд Улаанбаатар хотод 117 (28.1%)-гоор өссөн нь голлон нөлөөлжээ.
- Хяналтын шатны шүүхийн иргэний хэрэг 228-аар буурахад Улаанбаатар хотод 135 (14.0%)-аар, Дархан-Уул аймагт 30 (46.2%)-аар буурсан нь голлон нөлөөлжээ.

..... о О о .....

## ХАВСРАЛТ

**ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ**

**Хүн:** Монголын Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно.

**Хуулийн этгээд:** Өмчлөлдөө буюу эзэмшиж, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудыг ойлгоно.

**Гэмт хэрэг:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

**16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэргийн түвшин:** 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн (шүүхээр шийдвэрлэсэн) гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн (шүүхээр шийдвэрлэсэн) гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

**Гэмт хэргийн хохирогч:** Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

**Гэмт хэргийн улмаас учирсан хохирол:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохирол гэж ойлгоно.

**Хохирлын нөхөн төлбөр:** Хохирлын нөхөн төлүүлэлт нь өргөн утгаараа хүний эрх, эрх чөлөөний хэр хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшинг аль болох өмнө байсан хэмжээнд нь сэргээхийг ойлгоно.

**Яллагдагч:** Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан гэмт хэрэгт холбогдогчийг ойлгоно.

**Гэмт хэргийн илрүүлэлт:** Хэрэг бүртгэлд бүртгэгдсэн нийт хэргээс мөрдөн байцаалтын явцад гэмт этгээдийг нь тогтоосон хэргийн түвшнээр тодорхойлогдоно.

**Ял:** МУ-ын Эрүүгийн хуулийн 5.2-т хуульчилсан торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих, эрх хасах ялыг ойлгоно.


**Зам тээврийн осол:** Зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь, нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч, гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг ойлгоно.

**Хөдөлмөрийн маргаан:** Хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлын хүрээнд ажиллагч болон ажил олгогчдын хооронд үүссэн саналын зөрүүг ойлгоно.

**Хүчирхийлэл:** Хэн нэг этгээд зорилгодоо хүрэхийн тулд эрх мэдлээ тогтоох зорилгоор бусдад албадлага, хүч хэрэглэх, дарамтлах үйлдлийг ойлгоно.

**Эс үйлдэхүй.** Иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан хугацаанд биелүүлээгүй буюу шийдвэрлээгүй орхигдуулсныг ойлгоно.

**ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, ТАРХААЛТ**



Манай орны хувьд гэмт хэргийн статистикийн мэдээллийн эх үүсвэр нь одоогоор Цагдаагийн ерөнхий газрын бүртгэгдсэн гэмт хэргийн сарын мэдээ, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн статистикийн жилийн мэдээ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын жилийн мэдээ, Авлигатай тэмцэх газрын авлигын статистикийн сарын мэдээ, Хуульчдын холбооны жилийн мэдээ байна. Эдгээр мэдээллийн эх үүсвэрт үндэслэж, бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, бүх шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо, шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо, шүүхээр шийдвэрлэсэн хөдөлмөрийн маргаан, шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ, авлигын хэргээс учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, хуульчдын тоо, хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн эрх зүйчдийн тоо, МХХ-нд шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл, хүсэлтийн тоо зэрэг 420 гаруй үзүүлэлтүүдийг сар, улирал, жилийн бюллетень, танилцуулга, эмхэтгэлд тусган нийтэд тархааж байна. Мөн хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын хууль зүй, гэмт хэргийн статистикийн гол гол үзүүлэлтүүдэд



үндэслэн салбарын танилцуулга бичин дэлгэрэнгүй мэдээллийг жил бүр нийтэд тархааж, ҮСХ-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn) сайтаар тархааж байна.

### ХУУЛИЙН ТАЙЛБАР:

Хууль зүйн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Их хурлаас Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталснаар өмнө мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл, заалтын нэршил, агуулга болон гэмт хэргийн төрөл, ангиллын хувьд өөрчлөгдсөн. Иймд өмнө мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн гэмт хэргийн төрлүүдийг шинэ хуулийн гэмт хэргийн төрлүүдтэй дараах байдлаар дүйцүүлэн динамикийг үүсгэн мэдээллийг нийтэд тархааж байна. Өмнөх гэмт хэргийн төрлүүдийг шинэ хуулийн гэмт хэргийн төрлүүдтэй дүйцүүлэхэд, ХЗДХЯ-ны Сургагч багш нарт зориулан 2017 онд гаргасан гарын авлагыг үндэс болгосон болно.

МУ-ын Эрүүгийн хууль, 2002 он	МУ-ын Эрүүгийн хууль, 2017 он
Бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	Эдийн засгийн гэмт хэрэг
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг
Компьютерын мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
Албан тушаалын гэмт хэрэг	Авлигын гэмт хэрэг
Завших, үрэгдүүлэх гэмт хэрэг	Хөрөнгө завших гэмт хэрэг